

САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОЙМ 2018 ОН



АГУУЛГА

I. ХУРААНГУЙ ТОЙМ	11
1.1. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ	12
1.2. ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ	13
1.3. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА	14
1.4. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО	16
1.5. ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН	17
II. САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ.....	19
2.1. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ.....	20
2.2. ХАА–Н ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ.....	24
2.3. ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ.....	25
2.4. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА.....	30
2.5. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО.....	35
2.6 ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН	40
III. ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ.....	43
3.1. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ	44
3.2. ХАА–Н ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ.....	46
3.3. ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ.....	47
3.4. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА	49
3.5. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО	53
3.6. ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН	57
IV. БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ	65
4.1. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ	66
4.2. ХАА–Н ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ.....	68
4.3. ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ.....	68
4.4. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА	72
4.5. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО	75
4.6. ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН	77
V. АШИГТ АЖИЛЛАГАА	81
5.1. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ	82
5.2. ХАА–Н ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ.....	84



5.3. ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ	84
5.4. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА	86
5.5. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО	88
5.6. ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН	90
VI. ТОГТВОРТОЙ БАЙДАЛ	93
6.1. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ	94
6.2. ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ	96
6.3. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА	101
6.4. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО	104
6.5. ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН	106
VII. БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН	109
7.1. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ	110
7.2. ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ	113
7.3. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА	115
7.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО	118
ХАВСРАЛТ	120

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1:	Үнэт цаасны компаниудын тоо болон хөрөнгийн хэмжээ /тэрбум төгрөгөөр/.....	21
Зураг 2:	Арилжааны гүйлгээний дүн, бүтээгдэхүүний ангиллаар /тэрбум төгрөгөөр/	22
Зураг 3:	Зах зээлийн үнэлгээ ба хөрвөх чадвар.....	22
Зураг 4:	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх зах зээлийн үнэлгээний хувь	23
Зураг 5:	ТОП–20 индекс	23
Зураг 6:	MSE A болон MSE B индекс	24
Зураг 7:	Хөдөө аж ахуйн биржийн арилжаа /тэрбум төгрөгөөр/	24
Зураг 8:	Хөдөө аж ахуйн гаралтай бараа бүтээгдэхүүний MAPIX индекс	25
Зураг 9:	Даатгалын зах зээлийн бүтэц	25
Зураг 10:	Даатгалын компаниудын зах зээлд эзлэх хувь	26
Зураг 11:	Даатгалын гүнзгийрэлтийн түвшин	27
Зураг 12:	Даатгалын салбарын нийт хөрөнгө.....	27
Зураг 13:	Даатгалын компанийн хөрөнгийн өсөлтийн тархалт	28
Зураг 14:	Даатгалын салбарын хураамжийн орлого.....	28
Зураг 15:	Нөхөн төлбөр, давхар даатгалын хураамжийн нийт хураамжийн орлогод эзлэх хувь	29
Зураг 16:	Нөөц сангийн хэмжээ, өсөлт	29
Зураг 17:	ББСБ–ын тоо болон харилцагчдын тоо	30
Зураг 18:	ББСБ–уудын байршил.....	30
Зураг 19:	ББСБ–уудын эзлэх хувь /хөрөнгө оруулалтын төрлөөр/	30
Зураг 20:	ББСБ–уудын ажиллагсдын тоо.....	31
Зураг 21:	ББСБ–уудын зээлдэгчдийн тоо /мянгаар/	31
Зураг 22:	ББСБ–ын салбарын нийт хөрөнгө ба өөрийн хөрөнгө /тэрбум төгрөгөөр/	32
Зураг 23:	ББСБ–уудын тоо /зах зээлд эзлэх хувиар/	32
Зураг 24:	ББСБ–ын салбарын нийт зээлийн өсөлт	33
Зураг 25:	ББСБ–ын салбарын нийт зээлийн төрөл /валютаар/.....	33
Зураг 26:	ББСБ–ын салбарын нийт зээлийн төрөл /чанараар/	33
Зураг 27:	ББСБ–ын салбарын нийт олгосон зээл, төлөгдсөн зээл /зориулалтаар/	34
Зураг 28:	ББСБ–ын салбарын зээлийн жигнэсэн дундаж сарын хүү	34
Зураг 29:	ББСБ–ын салбарын нийт зээлийн үлдэгдэл /хугацааны ангиллаар/.....	34
Зураг 30:	ХЗХ–дын тоо болон гишүүдийн тоо.....	35
Зураг 31:	ХЗХ–дын нийт хөрөнгө, өсөлт.....	36
Зураг 32:	ХЗХ–дын нийт хөрөнгөд эзлэх хувь /хөрөнгийн бүлгээр/	36
Зураг 33:	ХЗХ–дын нийт зээл, өсөлт	37
Зураг 34:	ХЗХ–ны салбарын зээлийн төрөл /чанараар/	37

Зураг 35:	ХЗХ–дын нийт хадгаламж, өсөлт.....	38
Зураг 36:	Нийт хадгаламжид эзлэх хувь /хадгаламжийн бүлгээр/.....	38
Зураг 37:	ХЗХ–дын зээл болон хадгаламжийн жигнэсэн дундаж хүү /улирлаар/.....	40
Зураг 38:	ЗБДС–ийн нийт хөрөнгийн хэмжээ /тэрбум төгрөгөөр/.....	40
Зураг 39:	Батлан даалтын үлдэгдэл.....	41
Зураг 40:	Тайлант хугацаанд шинээр олгосон батлан даалтын дүн.....	41
Зураг 41:	Олгосон батлан даалт /хэрэглэгчдийн төрлөөр/.....	41
Зураг 42:	Нэг батлан даалтын дундаж хэмжээ.....	41
Зураг 43:	Үнэт цаасны компаниудын тархалт /газар зүйн байршлаар/.....	44
Зураг 44:	Зах зээлийн үнэлгээ өндөр 10 ХК /салбараар/.....	44
Зураг 45:	Зах зээлийн үнэлгээ өндөр 10 ХК–ийн хувьцааны төвлөрөл.....	45
Зураг 46:	Шинээр нээгдсэн данс.....	46
Зураг 47:	Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/–дын байршлын тархалт /газар зүйн байршлаар/.....	47
Зураг 48:	Даатгалын нягтрал /төгрөгөөр/.....	47
Зураг 49:	Даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгчдийн салбар, төлөөлөгчийн газар /бүсээр/.....	48
Зураг 50:	Даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгчдийн салбаруудын байршил /дүүргээр/.....	48
Зураг 51:	ББСБ–уудын тархалт /газар зүйн байршлаар/.....	49
Зураг 52:	ББСБ–уудын тархалт /дүүргээр/.....	50
Зураг 53:	18–64 насны 100000 хүн ам болон 1000 ААН–д ногдох ББСБ–ын тоо /бүсээр/.....	50
Зураг 54:	Улаанбаатар хот дахь 18–64 насны 100000 хүн ам болон 1000 ААН–д ногдох ББСБ–ын тоо /дүүргээр/.....	51
Зураг 55:	ББСБ–уудын зээлийн дундаж хэмжээ ба 18–64 насны хүн ам болон зээлдэгчдийн тооны харьцаа, байршлаар /сая төгрөгөөр/.....	51
Зураг 56:	ББСБ–уудын харилцагчид /хүйсээр/.....	52
Зураг 57:	ББСБ–уудын зээлдэгчид /насны бүлгээр/.....	52
Зураг 58:	ББСБ–уудын зээлдэгчид /боловсролын бүлгээр/.....	52
Зураг 59:	Дижитал санхүүгийн үйлчилгээ хэрэглэгчид /хүйсээр/.....	53
Зураг 60:	Дижитал санхүүгийн үйлчилгээ хэрэглэгчид /зээлийн чанараар/.....	53
Зураг 61:	Дижитал санхүүгийн үйлчилгээ хэрэглэгчид /насны ангиллаар/.....	53
Зураг 62:	Дижитал санхүүгийн үйлчилгээ хэрэглэгчид /боловсролын түвшнээр/.....	53
Зураг 63:	ХЗХ–дын тархалт /газарзүйн байршлаар/.....	54
Зураг 64:	ХЗХ–дын тархалт /дүүргээр/.....	54
Зураг 65:	18–64 насны хүн амын тоонд нийт гишүүдийн эзлэх хувь /бүсээр/.....	55
Зураг 66:	100 ААН болон 10000 хүнд ногдох ХЗХ–ны тоо /бүсээр/.....	55
Зураг 67:	100 ААН болон 10000 хүнд ногдох ХЗХ–ны тоо /дүүргээр/.....	56

Зураг 68:	ХЗХ–дын зээлийн үйлчилгээний хүртээмж /байршлаар/.....	56
Зураг 69:	ХЗХ–дын хадгаламжийн үйлчилгээний хүртээмж /байршлаар/.....	57
Зураг 70:	ХЗХ–дын гишүүд /хүйсээр/.....	57
Зураг 71:	ХЗХ–дын гишүүд /насны бүтцээр/.....	57
Зураг 72:	Шинээр гаргасан батлан даалтын тоо /газар зүйн байршлаар/.....	58
Зураг 73:	Шинээр гаргасан батлан даалтын тоо /дүүргээр/.....	58
Зураг 74:	Олгосон батлан даалтын хэмжээ, бүсээр /тэрбум төгрөгөөр/.....	58
Зураг 75:	Олгосон батлан даалтын хэмжээ, дүүргээр /тэрбум төгрөгөөр/.....	59
Зураг 76:	Нэг батлан даалтын дундаж хэмжээ /дүүргээр/.....	59
Зураг 77:	Нэг батлан даалтын дундаж хэмжээ /бүсээр/.....	59
Зураг 78:	Нийт арилжааны бүтэц /бүтээгдэхүүнээр/.....	66
Зураг 79:	Хувьцааны арилжаа /тэрбум төгрөгөөр/.....	66
Зураг 80:	Засгийн газрын үнэт цаасны арилжаа /тэрбум төгрөгөөр/.....	66
Зураг 81:	Компанийн бондын арилжаа /тэрбум төгрөгөөр/.....	67
Зураг 82:	Хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хувь.....	67
Зураг 83:	Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн арилжаа /тэрбум төгрөгөөр/.....	68
Зураг 84:	Даатгалын хураамжийн орлого /бүтээгдэхүүнээр/.....	69
Зураг 85:	Даатгалын нөхөн төлбөрийн зардал /бүтээгдэхүүнээр/.....	69
Зураг 86:	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, хураамж, нөхөн төлбөр /тэрбум төгрөгөөр/.....	70
Зураг 87:	Зуучилсан даатгалын нийт хураамжийн орлого /бүтээгдэхүүнээр/.....	71
Зураг 88:	Зуучлалын шимтгэлийн орлого /бүтээгдэхүүнээр/.....	71
Зураг 89:	Даатгалын хохирлын тоо /бүтээгдэхүүнээр/.....	72
Зураг 90:	Даатгалын хохирол үнэлгээний орлого /бүтээгдэхүүнээр/.....	72
Зураг 91:	ББСБ–уудын тоо /үйлчилгээний төрлөөр/.....	73
Зураг 92:	ББСБ–ын салбарын нийт үйл ажиллагааны орлого /төрлөөр/.....	73
Зураг 93:	ББСБ–ын салбарын нийт хүүгийн бус орлого.....	73
Зураг 94:	Факторингийн үйлчилгээний цэвэр авлага /сая төгрөгөөр/.....	74
Зураг 95:	Итгэлцлийн үйлчилгээний өглөг /тэрбум төгрөгөөр/.....	74
Зураг 96:	Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг /сая төгрөгөөр/.....	74
Зураг 97:	Гадаад валют арилжааны худалдаж авсан, худалдсан дүн /тэрбум төгрөгөөр/.....	75
Зураг 98:	ХЗХ–ны салбарын хүүгийн орлогын бүтэц /хувиар/.....	76
Зураг 99:	ХЗХ–ны салбарын хүүгийн зардлын бүтэц /хувиар/.....	76
Зураг 100:	Батлан даалт гаргуулахаар ирүүлсэн хүсэлтийн тоо.....	77
Зураг 101:	Шинээр гаргасан батлан даалт /эдийн засгийн салбараар/.....	78
Зураг 102:	Батлан даалт гаргах дундаж хугацаа.....	78
Зураг 103:	Шинээр гаргасан батлан даалт /арилжааны банкаар/.....	79

Зураг 104: Үнэт цаасны компаниудын орлогын болон балансын тайлангийн үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/	82
Зураг 105: Үнэт цаасны компаниудын орлогын бүтэц	82
Зураг 106: Үнэт цаасны компаниудын зардлын бүтэц.....	83
Зураг 107: Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-дын тайлангийн үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/	84
Зураг 108: Даатгалын салбарын татварын дараах цэвэр ашиг	85
Зураг 109: Цэвэр ахиуц ашиг, хосолсон харьцаа	85
Зураг 110: Нийт хөрөнгө, өөрийн хөрөнгийн өгөөж	86
Зураг 111: ББСБ-уудын орлого, зарлага, ашгийн динамик /тэрбум төгрөгөөр/	86
Зураг 112: ББСБ-ын салбарын нийт болон өөрийн хөрөнгийн өгөөж	87
Зураг 113: ББСБ-уудын ангилал /нийт хөрөнгийн өгөөжөөр/.....	87
Зураг 114: ББСБ-уудын ангилал /өөрийн хөрөнгийн өгөөжөөр/	87
Зураг 115: ББСБ-уудын хөрөнгийн өгөөжийн медиан утга /хувь нийлүүлсэн хөрөнгөөр/	87
Зураг 116: Банк бус санхүүгийн байгууллагуудын зардал, орлогын харьцаа	88
Зураг 117: ХЗХ-дын орлого ба зардал /тэрбум төгрөгөөр/	88
Зураг 118: ХЗХ-дын ашигт ажиллагааны өсөлт /хувиар/.....	89
Зураг 119: ХЗХ-ны салбарын нийт болон өөрийн хөрөнгийн өгөөж /хувиар/.....	89
Зураг 120: ХЗХ-ны салбарын хүүгийн орлогын хувь болон цэвэр ахиуц ашгийн харьцаа /хувиар/	90
Зураг 121: ХЗХ-дын зардал, орлогын харьцаа.....	90
Зураг 122: Ашигт ажиллагаа /тэрбум төгрөгөөр/	91
Зураг 123: Нийт хөрөнгийн өгөөж	91
Зураг 124: IPO түүхэн замнал.....	94
Зураг 125: FPO түүхэн замнал.....	94
Зураг 126: Хувьцааны үнийн хэлбэлзэл	95
Зураг 127: Даатгалын компаниудын зах зээлд эзлэх хувь	96
Зураг 128: Даатгалын салбарт түгээмэл тулгардаг эрсдэлүүд /эрсдэлийн төрлөөр/	97
Зураг 129: Даатгалын салбарын эрсдэлийн түвшин /эрсдэлийн төрлөөр/	97
Зураг 130: Даатгалын компаниудын эрсдэлийн ойлголтын түвшин /эрсдэл тус бүрээр/	98
Зураг 131: Эрсдэлийн үйл ажиллагаанд зарцуулж буй хүн цаг	99
Зураг 132: Давхар даатгалын хураамж, ам.долларын ханш /улирлын дүнгээр/	100
Зураг 133: Даатгалын нийт хөрөнгө оруулалт ба хадгаламжийн жигнэсэн дундаж хүү.....	101
Зураг 134: ББСБ-ын салбарын хөрөнгийн хүрэлцээт байдлын харьцаа	102
Зураг 135: ББСБ-ын салбарын зээлийн эрсдэлийн сангийн харьцаа.....	102
Зураг 136: ББСБ-ын салбарын чанаргүй зээлийн хувь.....	103
Зураг 137: ББСБ-ын салбарын хөрвөх чадварын харьцаа.....	103

Зураг 138: ББСБ–ын салбарын Z индекс.....	104
Зураг 139: ХЗХ–дын нийт зээл ба чанаргүй зээл /тэрбум төгрөгөөр/.....	104
Зураг 140: ХЗХ–дын чанаргүй зээлийн үзүүлэлт /эзлэх хувиар/.....	105
Зураг 141: ХЗХ–ны салбарын зээлийн эрсдэлийн сангийн нийт хөрөнгө болон нийт зээлд эзлэх хувь.....	105
Зураг 142: ХЗХ–ны салбарын хөрвөх чадварын харьцаа.....	106
Зураг 143: Чанаргүй батлан даалтын хувь.....	106
Зураг 144: Чанаргүй батлан даалт /эдийн засгийн салбараар/.....	106

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1: Үнэт цаасны зах зээл дэх зохицуулалттай этгээдийн тоо /үйл ажиллагааны чиглэлээр/.....	20
Хүснэгт 2: ББСБ–уудын актив болон пассивын бүтэц /тэрбум төгрөгөөр/.....	31
Хүснэгт 3: ХЗХ–дын тоо, гишүүдийн үзүүлэлт /хүйс, байршлаар/.....	35
Хүснэгт 4: ХЗХ–дын нэг гишүүнд ногдох хадгаламжийн хэмжээ /бүсээр/.....	39
Хүснэгт 5: ХЗХ–дын актив ба пассивын ерөнхий үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/.....	39
Хүснэгт 6: Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд бүртгэлтэй хувьцаа /мянган ширхгээр/.....	45
Хүснэгт 7: Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд бүртгэлтэй бонд /мянган ширхгээр/.....	46
Хүснэгт 8: ХЗХ–дын тархалт /бүсээр/.....	54
Хүснэгт 9: Үнэт цаас гаргагчийн өмчийн бүтэц.....	68
Хүснэгт 10: ХЗХ–дын тоо /үйл ажиллагааны төрлөөр/.....	75
Хүснэгт 11: Үнэт цаасны компаниудын орлогын хураангуй тайлан /тэрбум төгрөгөөр/.....	83
Хүснэгт 12: Хөрөнгийн зах зээлийн хөгжлийн үзүүлэлтүүдийг харьцуулсан нь.....	95
Хүснэгт 13: Даатгалын компанийн хураамжийн орлогын хэмжээ.....	96

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ



Хавсралт 1: Хөрөнгийн зах зээлийн статистик үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/.....	120
Хавсралт 2: Даатгалын зах зээлийн статистик үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/.....	120
Хавсралт 3: Банк бус санхүүгийн байгууллагуудын стистик үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/.....	121
Хавсралт 4: Хадгаламж, зээлийн хоршоодын статистик үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/.....	122

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААН	Аж ахуйн нэгж
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗБДС	Зээлийн батлан даалтын сан
ЗГҮЦ	Засгийн газрын үнэт цаас
ЗЗҮ	Зах зээлийн үнэлгээ
МИК	Монголын ипотекийн корпораци
МХБ	Монголын хөрөнгийн бирж
ПОС	Карт уншигч төхөөрөмж
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
ҮЦК	Үнэт цаасны компани
ҮЦТХТ	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
ХАА	Хөдөө аж ахуй
ХААДД	Хөдөө аж ахуйн давхар даатгал
ХЗХ	Хадгаламж, зээлийн хоршоо
ХНХ	Хувь нийлүүлсэн хөрөнгө
ХК	Хувьцаат компани
ХОМК	Хөрөнгө оруулалтын менежментийн компани
ХОС	Хөрөнгө оруулалтын сан
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
МАРІХ	Монголын хөдөө аж ахуйн барааны үнийн индекс
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
АFI	Alliance for Financial Inclusion /Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг/
АТМ	Automated teller machine /Автомат теллер машин/
IAIS	International Association of Insurance Supervisors /Олон улсын даатгалын зохицуулагчдын холбоо/
ІPO	Initial public offering /Олон нийтэд хувьцаагаа санал болгох/
FPO	Follow up on public offering /Нэмэлт хувьцаа гаргах/
OECD	The Organisation for Economic Co-operation and Development /Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага/








ХУРААНГУЙ ТОЙМ



ХУРААНГУЙ ТОЙМ 2018



1.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Санхүүгийн зохицуулах хорооны үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой болон хувийн нийт 305 хувьцаат компани бүртгэлтэй байгаа бөгөөд 2018 оны жилийн эцсийн байдлаар 54 үнэт цаасны компани Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулж байна.

Жилийн эцсийн байдлаар Монгол Улсын үнэт цаасны зах зээлийн нийт үнэлгээ 2,511.8 тэрбум төгрөгт хүрчээ. ЗЗҮ–г өнгөрсөн онтой харьцуулахад 2.9 хувиар өсөж, 2018 оны жилийн эцсийн ДНБ–ий дүнд харьцуулахад 7.8 хувьтай тэнцсэн бөгөөд нийт ЗЗҮ–ний 91.6 хувийг 30 компанийн үнэлгээ бүрдүүлжээ. Түүнчлэн ТОП–20 индекс өмнөх оны байдлаас 3.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2018 оны байдлаар “Монголын хөрөнгийн бирж” ХК болон “Монголын үнэт цаасны бирж” ХК–аар дамжуулан нийт 245.5 тэрбум төгрөгийн арилжаа хийгдлээ. Нийт арилжааны дүнг задлан авч үзвэл, МХБ–ийн анхдагч зах зээлийн арилжаагаар нийт 31.4 тэрбум төгрөгийн хувьцаа, хоёрдогч зах зээлийн арилжаагаар 178.6 тэрбум төгрөгийн хувьцаа, ЗЗҮ–ийн анхдагч зах зээлийн арилжаагаар 1.0 тэрбум төгрөгийн компанийн бонд, МҮЦБ–ийн анхдагч зах зээлийн арилжаагаар 66.0 сая төгрөгийн компанийн бонд, хоёрдогч зах зээлийн арилжаагаар 292.1 сая төгрөгийн хувьцааг тус тус арилжаалав.

Оны онцлох үйл явдлаас дурдвал Хорооноос нийт 6 компанид анхдагч зах зээлд хувьцаагаа санал болгох (IPO) зөвшөөрөл олгосон нь түүхэн дээд амжилт болсон ба Монголын анхдагч хувийн бирж болох “Монголын үнэт цаасны бирж” ХК–ийн хамгийн анхны компанийн бондын арилжаа явагдлаа.



1.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Тухайн зах зээлийн хэмжээг илэрхийлэх гол үзүүлэлтүүдийн нэг болох нийт хөрөнгийн хэмжээ даатгалын салбарын хувьд тайлант онд өмнөх улирлаас 1.3 хувиар, өмнөх оноос 35.6 хувиар тус тус өсөж 331.9 тэрбум төгрөгт хүрсэн. Даатгалын салбарт давхар даатгалын нэг компани нэмэгдсэнтэй холбоотойгоор даатгалын салбарын хөрөнгийн бүтцэд өөрчлөлт гарсан ба давхар даатгалын нийт хөрөнгийн салбарын үзүүлэлтэд эзлэх хувь хэмжээ өнгөрсөн онд 17.7 хувь байсан бол тайлант оны байдлаар 21.2 хувь болж өслөө. Салбарын нийт хөрөнгийн 76.2 хувийг ердийн даатгалын компаниудын хөрөнгө, 2.7 хувийг давхар даатгалын компанийн хөрөнгө тус тус эзэлж байна.

Харин нийт хураамжийн орлого өмнөх улирлаас 41.4 хувиар, өмнөх оноос 23.8 хувиар өсөж 178.7 тэрбум төгрөг болов. Энэхүү өсөлтийн 99 хувийг ердийн даатгалын компаниудын нийт хураамжийн орлогын өсөлт бүрдүүлэв. Хураамжийн орлогын төвлөрүүлэлтийг авч үзвэл даатгалын зуучлагчид 39.8 тэрбум төгрөг буюу 22.3 хувийг, даатгалын төлөөлөгчид 36.9 тэрбум төгрөг буюу 20.6 хувийг бүрдүүлсэн байна.

Даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн зардал тайлант онд 58.2 тэрбум төгрөгт хүрч, нийт хураамжийн орлогын 32.6 хувийг эзлэв. Өнгөрсөн онтой харьцуулахад нөхөн төлбөрийн зардал 28.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс ердийн даатгалын компаниудын нөхөн төлбөр 98.1 хувийг бүрдүүлж байна.

Даатгалын компаниуд өөрийн хүлээж авсан эрсдэлээ шилжүүлэх зорилгоор давхар даатгалын компанид даатгуулдаг. Манай орны хувьд дийлэнх даатгалын компаниуд гадны давхар даатгалын компанид эрсдэлээ даатгадаг ба тайлант онд даатгалын компаниуд нийт 55.3 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамжийн зардалтай ажилласан нь өмнөх оноос 18.7 хувиар өссөн үзүүлэлт бөгөөд нийт хураамжийн орлоготой харьцуулахад 31 хувь байна.

Тайлант онд даатгалын компаниудын цэвэр ашиг өмнөх онтой харьцуулахад 39.7 хувиар өсөж 18.4 тэрбум төгрөг болсон байна. Салбарын өөрийн хөрөнгийн өгөөж 13 хувь, нийт хөрөнгийн өгөөж 5.6 хувь байна.



1.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

2018 оны жилийн эцсийн байдлаар санхүүгийн зах зээлд нийт 539 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасны дагуу Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй банк бус санхүүгийн байгууллагууд нь нийт 10 төрлийн үйлчилгээг тусгай зөвшөөрлийн дагуу эрхлэх боломжтой байдаг. Үүнээс тайлант онд нийт байгууллагуудын дийлэнх нь буюу 91.3 хувь нь зээлийн үйл ажиллагааг дагнан болон хавсран эрхэлж, 8.7 хувь нь зөвхөн гадаад валют арилжааны үйлчилгээг эрхэлж байна.

Санхүүгийн байгууллагуудын чадавх, хэмжээг илэрхийлэгч хамгийн чухал үзүүлэлтүүдийн нэг болох нийт хөрөнгийн хэмжээ жилийн эцсийн байдлаар 1.3 их наяд төгрөг байна. Энэхүү үзүүлэлт нь өмнөх оноос 32.6 хувиар өссөн дүн бөгөөд банк бус санхүүгийн байгууллагуудын нийт хөрөнгө 2018 оны туршид гучаас дээш хувийн өсөлтийг үзүүллээ. Активын бүтцээс харвал салбарын хөрөнгийн өсөлтийн 73.2 хувийг зээлийн өсөлт, пассивын бүтцээс харвал 66.3 хувийг хувь нийлүүлсэн хөрөнгийн өсөлт тус тус бүрдүүлж байна.

2018 онд банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн нийт үлдэгдэл өмнөх оноос 36.2 хувиар өсөж, 869.2 тэрбум төгрөгт хүрлээ. Нийт зээлийн үлдэгдлийн 81.9 хувийг иргэдийн зээл, 18.1 хувийг хуулийн этгээдийн зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Зээлийн чанараар ангилан харвал 86.6 хувийг хэвийн зээл, 3.9 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 9.5 хувийг чанаргүй зээл тус тус эзэлж байна. 2017 онд салбарын чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 12.7 байсан бол тайлант онд уг үзүүлэлт 3.2 нэгжээр буурч, зээлийн чанар сайжирсан байна.

Мөн салбарын зээлийн нийлүүлэлт нэмэгдсэнтэй холбоотойгоор банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн үйлчилгээний хүртээмж сайжирсан бөгөөд салбарын зээлдэгчдийн тоо өмнөх оноос 2.2 дахин нэмэгдэж 234.1 мянга хүрсэн бол нийт харилцагчдын тоо өмнөх оноос 1.1 дахин нэмэгдэж 1.6 саяд хүрсэн байна. Зээлийн үйлчилгээний хүртээмжийн уг өндөр өсөлт нь зээлийн нийлүүлэлтээс гадна технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ зах зээлд нэвтэрч эхэлсэнтэй холбоотой юм. Харин зээлийн бүтээгдэхүүний үнэ болох сарын жигнэсэн дундаж хүүгийн түвшин 2018 оны жилийн эцсийн байдлаар 3.2 хувьтай байгаа бөгөөд хүүгийн түвшин өмнөх оноос 0.2 пунктээр буурсан байна.



Тайлант онд салбарын нийт орлого өмнөх оноос 32.5 хувиар өсөж, 259.5 тэрбум төгрөгт, нийт ашиг 51.4 хувиар өсөж, 101.1 тэрбум төгрөгт хүрсэн ба нийт банк бус санхүүгийн байгууллагуудын 85.5 хувь нь 109.0 тэрбум төгрөгийн ашигтай, 12.1 хувь нь 7.9 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж, үлдсэн 2.4 хувь нь тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй байна. Салбарын ашигт ажиллагааны үзүүлэлтүүд болох нийт хөрөнгийн өгөөж 9.0 хувь, өөрийн хөрөнгийн өгөөж 11.7 хувьтай байгаа ба өмнөх оноос 1.4, 1.7 хувиар тус тус өссөн дүнтэй байна.



1.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

2018 оны жилийн эцсийн байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй 279 ХЗХ, нийт 27 салбартайгаар үйл ажиллагаа явуулж байна. ХЗХ-дын нийт гишүүдийн тоо өнгөрсөн оноос 12.5 хувиар өсөж тайлант онд 62,556 боллоо.

Тайлант онд ХЗХ-дын нийт хөрөнгийн хэмжээ 200.2 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 30.7 хувийн өсөлтийг үзүүлжээ. Салбарын нийт хөрөнгийн 83.4 хувийг нэг тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй 21 ХЗХ, 13.1 хувийг 100 саяас нэг тэрбум хөрөнгөтэй 123 ХЗХ, үлдсэн буюу 3.5 хувийг 100 саяас доош хөрөнгөтэй 135 ХЗХ-д бүрдүүлж байна. Салбарын активын бүтцээс харвал нийт хөрөнгийн өсөлтийн 60.7 хувийг зээлийн өсөлт, пассивын бүтцээс харвал 89.6 хувийг хадгаламжийн өсөлт тус тус бүрдүүлж байна.

Салбарын нийт зээлийн үлдэгдлийг өнгөрсөн онтой харьцуулахад 27.2 хувиар өсөж 133.8 тэрбум төгрөгт хүрсэн байна. Харин цэвэр зээлийн хэмжээ өмнөх оноос 27.5 хувиар өсөж 130.2 тэрбум төгрөг, зээлийн эрсдэлийн сан 16.7 хувиар өсөж 3.6 тэрбум төгрөгт хүрчээ. Мөн нийт зээлийн 92.2 хувийг хэвийн зээл, 3.3 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 4.5 хувийг чанаргүй зээл эзэлж байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь өнгөрсөн оноос 0.3 пунктээр өсөж 4.5 хувьд хүрчээ.

Мөн салбарын нийт хадгаламжийн хэмжээ өмнөх оноос 42.5 хувиар өссөн бөгөөд түүний 98.3 хувийг хугацаатай хадгаламж, 1.7 хувийг хугацаагүй хадгаламж бүрдүүлж байна. Тайлант онд ХЗХ-дын нийт орлого өмнөх оноос 29.6 хувиар өсөж 41.2 тэрбум төгрөгт хүрсэн бол цэвэр ашгийн хэмжээ 3.7 хувиар буурч 5.3 тэрбум төгрөг боллоо. Салбарын хэмжээнд нийт 279 ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаагаас 198 ХЗХ нь 5.6 тэрбум төгрөгийн ашигтай, 73 ХЗХ 0.3 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан бол 8 ХЗХ тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй байна. Түүнчлэн хадгаламж, зээлийн хоршоодын өөрийн хөрөнгийн өгөөж 18.7 хувь, нийт хөрөнгийн өгөөж 3.4 хувь байгаа бол гишүүдэд олгож буй зээлийн хүүгийн орлогын нийт зээлд эзлэх хувь өмнөх оноос 0.9 пунктээр өсөж 29.6 хувьд хүрчээ.



1.5. ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

Жижиг дунд үйлдвэр эрхлэгчийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, иргэдийн орлогын тогтвортой эх үүсвэрийг хангах зорилгоор 2012 онд Зээлийн батлан даалтын сан үүсгэн байгуулагдсан. 2018 оны жилийн эцсийн байдлаар Сангийн нийт хөрөнгийн хэмжээ 70.3 тэрбум төгрөг байгаа ба өмнөх оноос 3 дахин өссөн үзүүлэлттэй байна. Сангийн хөрөнгийн уг өндөр өсөлтөд урт хугацаат өр төлбөрийн өсөлт голчлон нөлөөлсөн.

2018 оны жилийн эцсээр Сангийн батлан даалтын үлдэгдэл 51.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 2 дахин өссөн бол батлан даалт гаргасан зээлийн үлдэгдэл өмнөх оноос 1.7 дахин өсөж 101.2 тэрбум төгрөгт хүрлээ. 2017 оны жилийн эцсээс эхлэн Сангаас гаргаж буй батлан даалт нэмэгдэж байгаа ба 2018 онд Сан 30.8 тэрбум төгрөгийн 162 батлан даалтыг шинээр гаргасан байна.

Тайлант онд шинээр гаргасан батлан даалтын 18.5 хувийг нь иргэдэд олгосон батлан даалт, 81.5 хувийг нь аж ахуйн нэгжид олгосон батлан даалт бүрдүүлж байгаа бол 69.8 хувийг Улаанбаатар хотод, 30.2 хувийг хөдөө орон нутагт гаргасан байна.

Тайлант онд шинээр гаргасан батлан даалтын хэмжээг эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудаар ангилан харвал нийт дүнгийн дийлэнх нь буюу 49.3 хувь нь үйлдвэрлэлийн салбарт, 25.8 хувь нь үйлчилгээний салбарт, 19.6 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 4.3 хувь нь хөдөө аж ахуйн салбарт үлдсэн 0.9 хувь нь бусад салбаруудад олгогдсон байна. 2016 оны эхэн үед хөдөө аж ахуйн салбарт батлан даалт түлхүү гаргаж байсан бол сүүлийн үед үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт гаргасан батлан даалт, нийт батлан даалтын дийлэнх хэсгийг бүрдүүлж байна.

2018 оны жилийн эцсийн байдлаар зээлийн батлан даалтын сан 3.8 тэрбум төгрөгийн орлого олж, 1.9 тэрбум төгрөгийн зардалтай ажилласнаар 1.8 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Үндсэн үйл ажиллагааны орлогын 85.9 хувийг гишүүдийн татварын орлого /хүүгийн орлого/, үлдсэн 14.1 хувийг батлан даалт, хураамж, шимтгэлийн орлого бүрдүүлж байна. Тайлант онд Сангийн цэвэр орлогын дүн өмнөх оноос 1.5 дахин өссөн дүнтэй байна.

2018 оны жилийн эцсийн байдлаар батлан даалтын нийт үлдэгдэлд эзлэх чанаргүй батлан даалтын хувь 14.2 болж өмнөх оноос 3.4 пунктээр буурлаа. 2017 оны 4 дүгээр улиралд 17.6 хувьд хүрээд байсан уг үзүүлэлт сүүлийн 4 улиралд буурсан дүнтэй байгаа юм.





САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ

2.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Зохицуулалттай этгээд: Тайлант хугацаанд 54 компани Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд үнэт цаасны арилжаа эрхлэх 2, үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх 1, төвлөрсөн хадгаламжийн 1, кастодиан банкны үйлчилгээ үзүүлэх 3, хөрөнгө оруулалтын менежментийн

17 компани үйл ажиллагаа явуулж байгаа бол хөдөө аж ахуйн биржийн арилжаа, зуучлалын чиглэлээр арилжаа эрхлэх 1, бараа, түүхий эдийн арилжааны зуучлалын үйл ажиллагаа эрхлэх 12 этгээд байна. Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй зохицуулалттай этгээдүүдийн үйл ажиллагааны чиглэл болон тоог хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 1: Үнэт цаасны зах зээл дэх зохицуулалттай этгээдийн тоо /үйл ажиллагааны чиглэлээр/


№	Зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэгч	Оролцогчдын тоо
1	Үнэт цаасны арилжаа эрхлэх	2
2	Үнэт цаасны төлбөр тооцооны	1
3	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн	1
4	Хөрөнгө оруулалтын менежментийн	17
5	Хөрөнгө оруулалтын сан (хувийн)	12
6	Кастодиан	3
7	Андеррайтерийн зөвшөөрөлтэй банк	2
Мэргэжлийн оролцогчид:		54
8	Брокер	53
9	Дилер	41
10	Андеррайтер	25
11	Хөрөнгө оруулалтын зөвлөх	14
Нийт		90
12	Хөдөө аж ахуйн түүхий эдийн арилжаа эрхлэх	1
13	Хөдөө аж ахуйн түүхий эдийн брокер	12
14	Аудитын компани	56
15	Үнэлгээний компани	23
16	Хуулийн компани	26

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Үнэт цаасны компаниудын хөрөнгө: 2018 оны жилийн эцсийн байдлаар нийт 54 үнэт цаасны компани үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд

нийт компаниудын хөрөнгийн хэмжээ 85.4 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

Зураг 1. Үнэт цаасны компаниудын тоо болон хөрөнгийн хэмжээ /тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Арилжааны гүйлгээ:

Монголын Хөрөнгийн Бирж (МХБ): 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 252 удаагийн арилжаагаар 136 компанийн 666.8 сая ширхэг хувьцааг 210.0 тэрбум төгрөгөөр, ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 332.8 мянган ширхэг үнэт цаасыг 33.5 тэрбум төгрөгөөр, компанийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаагаар 6.3 мянган ширхэг бондыг

631.6 сая төгрөгөөр тус тус арилжиж, нийт 244.1 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна.

Монголын Үнэт Цаасны Бирж (МҮЦБ): Тайлант онд МҮЦБ-ийн анхдагч зах зээлийн арилжаагаар 100 мянган ширхэг компанийн бондыг 1 тэрбум төгрөгөөр, хоёрдогч зах зээлийн арилжаагаар 6,600 ширхэг компанийн бондыг 66 сая төгрөгөөр, 6.4 сая ширхэг хувьцааг 292.1 сая төгрөгөөр тус тус арилжаалав.

ШИГТГЭЭ 1.

МОНГОЛЫН АНХДАГЧ ХУВИЙН БИРЖИЙН АНХНЫ БОНДЫН АРИЛЖАА ЯВАГДЛАА


2018 оны сүүлээр нэгэн онцлог бүтээгдэхүүн Монголын хөрөнгийн зах зээлд гарсан нь орон нутагт барилгын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Минж Проперти” ХХК Монголын анхны хувийн бирж болох “Монголын үнэт цаасны бирж” ХК-аар дамжуулан 1 тэрбум төгрөгийн 1 жилийн хугацаатай 17 хувийн хүүтэй “Парк таун” бондыг нээлттэй хүрээнд амжилттай босгосон явдал байлаа. Өөрийн хөрөнгөөр баталгаажсан бонд гаргагч “Минж Проперти” ХХК нь Дархан-Уул аймагт 2011 оноос барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд орон нутгаас барилгын компани нээлттэй хүрээнд бонд гаргаж байгаа нь хөрөнгийн зах зээлийн түүхэн дэх анхны тохиолдол юм. Тус компани Дархан-Уул аймагт хэрэгжүүлэх “Парк Таун-2” төслийн урсгал санхүүжилтийг энэхүү бондоор босгохоор төлөвлөсөн аж.

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

МХБ болон МҮЦБ-ээр өссөн дүнгээр нийтдээ 245.5 тэрбум төгрөгийн арилжаа явагдсан бөгөөд өнгөрсөн оноос 615.3 тэрбум төгрөгөөр буурчээ.

2017 онд нийт арилжааны гүйлгээний 89.8 хувийг ЗГҮЦ-ны арилжаа бүрдүүлж байв.

Зураг 2: Арилжааны гүйлгээний дүн, бүтээгдэхүүний ангиллаар /тэрбум төгрөгөөр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зах зээлийн үнэлгээ болон хөрвөх чадвар: 2018 оны жилийн эцсийн байдлаар үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 2,511.8 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх онтой харьцуулахад 71.5 тэрбум төгрөг буюу 2.9 хувиар өссөн үзүүлэлт юм. Тайлант үед

нийт 210.3 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдэж хөрвөх чадвар 8.4 хувь болов. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 5.2 пунктээр өссөн үзүүлэлт юм.

Зураг 3: Зах зээлийн үнэлгээ ба хөрвөх чадвар




Эх сурвалж: "Монголын хөрөнгийн бирж" ХК

ЗЗУ/ДНБ-ий харьцаа: Тайлант онд ЗЗУ-г 2018 оны жилийн эцсийн үйлдвэрлэлийн аргаар тооцсон нэрлэсэн ДНБ-ний хэмжээтэй харьцуулахад 7.8

хувийг эзэлж байгаа нь өмнөх оноос 0.9 пунктээр буурсан үзүүлэлт юм. Тус үзүүлэлт буурахад ДНБ 15 хувиар өссөн нь голчлон нөлөө үзүүлжээ.

Зураг 4: Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх зах зээлийн үнэлгээний хувь




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хувьцааны индекс: Олон улсад хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдлыг тайлбарладаг бас нэгэн үзүүлэлт нь хувьцааны индекс байдаг. Тухайлбал, Нью-Йоркийн хөрөнгийн бирж болон Насдакийн хөрөнгийн бирж дээр арилжаалагддаг томоохон 500 компанийн зах зээлийн үнэлгээнд суурилан тооцдог Стандарт энд Пүүрс 500 (Standard and Poor's 500 буюу S&P 500) индекс нь Америкийн хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдлыг илэрхийлэгч нэгэн үзүүлэлт болдог. Манай орны хувьд “Монголын хөрөнгийн бирж” ХК-аас

хоёр төрлийн индекс тооцдог. Хамгийн өндөр үнэлгээтэй 20 компанийн зах зээлийн үнэлгээнд суурилан тооцдог ТОП-20 индекс, үнэт цаасны бүртгэлийн I ба II ангилалд багтах компанийн зах зээлийн үнэлгээнд суурилсан MSE A болон MSE B индексүүдийг тооцож байна.

ТОП-20: Тайлант үед ТОП-20 индекс өмнөх онтой харьцуулахад 729.8 нэгжээр буюу 3.5 хувиар өсөж 21,466.8 нэгж болсон бөгөөд индексийн дээд үзүүлэлт 21,737.7 нэгж, доод үзүүлэлт 18,861.4 нэгж, дундаж үзүүлэлт 20,157.0 нэгж байна.

Зураг 5: ТОП-20 индекс




Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

MSE A болон MSE B: Тайлант хугацаанд MSE A индексийн дээд үзүүлэлт нь 11,091.79 нэгж, доод үзүүлэлт нь 8,872.87 нэгж, дундаж үзүүлэлт нь 9,661.84 нэгж байна.

MSE B индексийн хувьд дээд үзүүлэлт нь 10,202.94 нэгж, доод үзүүлэлт нь 8,284.32 нэгж, дундаж үзүүлэлт нь 9,388.79 нэгж байна.

Зураг 6: MSE A болон MSE B индекс




Эх сурвалж: "Монголын хөрөнгийн бирж" ХК

2.2. ХАА-Н ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Хөдөө аж ахуйн бирж нь анх 2013 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд арилжаалж эхэлсэн ба үүнээс хойш 2018 оны жилийн эцсийн байдлаар нийт 3.1 их наяд төгрөгийн арилжаа явуулжээ.

ХАА-н биржийн арилжаа: ХАА-н биржээр дамжин 2018 оны жилийн эцсийн байдлаар өссөн дүнгээр 711.4 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 164.2 тэрбум төгрөг буюу 30.0 хувиар өссөн үзүүлэлт юм.

Зураг 7: Хөдөө аж ахуйн биржийн арилжаа /тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ХАА-н биржийн индекс: Бирж 2015 оноос биржийн индекс тооцоолж олон нийтэд мэдээлж эхэлсэн. МАРИХ нь бирж дээр арилжаалагдаж байгаа бараа түүхий эдийн үнийг тусгай загвараар жигнэж тооцоолсон үнэ юм. Биржийн индекс нь

сонгосон бүлэг бараа эсвэл салбар дахь барааны үнийг ерөнхий багцаар харах боломж олгодог. Тайлант онд МАРИХ индекс хамгийн их буюу 861,420.43 нэгж хүрсэн.

Зураг 8: Хөдөө аж ахуйн гаралтай бараа бүтээгдэхүүний MAPIX индекс




Эх сурвалж: Хөдөө аж ахуйн бирж

2.3. ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Даатгалын зах зээлийн бүтэц: Тайлант хугацаанд нийт 306 даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгч, аудитын компани, актуарч, аудитор

СЗХ–ноос олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрхийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 9: Даатгалын зах зээлийн бүтэц



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Даатгалын зах зээлд өнөөгийн байдлаар ердийн даатгалын 15 компани, урт хугацааны даатгалын 1 компани, давхар даатгалын 2 компани үйл ажиллагаа явуулж байна. Харин мэргэжлийн

оролцогчдын хувьд 49 даатгалын зуучлагч компани байгаагаас давхар даатгалын зуучлагч 7, мөн даатгалын зуучлалын үйлчилгээ үзүүлэгч 10 банк байна. Даатгалын хохирол үнэлэгч 27

компани, 2430 даатгалын төлөөлөгчид тус тус СЗХ–ноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулж байна.


Түүнчлэн даатгалын компаниуд болон мэргэжлийн оролцогчдын нийтлэг эрх ашгийг хамгаалах зорилго бүхий, төрийн бус байгууллагууд СЗХ–той санамж бичгийн хүрээнд хамтран ажилладаг. Эдгээр холбоодыг дурдвал Албан журмын даатгагчдын холбоо, Монголын даатгалын холбоо, Монголын даатгалын зуучлагчдын холбоо, Монголын хохирол үнэлэгчдийн холбоо, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт зэрэг юм.

Даатгалын компаниуд болон мэргэжлийн оролцогчдын санхүү нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа стандартын дагуу хөтлөгдөж буй эсэхэд хяналт тавих, баталгаажуулах үүднээс аудитын компаниудад СЗХ–ноос эрх олгодог. Одоогоор нийт 43 аудитын компани болон 141 аудиторт тус эрхийг олгоод байна.

Даатгалын зах зээлийн бүтэц /нийт хөрөнгөөр/. Нийт даатгалын компаниудын хувьд зах зээлд эзлэх хувь хэмжээгээр 3 хувиас доош хувь хэмжээг эзэлж буй 6 даатгалын компани, 3–6 хувьтай мөн 5 даатгалын компани, 6–9 хувьтай 4 даатгалын компани, 9 хувиас дээш хувь хэмжээг эзэлж буй 3 даатгалын компани байна. Даатгалын зах зээлд нийт хөрөнгөөр хамгийн өндөр хувийг эзэлж байгаа 5 даатгалын компанийн хөрөнгийн хэмжээ 2017 онд нийт зах зээлийн 54.7 хувийг бүрдүүлж байсан бол тайлант онд давхар даатгалын нэг компани нэмэгдсэнтэй холбоотойгоор нийт эзлэх хувь хэмжээ нь 52.1 хувь болж буурчээ.

Тайлант онд даатгалын компаниудын нийт хөрөнгөд эзлэх хувь хэмжээгээр Хөдөө аж ахуйн давхар даатгал (ХААДД)–ын компани хамгийн өндөр буюу 14.6 хувийг эзэлж байгаа бөгөөд энэ нь 2017 оныхтой харьцуулахад 3.1 пунктээр буурсан үзүүлэлт юм. Харин ердийн даатгалын компаниудаас Монгол даатгал ХХК зах зээлд эзлэх хувиар ХААДД–ын компанийн дараа буюу нийт зах зээлийн 11.3 хувийг эзэлжээ.

Зураг 10: Даатгалын компаниудын зах зээлд эзлэх хувь




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Даатгалын гүнзгийрэлтийн түвшин: Даатгалын салбарын үндсэн үзүүлэлтүүд сүүлийн жилүүдэд өсөлттэй байгаа хэдий ч салбарын хөгжлийн гол хэмжүүр болох даатгалын гүнзгийрэлт буюу ДНБ–д эзлэх хураамжийн орлогын хувь хэмжээ

олон улстай харьцуулахад доогуур байна. 2018 онд даатгалын гүнзгийрэлт 0.56 хувь байгаа нь өнгөрсөн онтой харьцуулахад 0.03 пунктээр өссөн үзүүлэлт юм.

Зураг 11: Даатгалын гүнзгийрэлтийн түвшин




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Олон улсын хандлагаас харахад урт хугацааны даатгалын гүнзгийрэлт ердийн даатгалаас илүү өндөр хувьтай байдаг бол манай орны хувьд нөхцөл байдал эсрэгээрээ байна. Европийн болон Азийн зарим орнуудад урт хугацааны даатгалын гүнзгийрэлт 5 хувиас дээш, Өмнөд Африк болон Хятадад 10 хувиас дээш байхад манай орны хувьд сүүлийн жилүүдэд дунджаар 0.01 хувьтай байгаа юм. Харин OECD-ийн гишүүн орнуудын ердийн даатгалын гүнзгийрэлт 2017 оны байдлаар 4.5 хувь байхад манай орны хувьд тайлант хугацаанд 0.56 хувь байна.

Нийт хөрөнгө: Тайлант хугацаанд нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оноос 35.6 хувь, өмнөх улирлаас 1.3

хувиар өсөж 331.9 тэрбум төгрөгт хүрлээ. Давхар даатгалын компанийн нийт хөрөнгийн жилийн өсөлт бусад даатгалын төрөлтэй харьцуулахад илүү өндөр буюу 61.8 хувиар өсөж 70.2 тэрбум төгрөг болж, нийт хөрөнгийн 21.2 хувийг эзлэв. Ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгө өмнөх онтой харьцуулахад 30.6 хувиар өсөж 252.9 тэрбум төгрөг болсон нь салбарын нийт хөрөнгийн 76.2 хувийг, давхар даатгалын компаниудын нийт хөрөнгө 61.8 хувиар өсөж 70.2 тэрбум төгрөгт хүрч салбарын нийт хөрөнгийн 21.2 хувийг, харин урт хугацааны даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ 14.3 хувиар өсөж 8.9 тэрбум төгрөгт хүрч, нийт хөрөнгийн 2.7 хувийг эзэллээ.

Зураг 12: Даатгалын салбарын нийт хөрөнгө




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нийт даатгалын компаниудын хөрөнгийн дундаж өсөлт 2017 онд 15.5 хувь байсан бол 2018 онд 26.8 хувьтай байна. 2017 онд дунджаас дээш хөрөнгийн өсөлттэй компанийн тоо 7 байсан бол 2018 онд 6 болж буурсан байна. Харин хөрөнгийн

өсөлтөөр бүлэглэн авч үзвэл 30 хувиас дээш өсөлттэй 6 даатгалын компани, 20–30 хувийн өсөлттэй 3 даатгалын компани, 10–20 хувийн өсөлттэй 4 даатгалын компани, 10 хувиас доош өсөлттэй 4 даатгалын компани байна.

Зураг 13: Даатгалын компанийн хөрөнгийн өсөлтийн тархалт




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хураамжийн орлого: Даатгалын компаниуд энэ онд нийт 178.7 тэрбум төгрөгийн хураамжийн орлоготой ажиллав. Үүнээс ердийн даатгалын компаниуд 175.5 тэрбум төгрөг, урт хугацааны даатгалын компани 1.4 тэрбум төгрөг, давхар даатгалын компани 1.7 тэрбум төгрөгийн хураамжийн орлого бүрдүүлэв. 2017 онд хураамжийн орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26 хувийн өсөлттэй гарч байсан бол 2018 онд 23.8 хувийн өсөлтийг үзүүлэв.

Хураамжийн орлогын төвлөрүүлэлтийг авч үзвэл даатгалын зуучлагчид 39.8 тэрбум төгрөг буюу 22.3 хувийг, даатгалын төлөөлөгчид 36.9 тэрбум төгрөг буюу 20.6 хувийг бүрдүүлсэн байна. Даатгалын зуучлагчаар дамжин орсон хураамжийн орлогын 28.9 хувийг жолоочийн хариуцлагын албан журмын даатгал эзэлж байгаа бол төлөөлөгчөөр дамжин орсон хураамжийн орлогын 31 хувийг эзэлж байна.

Зураг 14: Даатгалын салбарын хураамжийн орлого



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нөхөн төлбөр, давхар даатгалын хураамж: Даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн зардал тайлант жилд 58.2 тэрбум төгрөгт хүрч,


нийт хураамжийн орлогын 32.6 хувийг эзлэв. Өнгөрсөн онтой харьцуулахад нөхөн төлбөрийн зардал 28.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Үүнээс ердийн даатгалын компаниудын нөхөн төлбөр 98.1 хувийг бүрдүүллээ.

Тайлант хугацаанд даатгалын компаниуд нийт 55.3 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамжийн зардалтай ажилласан нь өмнөх оноос 18.7 хувиар өссөн үзүүлэлт бөгөөд нийт хураамжийн

орлоготой харьцуулахад 31 хувь байна. Ердийн даатгалын компаниуд давхар даатгалд 54.5 тэрбум төгрөг, давхар даатгалын компани 825.3 сая төгрөг, урт хугацааны даатгалын компани 22.4 сая төгрөгийг зарцуулжээ.

Зураг 15: Нөхөн төлбөр, давхар даатгалын хураамжийн нийт хураамжийн орлогод эзлэх хувь




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нөөц сан: Даатгалын салбарын нийт нөөц сангийн хэмжээ тайлант онд 146 тэрбум төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оноос 23.7 хувиар өссөн үзүүлэлт юм. Жилийн эцсийн харьцуулсан үзүүлэлтээс харахад 2011 оноос хойш нийт нөөц сангийн өсөлт дунджаар 22 хувьтай, 8 хувийн стандарт хазайлттай байна.

Тайлант хугацаанд ердийн даатгалын компаниудын нийт нөөц сан (орлогод тооцоогүй хураамжийн нөөц болон нөөц сангийн нийлбэр дүн)-ийн хэмжээ 22.3 хувиар өсөж 118.1 тэрбум төгрөг, урт хугацааны даатгалын компанийн нөөц сан 30.8 хувиар өсөж 2 тэрбум төгрөг, давхар даатгалын компанийн нөөц сан 30.2 хувиар өсөж 25.9 тэрбум төгрөг болов.

Зураг 16: Нөөц сангийн хэмжээ, өсөлт



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


Нөөц сангийн хөрөнгийн 60 орчим хувь нь арилжааны банкуудад хадгаламж болон хадгаламжийн сертификат хэлбэрээр байршиж байна.

2.4. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Банк бус санхүүгийн байгууллагуудын статистик үзүүлэлтүүд: 2018 оны жилийн эцсийн байдлаар санхүүгийн зах зээл дээр нийт 539 банк бус санхүүгийн байгууллага Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулж байна. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо тайлант онд өмнөх оноос 0.9 хувиар өссөн

байна. Үйл ажиллагаа эрхлэгчдийн тооны өсөлт саарч буй хэдий ч банк бус санхүүгийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэж байна. Тухайлбал, тайлант онд банк бус санхүүгийн байгууллагын харилцагчдын тоо 1.6 сая болж өмнөх оноос 8.9 хувиар, нийт зээлдэгчдийн тоо 234.1 мянгад хүрч өмнөх оноос 2.1 дахин өслөө.

Зураг 17: ББСБ-ын тоо болон харилцагчдын тоо




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


Салбарын хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж буй 539 банк бус санхүүгийн байгууллагын 13.5 хувь нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа бол 86.5 хувь нь нийслэл Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байна. Мөн нийт

байгууллагуудын 5.2 хувь нь гадаадын хөрөнгө оруулалтаар санхүүжиж байгаа бол 94.8 хувь нь дотоодын хөрөнгө оруулалттай байгууллагууд байна.

Зураг 18: ББСБ-уудын байршил



Зураг 19: ББСБ-уудын эзлэх хувь /хөрөнгө оруулалтын төрлөөр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Банк бус санхүүгийн байгууллагаас зээл авсан иргэдийн тоо сүүлийн жилүүдэд огцом нэмэгдэж байна. Зээлдэгчдийн тооны уг өсөлтөд салбарын зээлийн нийлүүлэлт нэмэгдсэн нь нөлөөлснөөс гадна технологид суурилсан санхүүгийн үйлчилгээ салбарт нэвтэрсэн нь нөлөөлсөн. Хорооны

зохицуулалтад байгаа банк бус санхүүгийн байгууллагууд нь гар утсанд суурилсан зээлийн үйлчилгээг иргэдэд хүргэж эхлээд байгаа ба энэ төрлийн зээл нь бага дүнтэй, богино хугацаатай, түргэн шуурхай санхүүжилтийг хэрэглэгчдэд санал болгож байна.

Зураг 20: ББСБ-уудын ажиллагсдын тоо



Зураг 21: ББСБ-уудын зээлдэгчдийн тоо /мянгаар/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Банк бус санхүүгийн байгууллагуудын актив болон пассивын бүтэц: Банк бус санхүүгийн байгууллагуудын санхүүгийн хураангуй тэнцлийн үндсэн үзүүлэлтүүдийг хүснэгтэд харууллаа. Активын бүтцээс харахад байгууллагуудын нийт хөрөнгийн 96.1 хувийг эргэлтийн хөрөнгө бүрдүүлж байна. Үүнээс 24.5 хувийг мөнгөн

хөрөнгө, 62.6 хувийг зээлийн үлдэгдэл бүрдүүлж байгаа бол нийт хөрөнгийн 3.9 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлж байна. Харин пассивын бүтцээс харахад нийт хөрөнгийн 23.9 хувийг өр төлбөр бүрдүүлж байгаа бол 76.1 хувийг эздийн өмч бүрдүүлж байна. Үүнээс 57.7 хувь нь хувь нийлүүлсэн хөрөнгө байна.

Хүснэгт 2: ББСБ-уудын актив болон пассивын бүтэц /тэрбум төгрөгөөр/

Активын бүтэц		Пассивын бүтэц	
Эргэлтийн хөрөнгө	1234.7	Өр төлбөр	307.5
Мөнгөн хөрөнгө	315.1	Санхүүгийн эх үүсвэр	57.6
Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/	1.8	Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад	151.0
Зээл /цэврээр/	804.7	Бусад эх үүсвэр	15.7
Санхүүгийн түрээсийн тооцооны авлага /цэврээр/	0.0	ББСБ-аас гаргасан өрийн бичиг	23.5
Факторингийн тооцооны авлага /цэврээр/	7.3	Төслийн зээлийн санхүүжилт	17.8
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	10.2	Бусад өр төлбөр	41.8
Бусад хөрөнгө	95.5	Эздийн өмч	977.4
		Хувьцаат капитал	740.8
		Бусад өмч	10.6
Эргэлтийн бус хөрөнгө	50.2	Сангууд	0.5
		Хуримтлагдсан ашиг/ алдагдал	224.6
НИЙТ ХӨРӨНГӨ	1284.9	Хоёрдогч өглөг	1.0
		НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	1284.9

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


Банк бус санхүүгийн байгууллагуудын хөрөнгө: Тайлант онд банк бус санхүүгийн байгууллагуудын нийт хөрөнгийн хэмжээ 1.3 их наяд төгрөгт хүрэн өмнөх оноос 315.7 тэрбум төгрөгөөр буюу 32.6 хувиар өсжээ. Активын

бүтцээс харвал энэхүү өсөлтийн 73.2 хувийг нийт зээлийн өсөлт дангаараа бүрдүүлж байна. Харин өөрийн хөрөнгийн хэмжээ өмнөх оноос 219.3 тэрбум төгрөгөөр өсөн 977.4 тэрбум төгрөгт хүрэн 28.9 хувийн өсөлт үзүүлжээ.

Санхүүгийн зохицуулах хорооноос 2016 оны 10 дугаар сард банк бус санхүүгийн байгууллагуудын хувь нийлүүлсэн хөрөнгийг үе шаттайгаар нэмэгдүүлэх шийдвэр гаргасан ба уг шийдвэрийг банк бус санхүүгийн байгууллагууд амжилттай


хэрэгжүүлсээр байна. 2018 оны жилийн эцсийн байдлаар банк бус санхүүгийн байгууллагуудын нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 740.8 тэрбум төгрөгт хүрсэн ба энэ нь өмнөх оноос 24.4 хувиар өссөн үзүүлэлт юм.

Зураг 22: ББСБ-ын салбарын нийт хөрөнгө ба өөрийн хөрөнгө /тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зураг 23: ББСБ-уудын тоо /зах зээлд эзлэх хувиар/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


Банк бус санхүүгийн байгууллагуудын зах зээлд эзлэх хувийг хөрөнгийн хэмжээгээр нь тооцвол, нийт үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагуудын 96.7 хувь нь буюу 521 нь салбарын нийт хөрөнгийн 1 хүрэхгүй хувийг эзэмшдэг бол 2.2 хувь нь салбарын нийт хөрөнгийн 1-2 хувийг, үлдсэн 1.1 хувь нь нийт салбарын хөрөнгийн 2-оос дээш хувийг эзэмшиж байна.

Банк бус санхүүгийн байгууллагуудын зээл: 2018 онд банк бус санхүүгийн салбарт нийт 989.2 тэрбум төгрөгийн зээл олгогдож, 795.6 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж, салбарын нийт зээлийн үлдэгдэл оны эцэст 869.2 тэрбум төгрөг байна. Сүүлийн жилүүдэд банк бус санхүүгийн байгууллагуудын зах зээлд нийлүүлж буй зээлийн бүтээгдэхүүний хэмжээ тасралтгүй өсөж байгаа ба 2018 онд салбарын нийт зээлийн хэмжээ өмнөх оноос 36.2 хувиар өссөн дүнтэй байна. Зээлийн нийлүүлэлтийн энэхүү өсөлтөд

байгууллагуудын хөрөнгийн чадавх сайжирсан, эх үүсвэрийн хэмжээ нэмэгдсэн нь голчлон нөлөөлсөн.

Тайлант оны зээлийн үлдэгдлийн 96.5 хувийг төгрөгөөр, 3.5 хувийг валютаар олгосон зээл бүрдүүлж байгаа бөгөөд, нийт зээлийн үлдэгдлийн 81.9 хувийг иргэнд, 18.1 хувийг хуулийн этгээдэд олгосон зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Зураг 24: ББСБ-ын салбарын нийт зээлийн өсөлт




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


Нийт олгосон зээлийн 86.6 хувь нь хэвийн боловч, 3.85 хувь нь хугацаа хэтэрсэн зээл ба 9.5 хувь нь чанаргүй зээл байна. Чанаргүй болон хугацаа

хэтэрсэн зээлийн нийт зээлийн үлдэгдэлд эзлэх хувиуд нь өмнөх оноос харгалзан 3.2 болон 0.8 пунктээр тус тус буурсан байна.

Зураг 25: ББСБ-ын салбарын нийт зээлийн төрөл / валютаар/



Зураг 26: ББСБ-ын салбарын нийт зээлийн төрөл / чанараар/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зээлийн зориулалтаар авч үзвэл нийт олгосон зээлийн 64.4 хувийг хэрэглээнд, 16.1 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 9.8 хувь нь барилгын салбарт, 3.5 хувь нь уул уурхай, олборлолтын салбарт, 2.1 хувь нь боловсруулах салбарт олгогдсон байна. Нийт эргэн төлөгдсөн

зээлийн хувьд авч үзвэл 64.2 хувь нь хэрэглээнээс, 17.7 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбараас, 8.9 хувь нь барилгын салбараас, 2.5 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбараас, 2.5 хувь нь уул уурхай, олборлолтын салбараас эргэн төлөгдсөн байна.

Зураг 27: ББСБ-ын салбарын нийт олгосон зээл, төлөгдсөн зээл /зориулалтаар/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2016 онд 4 хувийг даваад байсан банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн жигнэсэн дундаж сарын хүү тайлант онд 3.2 хувь болж өмнөх оноос 0.2 пунктээр буурлаа. Зээлийн хүүгийн бууралтад эдийн засгийн нөхцөл байдал

сайжирсан нь нөлөөлсөн байж болох ч банк бус санхүүгийн салбарт зээлийн бүтээгдэхүүний нийлүүлэлт нэмэгдсэн нь үнийн түвшин болох хүүгийн түвшинг буурахад нөлөөлсөн байх боломжтой юм.


Зураг 28: ББСБ-ын салбарын зээлийн жигнэсэн дундаж сарын хүү



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2018 оны жилийн эцсийн байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт зээлийн үлдэгдлийн 64.0 хувь нь 1 жилээс бага хугацаатай олгосон зээл, 29.8 хувь нь 1–3 жилийн хугацаатай олгосон зээл, 5.7 хувь нь 3–5 жилийн хугацаатай олгосон зээл, 0.6 хувь нь 5–аас дээш жилийн хугацаатай олгосон зээл бүрдүүлж байна.

Зураг 29: ББСБ-ын салбарын нийт зээлийн үлдэгдэл /хугацааны ангиллаар/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2.5. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Хадгаламж, зээлийн хоршоодын тоо болон гишүүд: 2018 оны жилийн эцсийн байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа явуулж буй хадгаламж, зээлийн хоршоодын тоо 279

болж өмнөх оноос 11-ээр буурсан байна. Харин хадгаламж, зээлийн хоршоодын салбар нэгжийн тоо өнгөрсөн оноос 5-аар нэмэгдсэн ба үүнд хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулах салбарын тоо 33 хувиар өсөж 20 болжээ.

Хүснэгт 3: ХЗХ-дын тоо, гишүүдийн үзүүлэлт /хүйс, байршлаар/


№	Үзүүлэлтүүд	2017	2018	Өөрчлөлт	
				Дүн	Хувь
1	Нийт ХЗХ-ны тоо	290	279	(11)	-4%
	Үүнээс: хөдөө орон нутагт	98	103	5	5%
2	Нийт гишүүдийн тоо	55,624	62,556	6,932	12.5%
	Үүнээс: эмэгтэй	31,968	34,984	3,016	9%
	Үүнээс: эрэгтэй	23,235	27,450	4,215	18%
	Үүнээс: хуулийн этгээд	421	122	(299)	-71%
4	Нийт ажиллагсдын тоо	745	796	44	6%
	Үүнээс: эмэгтэй	541	603	62	11%
5	Нийт салбар нэгжийн тоо	22	27	5	23%
	Үүнээс: Улаанбаатар хотод	7	7	-	0%
	Үүнээс: хөдөө орон нутагт	15	20	5	33%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хадгаламж, зээлийн хоршоодын нийт гишүүдийн тоо өнгөрсөн оноос 12.5 хувиар буюу 6,932-оор өсөж тайлант онд 62,556-д хүрсэн байна. Энд,

эмэгтэй гишүүд 9 хувиар өсөж 34,984, эрэгтэй гишүүд 18 хувиар өсөж 27,450-д хүрсэн бол хуулийн этгээд гишүүний тоо 71 хувиар буурчээ.

Зураг 30: ХЗХ-дын тоо болон гишүүдийн тоо




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хадгаламж, зээлийн хоршоодын хөрөнгө: Тайлант онд хадгаламж, зээлийн хоршоод нийт 200.2 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй ажилласан ба

энэ нь өмнөх оноос 30.7 хувиар өссөн үзүүлэлт юм. Энэхүү өсөлтийн 60.6 хувийг зээлийн өсөлт дангаар бүрдүүлсэн байна.

Зураг 31: ХЗХ-дын нийт хөрөнгө, өсөлт




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хадгаламж, зээлийн хоршоодыг хөрөнгийн бүлгээр нь ангилан нийт хөрөнгөд эзлэх хувийг тооцвол, салбарын нийт хөрөнгийн 83.4 хувийг нэг тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй 21 ХЗХ,

13.1 хувийг 100 саяас нэг тэрбум хөрөнгөтэй 123 ХЗХ, үлдсэн буюу 3.5 хувийг 100 саяас доош хөрөнгөтэй 135 ХЗХ-д бүрдүүлж байна.

Зураг 32: ХЗХ-дын нийт хөрөнгөд эзлэх хувь /хөрөнгийн бүлгээр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хадгаламж, зээлийн хоршоодын зээл: Тайлант онд нийт зээлийн хэмжээ 133.8 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 27.2 хувиар өссөн нь 2017 оны жилийн эцсийн өсөлтөөс 2.6 пунктээр

өссөн үзүүлэлт юм. Харин цэвэр зээлийн хэмжээ өмнөх оноос 27.5 хувиар өсөж 130.2 тэрбум төгрөг, зээлийн эрсдэлийн сан 16.7 хувиар өсөж 3.6 тэрбум төгрөгт хүрчээ.

Зураг 33: ХЗХ-дын нийт зээл, өсөлт




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант онд хэвийн зээл өмнөх оноос 28.9 хувиар өсөж 133.8 тэрбум төгрөгт хүрсэн ба нийт зээлийн 92.2 хувийг эзэлж байна. Харин хугацаа хэтэрсэн зээл өмнөх оноос 11.8 хувиар буурч 4.4 тэрбум төгрөгт хүрсэн бол чанаргүй зээлийн хэмжээ 33.6

хувиар өсөж 6.0 тэрбум төгрөгт хүрчээ. Чанаргүй зээлийн 21.2 хувийг муу зээл, 60.0 хувийг эргэлзээтэй зээл, 18.7 хувийг хэвийн бус зээл эзэлж байна.

Зураг 34: ХЗХ-ны салбарын зээлийн төрөл /чанараар/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хадгаламж, зээлийн хоршоодын хадгаламж: Салбарын нийт хадгаламжийн хэмжээ өмнөх оноос 42.5 хувийн өсөлттэй байгаа бөгөөд түүний

98.3 хувийг хугацаатай хадгаламж, 1.7 хувийг хугацаагүй хадгаламж бүрдүүлж байна.

Зураг 35: ХЗХ-дын нийт хадгаламж, өсөлт




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант онд ХЗХ-дын 90.7 хувь буюу 253 ХЗХ нь нийт 141.5 тэрбум төгрөгийн хадгаламжтай ба үлдсэн 9.3 хувь буюу 26 ХЗХ нь огт хадгаламж татаагүй байна. Хадгаламжийн хэмжээгээр бүлэг болгон нийт хадгаламжид эзлэх хувийг авч үзвэл, 1 тэрбумаас дээш төгрөгийн хадгаламжтай 15 ХЗХ нь нийт 124.4 тэрбум төгрөг буюу салбарын

нийт хадгаламжийн 87.9 хувийг, 100 саяас 1 тэрбум төгрөгийн хадгаламжтай 46 ХЗХ нь нийт 12.4 тэрбум төгрөг буюу салбарын нийт хадгаламжийн 8.7 хувийг эзэлж байна. Харин 10 саяас 100 сая төгрөгийн хадгаламжтай ХЗХ-д 134 байгаа ба эдгээр нь салбарын нийт хадгаламжийн 3.2 хувийг эзэлж байна.

Зураг 36: Нийт хадгаламжид эзлэх хувь /хадгаламжийн бүлгээр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Мөн хадгаламж, зээлийн хоршоодын нэг гишүүнд ногдох хадгаламжийн хэмжээг бүсээр харвал, хангайн бүс хамгийн өндөр дүнтэй буюу дунджаар 0.6 сая төгрөг байна. Мөн хангайн бүсийн нэг гишүүнд ногдох хамгийн их хадгаламжийн хэмжээ

2.4 сая төгрөг, хамгийн багадаа 14.7 мянган төгрөг байна. Харин тус үзүүлэлтээр төвийн бүс бусад бүсүүдээс хамгийн бага буюу дунджаар олгох нэг гишүүний хадгаламжийн хэмжээ 0.35 сая төгрөг байна.

Хүснэгт 4: ХЗХ–дын нэг гишүүнд ногдох хадгаламжийн хэмжээ /бүсээр/

Бүсээр	Нэг гишүүнд ногдох хадгаламжийн хэмжээ /төгрөгөөр/		
	Их	Дундаж	Бага
Баруун бүс	2,012,046.2	383,991.3	25,348.7
Хангайн бүс	2,413,085.6	615,810.6	14,741.9
Төвийн бүс	969,893.5	347,768.0	531.9
Зүүн бүс	1,388,950.1	541,073.4	46,899.4

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант оны байдлаар хадгаламж, зээлийн төгрөгт хүрсэн бол хоршоологчдын өмчийн хоршоодын гишүүдийн оруулсан хувь хөрөнгө хэмжээ өнгөрсөн жилээс 20.2 хувиар өсөж 18.0 өнгөрсөн жилээс 3.2 хувиар өсөж 15.3 тэрбум тэрбум төгрөгт хүрчээ.


Хүснэгт 5: ХЗХ–дын актив ба пассивын ерөнхий үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	2017	2018	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
Нийт хөрөнгө	153.1	200.2	47.1	30.7%
Нийт зээл	105.2	133.8	28.6	27.2%
Хэвийн зээл	95.7	123.4	27.7	28.9%
Хугацаа хэтэрсэн зээл	5.0	4.4	(0.6)	-11.8%
Чанаргүй зээл	4.5	6.0	1.5	33.6%
Хэвийн бус	1.1	1.1	(0.0)	-2.1%
Эргэлзээтэй зээл	1.6	3.6	2.0	123.7%
Муу зээл	1.7	1.3	(0.5)	-26.5%
Нийт өр төлбөр	123.2	166.7	43.5	35.3%
Хадгаламж	99.3	141.5	42.2	42.5%
Хугацаагүй	3.3	2.5	(0.8)	-25.4%
Хугацаатай	96.1	139.1	43.0	44.8%
Нийт өөрийн хөрөнгө	30.0	33.5	3.5	11.7%
Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	14.9	15.3	0.5	3.2%
Хоршоологчдын өмч	14.9	18.0	3.0	20.2%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хадгаламж, зээлийн хоршоодын зээл болон 2.9 хувьд хүрсэн бол хадгаламжийн жигнэсэн хадгаламжийн хүү: Салбарын зээлийн жигнэсэн дундаж хүү өнгөрсөн улирлаас 0.1 пунктээр өсөж дундаж хүү өнгөрсөн улиралтай харьцуулахад 0.2 пунктээр өсөж 1.6 хувьд хүрчээ.

Зураг 37: ХЗХ–дын зээл болон хадгаламжийн жигнэсэн дундаж хүү /улирлаар/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2.6 ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

Монгол Улсын Засгийн Газар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбоо нь жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, иргэдийн орлогын тогтвортой эх үүсвэрийг хангах зорилгоор 2012 онд Зээлийн батлан даалтын санг үүсгэн байгуулсан.

2018 оны жилийн эцсийн байдлаар Сангийн нийт хөрөнгийн хэмжээ 70.3 тэрбум төгрөг байна. Энэ нь өмнөх улирлаас 1.8 хувиар, өмнөх оны мөн үеэс 3 дахин өссөн дүн бөгөөд хөрөнгийн уг өндөр өсөлтөд урт хугацаат өр төлбөрийн өсөлт голчлон нөлөөлсөн бөгөөд хөрөнгийн өсөлтийн 95.7 хувийг урт хугацаат өр төлбөрийн өсөлт бүрдүүлж байна.

Зураг 38: ЗБДС–ийн нийт хөрөнгийн хэмжээ /тэрбум төгрөгөөр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Сангийн батлан даалтын үлдэгдэл 2018 оны жилийн эцсийн байдлаар 51.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 2 дахин өссөн бол батлан даалт

гаргасан зээлийн үлдэгдэл өмнөх оноос 1.7 дахин өсөж 101.2 тэрбум төгрөгт хүрлээ.

Зураг 39: Батлан даалтын үлдэгдэл




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2017 оны жилийн эцсээс эхлэн Сангаас гаргаж буй батлан даалт нэмэгдэж байгаа ба 2018 оны 4 дүгээр улиралд 3.2 тэрбум төгрөгийн 16 батлан

даалтыг шинээр гаргаснаар 2018 онд нийт 30.8 тэрбум төгрөгийн батлан даалт хийсэн байна.

Зураг 40: Тайлант хугацаанд шинээр олгосон батлан даалтын дүн




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


2018 оны туршид шинээр гаргасан батлан даалтын 18.5 хувийг нь иргэдэд олгосон батлан даалт, 81.5 хувийг нь аж ахуй нэгжид олгосон батлан даалт бүрдүүлж байна. 2018 онд Сангийн гаргаж буй нэг батлан даалтын хэмжээ дунджаар

189.9 сая төгрөгийн дүнтэй байгаа бол иргэдэд олгосон батлан даалтын дүн дунджаар 123.6 сая төгрөг, аж ахуй нэгжид олгосон батлан даалтын дүн дунджаар 216.2 сая төгрөг байна.

Зураг 41: Олгосон батлан даалт /хэрэглэгчдийн төрлөөр/



Зураг 42: Нэг батлан даалтын дундаж хэмжээ



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

delivered solid results in a cha

llion
Income
PBT

CAGR (04-08)
Revenue 20%
PBT 15%

H1
Revenue (2%)
PBT 4%

BCI/BlackRock
deal costs






ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

3.1. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Зохицуулалттай үнэт цаасны компаниуд: Нийт 79 ҮЦК-ийн 54 нь төв ҮЦК, 25 нь салбар төлөөлөгчөөр ажиллаж байгаа ба тэдгээрийн 33 нь хөдөө орон нутагт байршиж байна. Бүсээр

ангилан харвал төвийн бүсэд 11, зүүн бүсэд 3, хангайн бүсэд 13, баруун бүсэд 6 байна. Харин үлдсэн 46 ҮЦК нь Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулж байна.

Зураг 43: Үнэт цаасны компаниудын тархалт /газар зүйн байршлаар/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Топ 10 ХК-ийн төвлөрөл (зах зээлийн үнэлгээгээр): 2018 онд зах зээлийн үнэлгээний 77.5 хувийг 10 компанийн үнэлгээ бүрдүүлж байна. Эдгээр зах зээлийн үнэлгээ өндөртэй 10 компанийг үйл ажиллагаа явуулж буй салбараар нь ангилан зураг 44-т харуулав.

Хувьцааны төвлөрөл: Аливаа хувьцаат компанийн нийтэд арилжаалагдаж буй хувьцааны дийлэнх хувь нь цөөн тооны нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн гарт байхыг хувьцааны төвлөрөл гэнэ. Компанийн нийт гаргасан хувьцааны 5 хувиас дээш хувьцааг эзэмшдэг бол том хувьцаа эзэмшигч болдог бол 5 хувиас доошийг эзэмшдэг бол жижиг хувьцаа эзэмшигч болдог байна. 2018 оны байдлаар 33Ү-ээр эхний 10-т жагсаж буй компаниудын хүрээнд хувьцааны төвлөрлийг тооцож үзэхэд нийт хувьцаа эзэмшигчдийн 0.1 хувь нь буюу том хувьцаа эзэмшигчид


Зураг 44: Зах зээлийн үнэлгээ өндөр 10 ХК /салбараар/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

нийт гаргасан хувьцааны 86.1 хувийг эзэмшиж байгаа бол үлдсэн 99.9 хувь нь буюу жижиг хувьцаа эзэмшигчид нийт хувьцааны 13.9 хувийг эзэмшиж байна.

Зураг 45: Зах зээлийн үнэлгээ өндөр 10 ХК-ийн хувьцааны төвлөрөл



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хувьцааны төвлөрөл өндөр байгаа нь гадны хөрөнгө оруулагчдад 2 талын үр дагаврыг бий болгодог. Нэгдүгээрт, нийт хувьцааны ихэнх хувь нь цөөн хувьцаа эзэмшигчдийн гарт төвлөрч байгаа нь бусад хөрөнгө оруулагчдад маш бага хувь ногдуулдаг бөгөөд энэ нь хөрвөх чадварыг бууруулдаг. Хоёрдугаарт, бусад хөрөнгө оруулагчдад компанийн үйл ажиллагааг хянахад саад тотгорыг бий болгодог байна.

Бүртгэлтэй хувьцаа: Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид 2018 оны байдлаар нийт 328 ХК-ийн 17 их наяд төгрөгийн зах зээлийн

үнэлгээ бүхий 31,516,707,371 ширхэг үнэт цаас хадгалагдаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 154 дугаар тогтоолд заасны дагуу төвлөрсөн хадгаламжид бүртгэлтэй “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нийт 15,000,000,000 ширхэг хувьцааны төрийн мэдлийн 9,780,711,099 ширхэг хувьцааг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн эзэмшилд шилжүүлж, 20 хувь буюу 3,000,000,000 ширхэг хувьцааг арилжигдаагүй үлдэгдэлээр бүртгэсэн болно.

Хүснэгт 6: Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд бүртгэлтэй хувьцаа /мянган ширхэгээр/

Үзүүлэлт	2015	2016	2017	2018
1. Бүртгэлтэй хувьцаа				
Төрийн мэдлийн бус хувьцаа	2,809,930	4,160,854	4,979,552	8,210,132
Төрийн мэдлийн хувьцаа	2,246,316	2,818,124	3,018,287	3,018,287
Орон нутгийн оролцоотой	29,046	29,046	29,046	29,046
Нийт	5,085,292	7,008,024	8,104,956	11,257,464
2. Биржийн бус зах зээлд бүртгэлтэй үнэт цаас				
Эрдэнэс Тавантолгой /Иргэн/	2,558,176	2,212,224	2,212,224	2,212,224
Эрдэнэс Тавантолгой /ААН/	5,139	5,203	7,065	7,065
Эрдэнэс Тавантолгой /Төр/	12,436,685	12,782,573	-	-
Эрдэнэс Тавантолгой /"Эрдэнэс Монгол" ХХК/	-	-	9,780,711	9,780,711
Эрдэнэс Тавантолгой /Гаргаагүй үлдэгдэл/	-	-	3,000,000	3,000,000
Нийт	15,000,000	150,000,000	15,000,000	15,000,000
Хаалттай ХК	172,753	174,958	5,214,500	20,181,172
Нийт	172,753	174,958	5,214,500	20,181,172

“Монголын үнэт цаасны бирж” дээр 1 ХК бүртгэлтэй байна. Үүнд:

“Анд-Энерги” ХК	78,070,758
-----------------	------------

Эх сурвалж: “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК

Бүртгэлтэй бонд: 2018 жилийн эцсийн байдлаар Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэлтэй бондыг дараах байдлаар хүснэгтлэн харууллаа.

Хүснэгт 7: Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд бүртгэлтэй бонд /мянган ширхгээр/


Үзүүлэлт	2015	2016	2017	2018
1. Бүртгэлтэй үнэт цаас				
Засгийн газрын бонд	2,415	2,808	3,567	974
Компанийн бонд	283	233	293	333
Нийт	2,698	3,041	3,860	1,307
2. Биржийн бус зах зээлд бүртгэлтэй үнэт цаас				
Компанийн бонд	20,668	21,870	29,679	29,715
Засгийн газрын бонд	2,314	3,725	1,988	181
Нийт	22,982	25,595	31,667	28,896

Эх сурвалж: “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК

Данс эзэмшигчид: Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш төвлөрсөн хадгаламжид өссөн дүнгээр нийт 1,304,371 данс, 160,805 холболтын данс нээгдсэн. Нийт нээгдсэн данснаас 1,299,268 дотоодын иргэн, 2,198 гадаадын иргэн, 2,712 дотоодын аж ахуйн нэгж, 193 гадаад аж ахуйн нэгжийн данс тус тус нээгдсэн байна.

Тайлант хугацаанд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид нийт 398,255 данс шинээр нээгдсэнээс 398,081 нь дотоодын иргэн, 80 нь гадаадын иргэн, 88 нь дотоодын аж ахуйн нэгж, 6 гадаадын аж ахуйн нэгжийн данс тус тус эзэлж байна. Мөн 17,561 холболтын данс шинээр нээгдсэн.

Зураг 46: Шинээр нээгдсэн данс



Эх сурвалж: “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК

3.2. ХАА–Н ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

2018 оны жилийн эцсийн байдлаар Хөдөө аж ахуйн биржийн гишүүн 12 брокерийн компани Хорооноос тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаагаа явуулж байна. Тэдгээрээс 4 брокер хөдөө орон нутагт байрладаг ба баруун бүсэд 2,

зүүн бүсэд 1, төвийн бүсэд 1 брокер тус тус үйл ажиллагаагаа явуулж байна. Харин үлдсэн 8 брокер Улаанбаатар хотод төвлөрөн ажилладаг байна.

Зураг 47: Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-дын байршлын тархалт /газар зүйн байршлаар/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

3.3. ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Даатгалын нягтралын үзүүлэлт буюу нэг хүнд ногдох хураамжийн орлогын харьцаа нь салбарын хүртээмж, эрэлтийг илэрхийлдэг. Хүн амын тоог

жилд нэг удаа тооцдог тул даатгалын нягтралыг улирлаар тооцох боломжгүй юм. Иймд 2017 оны жилийн эцсийн байдлаар үзүүлээ.

Зураг 48: Даатгалын нягтрал /төгрөгөөр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2017 оны жилийн эцэст нэг хүнд ногдох даатгалын хураамжийн хэмжээ 45,419 төгрөг байсан бол 2018 оны жилийн эцэст 10,815 төгрөгөөр буюу 23.8 хувиар өсөж 56,234 төгрөгт хүрэв. Даатгалын нягтралыг ангиллаар авч үзвэл, нэг хүнд ногдох ердийн даатгалын хураамж 24.3 хувиар өсөж 55,240 төгрөг болсон бол урт


хугацааны даатгалын хураамж 8.8 хувиар өсөж 447 төгрөгт хүрсэн байна.

Даатгалын мэргэжлийн оролцогчдын салбар нэгж: Даатгалын үйлчилгээний хүртээмжийг илэрхийлэгч өөр нэгэн үзүүлэлт нь даатгалын компанийн салбар, зуучлагчдын тоо юм. Даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгч

компаниудын нийт 594 салбар, төлөөлөгчийн газар 21 аймаг болон Улаанбаатар хотод байршиж байна. Эдгээр салбарыг бүсээр ангилан харвал хангайн бүсэд хамгийн их буюу 92, төвийн бүсэд

132, баруун бүсэд 66, зүүн бүсэд хамгийн бага буюу 50 салбар, төлөөлөгчийн газар тус тус үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 49: Даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгчдийн салбар, төлөөлөгчийн газар /бүсээр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант хугацаанд Улаанбаатар хотод нийт даатгалын компанийн 47, даатгалын зуучлагчийн 174, хохирол үнэлэгчийн 31 салбар бүртгэгдсэн. Эдгээрийг дүүргээр ангилан үзвэл салбар нэгжийн 92 хувь нь төвийн 6 дүүрэгт төвлөрсөн

байна. Түүнчлэн даатгалын компанийн төлөөлөгчийн газар 12 байгаагаас БНСУ болон БНХАУ-д тус тус нэг төлөөлөгчийн газар үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 50: Даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгчдийн салбаруудын байршил /дүүргээр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ШИГТГЭЭ 2.

ДААТГАЛЫН ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛСНААР НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ЗЕРЭГ НӨЛӨӨЛӨЛ

Даатгалын хүртээмжийг сайжруулснаар ядуурлыг бууруулах, нийгэм болон эдийн засгийн хөгжлийг сайжруулах, хүн амын эрүүл мэндийг сайжруулах, цаг уурын өөрчлөлт, хүнсний аюулгүй байдлыг хангах зэрэг төрийн бодлогын томоохон зорилтуудыг дэмжихэд чухал ач холбогдолтой. Орчин үед олон нийтийн сүлжээ ашиглаж сурталчилгаагаа явуулснаар даатгалын байгууллагууд нь зорилтот зах зээлдээ илүү сайн хүрч, маркетингийн зардлаа ч бууруулж чадаж байна. Даатгалын байгууллагууд нь олон нийтийн сүлжээнээс гадна Том Өгөгдөл /Big Data/, Робот зөвлөх /Robo Advisors/, платформ бизнес зөвлөх гэх мэт маш олон төрлийн дижитал мэдээлэл, үйлчилгээнүүдийг ашиглаж байна. Жишээ нь Big Data-г тусгайлан бүтээгдэхүүн, үйлчилгээ санал болгохдоо даатгалын байгууллага нь эрсдэлийг хэмжих, үнэлэлт хийх, нэхэмжлэл таамаглах, залилан илрүүлэхэд ашигладаг бол робот зөвлөх нь хүний оролцоогүйгээр мэдээллийг хэрэглэгчдэд автоматаар түргэн, шуурхайгаар хүргэдэг. Даатгалын байгууллага нь олон нийтийн сүлжээ ашиглан мэдээлэл, харилцаа холбоогоо сайжруулснаар хэрэглэгч даатгалын талаарх өөрийн туршлага, мэдээллээ сайжруулан даатгалын үйлчилгээг илүү ихээр авах боломжтой болж байна.


Эх сурвалж: www.iaisweb.org

3.4. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Монгол Улсын 21 аймагт ББСБ-ын үйл ажиллагаа явуулж буй хэдий ч дийлэнх хувь нь Улаанбаатар хотод ажиллаж байна. Улаанбаатар хотын хэмжээнд 466 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа бол орон нутгийн

хэмжээнд нийт 73 байгууллага иргэдэд банк бус санхүүгийн үйлчилгээг хүргэж байна. Дараах зурагт банк бус санхүүгийн байгууллагуудын байршлын тархалтыг Монгол улсын газрын зурагт харууллаа.


Зураг 51: ББСБ-уудын тархалт /газар зүйн байршлаар/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Улаанбаатарт үйл ажиллагаагаа явуулж буй 466 банк бус санхүүгийн байгууллагуудын 34.5 хувь нь Сүхбаатар дүүрэгт, 31.8 хувь нь Чингэлтэй дүүрэгт, 14.8 хувь нь Баянгол дүүрэгт, 10.9 хувь нь Баянзүрх дүүрэгт, 6.0 хувь нь Хан-Уул дүүрэгт, 1.7 хувь нь Сонгино хайрхан дүүрэгт, 0.2 хувь нь Багануур дүүрэгт тус тус үйл ажиллагаагаа явуулж байна.

Зураг 52: ББСБ-уудын тархалт /дүүргээр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Банк бус санхүүгийн байгууллагуудын хүртээмж, газарзүйн байршлаар: Монгол улсын хэмжээнд 18-64 насны 100,000 иргэнд 41 банк бус санхүүгийн байгууллага, 1000 аж ахуй нэгжид 27 банк бус санхүүгийн байгууллага ногдож байна. Харин орон нутгийн хэмжээнд уг харьцаанууд нь

14, 5 байгаа бөгөөд бүс нутгийн хувьд Зүүн бүс 100,000 иргэнд 18, 1000 аж ахуй нэгжид 7 банк бус санхүүгийн байгууллага ногдож байгаагаар банк бус санхүүгийн байгууллагын хүртээмжээр тэргүүлж байна.

Зураг 53: 18-64 насны 100000 хүн ам болон 1000 ААН-д ногдох ББСБ-ын тоо /бүсээр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Улаанбаатар хотын хэмжээнд 18-64 насны 100,000 хүн ногдох банк бус санхүүгийн байгууллагын тоо 72, 1000 аж ахуй нэгжид ногдох банк бус санхүүгийн байгууллагын тоо 11 байна.

Дүүргээр нь авч үзвэл энэхүү үзүүлэлтүүдээр Чингэлтэй болон Сүхбаатар дүүргүүд тэргүүлж байна.

Зураг 54: Улаанбаатар хот дахь 18–64 насны 100000 хүн ам болон 1000 ААН–д ногдох ББСБ–ын тоо / дүүргээр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зээлийн үйлчилгээний тархалт: Банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэж зээлдэгчдийн тоо өмнөх оноос 2.2 дахин нэмэгдэж 234.1 мянгад хүрлээ. Эдийн засгийн идэвхтэй хүн ам буюу 18–64 насны хүн амын тоог зээлдэгчдийн тоонд харьцуулсан дүн 8 байна. Өөрөөр хэлбэл улсын хэмжээнд 18–64 насны 8 хүн тутмын нэг нь банк бус санхүүгийн байгууллагын зээлийн үйлчилгээг хүртэж байна. Харин орон нутагт уг харьцаа 136, Улаанбаатар хотын хэмжээнд 4 байна.

Банк бус санхүүгийн байгууллагаас зээл авсан иргэдийн тоо нэмэгдсэн нь санхүүгийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэж буйг илэрхийлж

байгаа хэдий ч энэ нь нөгөө талаасаа иргэдийн өрийн дарамтыг нэмэгдүүлэх эрсдэлтэйг харуулдаг. Тийм учраас бид нэг зээлдэгчид ногдох зээлийн хэмжээг зайлшгүй харах шаардлагатай юм. Тайлант онд Монгол улсын хэмжээнд банк бус санхүүгийн байгууллагаас нэг зээлдэгч дунджаар 3.7 сая төгрөгийн зээл авсан бол орон нутагт энэхүү үзүүлэлт 3.3 сая төгрөг, Улаанбаатар хотын хувьд улсын дундажтай ижил буюу 3.7 сая төгрөгийн зээлтэй байна байна. Харин уг үзүүлэлт өмнөх онд 5.9 сая төгрөг байсан ба 2018 онд банк бус санхүүгийн байгууллагаас зээл авсан нэг зээлдэгчид ногдох зээлийн дундаж хэмжээ 1.6 дахин буурсан байна.

Зураг 55: ББСБ–уудын зээлийн дундаж хэмжээ ба 18–64 насны хүн ам болон зээлдэгчдийн тооны харьцаа, байршлаар /сая төгрөгөөр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


Банк бус санхүүгийн байгууллагуудын хүртээмж хүн амын үзүүлэлтээр: Банк бус санхүүгийн байгууллагуудын нийт харилцагчдын 48.3 хувь нь эмэгтэй, 51.5 хувь нь эрэгтэй байна. Нийт

зээлдэгчдийн 53.9 хувь нь 18–35 насны, 27.1 хувь нь 36–45 насны, 14.2 хувь нь 46–55 насны, үлдсэн буюу 4.9 хувь нь 55–аас дээш насны хүмүүс байна.

Зураг 56: ББСБ–уудын харилцагчид /хүйсээр/




Зураг 57: ББСБ–уудын зээлдэгчид /насны бүлгээр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Дээд боловсролтой иргэд бусад бүлэгтэй харьцуулахад банк бус санхүүгийн байгууллагуудаас илүү зээл авч байна. Тухайлбал 2018 оны байдлаар банк бус санхүүгийн байгууллагаас зээл авсан иргэдийн 60.7 хувь нь дээд боловсролтой, 8.4 хувь нь тусгай дунд боловсролтой, 24.6 хувь нь бүрэн дунд боловсролтой, 6.0 хувь нь дунд түвшний боловсролтой иргэд байна.

Зураг 58: ББСБ–уудын зээлдэгчид /боловсролын бүлгээр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Дижитал санхүүгийн үйлчилгээний хүртээмж: Технологид суурилсан дижитал санхүүгийн үйлчилгээ нь сүүлийн жилүүдэд дэлхийн санхүүгийн салбарыг хурдтайгаар өөрчилж байгаа бөгөөд энэхүү хөгжлийг даган банк бус санхүүгийн байгууллагууд ч дижитал санхүүгийн үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэж эхлээд байна.


шийдэж өгдөг онцлогтой ба эдгээр байгууллагын хэрэглэгчдийн авсан зээл салбарын зээлийн нийт үлдэгдлийн 2.6 хувьтай тэнцүү байна. Харин гар утсанд суурилсан зээлийн үйлчилгээг авсан нэг иргэнд ногдох зээлийн дүн 210.5 мянга байна.

2018 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд 2 банк бус санхүүгийн байгууллага гар утсанд суурилсан зээлийн үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэж байгаа ба нийт зээлдэгчдийн 46.2 хувь нь уг үйлчилгээг хүртэж байна.


Дижитал санхүүгийн үйлчилгээг хэрэглэгчдэд хүйсийн ялгаа байхгүй буюу нийт хэрэглэгчдийн 50.2 хувь нь эрэгтэй, 49.8 хувь нь эмэгтэй байна. Харин зээлийн чанараар нь ангилан харвал нийт зээлдэгчдийн 92.5 хувь нь хэвийн, 4.7 хувь нь хугацаа хэтэрсэн, 2.8 хувь нь чанаргүй зээлдэгчид байна.

Гар утсанд суурилсан зээлийн үйлчилгээ нь бага дүнтэй, богино хугацаатай зээлийг түргэн шуурхай

Зураг 59. Дижитал санхүүгийн үйлчилгээ хэрэглэгчид /хүйсээр/



Зураг 60. Дижитал санхүүгийн үйлчилгээ хэрэглэгчид /зээлийн чанараар/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


18–35 насны иргэд дижитал санхүүгийн үйлчилгээг бусад бүлгээс илүү хэрэглэж байна. Тухайлбал 2018 оны жилийн эцсийн байдлаар гар утсанд суурилсан зээлийн үйлчилгээг хэрэглэгчдийн 66.8 хувь нь 18–35 нас, 20.2 хувь

нь 36–45 нас, 9.8 хувь нь 46–55 насны иргэд байна. Харин нийт зээлдэгчдийн 67.4 хувь нь дээд боловсролтой, 29.2 хувь нь бүрэн дунд, 1.5 хувь нь тусгай дунд боловсролтой байна.

Зураг 61. Дижитал санхүүгийн үйлчилгээ хэрэглэгчид /насны ангиллаар/



Зураг 62. Дижитал санхүүгийн үйлчилгээ хэрэглэгчид /боловсролын түвшнээр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

3.5. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Хадгаламж, зээлийн хоршоодын хүртээмж, газарзүйн байршлаар: Тайлант онд нийт тусгай зөвшөөрөлтэй хадгаламж, зээлийн хоршоодын 176 ХЗХ нь нийслэл Улаанбаатар хотод, 103 ХЗХ нь хөдөө, орон нутагт үйл ажиллагаа явуулж байна. Газарзүйн байршлаар харвал, 21 аймагт

бүгдэд нь ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаа ба баруун бүсэд харьяалагдах хадгаламж, зээлийн хоршоод 2017 оны жилийн эцсийн байдлаар 32 байсан бол тайлант онд 7 ХЗХ нэмэгдэж 39 болсон байна.

Зураг 63: ХЗХ-дын тархалт /газарзүйн байршлаар/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нийт хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын 37.9 хувь нь баруун бүсэд, 29.1 хувь

нь хангайн бүсэд, 23.3 хувь нь төвийн бүсэд, 9.7 хувь нь зүүн бүсэд байршиж байна.


Хүснэгт 8: ХЗХ-дын тархалт /бүсээр/

Байршил	2017	2018	Өөрчлөлт	
	ХЗХ-ны тоо	ХЗХ-ны тоо	Дүн	Хувь
Баруун бүс	32	39	7	21.9%
Зүүн бүс	13	10	-3	-23.1%
Хангайн бүс	29	30	1	3.4%
Төвийн бүс	24	24	-	-
Төвийн дүүрэг	177	161	-16	-9.0%
Алслагдмал дүүрэг	15	15	-	-

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Харин Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 176 ХЗХ-ны 21.6 хувь нь Сүхбаатар дүүрэгт, 18.2 хувь нь Чингэлтэй дүүрэгт, 8.0 хувь нь Баянгол дүүрэгт, 18.2 хувь нь Баянзүрх дүүрэгт, 10.8 хувь нь Хан-Уул дүүрэгт, 14.8 хувь нь Сонгинохайрхан дүүрэгт, 4.5 хувь нь Багануур дүүрэгт, 2.8 хувь нь Налайх дүүрэгт, 1.1 хувь нь Багахангай дүүрэгт тус тус байршиж байна.

Зураг 64: ХЗХ-дын тархалт /дүүргээр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хадгаламж, зээлийн хоршооны гишүүдийг 18–64 насны хүн амд харьцуулан тооцсон хүртээмжийн үзүүлэлт нь тайлант онд улсын хэмжээнд 3.2 хувь, хөдөө орон нутагт 2.2 хувь, Улаанбаатар хотод 4.6 хувь байна. Энэхүү үзүүлэлтийг газарзүйн

байршлаар харвал, төвийн дүүргүүдэд хамгийн их буюу 4.6 хувьтай байгаа бол захын 3 дүүрэгт 4.5 хувьтай байна. Харин төвийн бүсэд хамгийн бага буюу 1.1 хувьтай байгаа бол хамгийн их нь баруун бүсэд 4.5 хувьтай байна.

Зураг 65: 18–64 насны хүн амын тоонд нийт гишүүдийн эзлэх хувь /бүсээр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хадгаламж, зээлийн хоршоод иргэн, аж ахуйн нэгжид санхүүгийн үйлчилгээ үзүүлж ажиллах нь хүртээмжийн нэг чухал үзүүлэлт бөгөөд үүнийг 18–64 насны 10,000 хүнд ногдох, 100 ААН–д ногдох ХЗХ–ны тоогоор илэрхийлж болно. Монгол улсын хэмжээнд 18–64 насны 10,000 хүнд

1.6 ХЗХ, 100 ААН–д 0.4 ХЗХ ногдож байна. Харин орон нутгийн хэмжээнд уг харьцаанууд нь 1.1, 0.4 байгаа бөгөөд хөдөө орон нутгийн 4 бүсийн хувьд Баруун бүс 10,000 хүнд 1.8, 100 ААН–д 0.6 ХЗХ ногдож хүртээмжээр тэргүүлж байна.

Зураг 66: 100 ААН болон 10000 хүнд ногдох ХЗХ–ны тоо /бүсээр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

100 ААН–д ногдох ХЗХ–ны тооны үзүүлэлтээр Багахангай дүүрэг 2.6, Багануур дүүрэг 1.7 буюу бусад дүүргийн үзүүлэлтээс хамгийн өндөр дүнтэй байгаа бол Баянгол болон Сонгинохайрхан дүүргүүд хамгийн бага үзүүлэлттэй байна. Харин 18–64 насны 10,000 хүнд ногдох ХЗХ–ны

тоогоор Багахангай дүүрэг 7.6, Сүхбаатар болон Багануур дүүрэг 4.4 дүнгээр хамгийн өндөр байгаа бол Баянгол дүүрэг мөн адил хамгийн бага үзүүлэлттэй байна. Энэхүү үзүүлэлтүүдээр Багахангай болон Багануур дүүргүүд тэргүүлж байна.

Сураг 67: 100 ААН болон 10000 хүнд ногдох ХЗХ-ны тоо /дүүргээр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зээлийн үйлчилгээний хүртээмж: ХЗХ-дын зээлийн үйлчилгээний хүртээмжийг 18–64 насны хүн амын тоог зээлдэгчдийн тоонд харьцуулсан дүнгээр тооцоход тайлант онд 66 байна. Энэ нь улсын хэмжээнд 18–64 насны 66 хүн тутмын нэг нь ХЗХ-нд гишүүнчлэлтэй, зээлийн үйлчилгээг хүртэж байна гэсэн үг. Харин хөдөө, орон нутаг

уг харьцаа 116 байгаа бол Улаанбаатар хотын хэмжээнд 43 байна. Улаанбаатар хотын хэмжээнд ХЗХ-ноос зээл авсан нэг зээлдэгч гишүүн дунджаар 5.8 сая төгрөгийн зээлтэй байгаа бол хөдөө орон нутагт энэ дүн бага буюу 1.9 сая төгрөг байна.

Сураг 68: ХЗХ-дын зээлийн үйлчилгээний хүртээмж /байршлаар/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хадгаламжийн үйлчилгээний хүртээмж: ХЗХ-дын хадгаламжийн үйлчилгээний хүртээмжийг 18–64 насны хүн амын тоог хадгаламж эзэмшигчдийн тоонд харьцуулан тооцоход тайлант онд 51 байна. Энэ нь улсын хэмжээнд 18–64 насны 51 хүн тутмын нэг нь ХЗХ-нд гишүүнчлэлтэй, хадгаламжийн үйлчилгээг хүртэж байна гэсэн үг.

Улаанбаатар хотын хэмжээнд уг харьцаа 33 байгаа бол хөдөө, орон нутагт 91 байна. Улаанбаатар хотын хэмжээнд ХЗХ-нд хадгаламжтай нэг хадгаламж эзэмшигч гишүүн дунджаар 4.9 сая төгрөгийн хадгаламжтай байгаа бол хөдөө орон нутагт энэ дүн бага буюу 1.2 сая төгрөг байна.

Зураг 69: ХЗХ-дын хадгаламжийн үйлчилгээний хүртээмж /байршлаар/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


ХЗХ-дын гишүүдийн хүртээмж: ХЗХ-дын нийт гишүүдийн 55.9 хувь нь эмэгтэй, 43.9 хувь нь эрэгтэй байгаа ба үлдсэн 0.2 хувь нь хуулийн этгээд байна. Нийт гишүүдийн 30.1 хувь нь 18–35

насны, 30.2 хувь нь 36–45 насны, 24.0 хувь нь 46–55 насны, үлдсэн буюу 15.7 хувь нь 55–аас дээш насны хүмүүс байна.

Зураг 70: ХЗХ-дын гишүүд /хүйсээр/



Зураг 71: ХЗХ-дын гишүүд /насны бүтцээр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

3.6. ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

2018 оны жилийн эцсийн байдлаар жилийн туршид гаргасан батлан даалтын 69.8 хувь нь буюу 113 нь Улаанбаатар хотод олгосон батлан


даалт байсан бол 7 нь Баруун бүсэд, 22 нь Хангайн бүсэд, 17 нь төвийн бүсэд, 3 нь зүүн бүсийн аймгуудад гаргасан батлан даалт байна.

Зураг 72: Шинээр гаргасан батлан даалтын тоо /газар зүйн байршлаар/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зураг 73: Шинээр гаргасан батлан даалтын тоо /дүүргээр/




Тайлант оны туршид олгосон батлан даалтын тооноос харахад Баянзүрх дүүрэгт хамгийн их буюу 30, Баянгол, дүүрэгт 25, Сонгинохайрхан дүүрэгт 19, Сүхбаатар дүүрэгт 15, Хан-Уул дүүрэгт 13, Чингэлтэй дүүрэгт 9, Налайх дүүрэгт 2 батлан даалтыг гаргасан бол Багануур, Багахангай дүүрэгт батлан даалт гаргаагүй байна.

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Олгосон батлан даалтын дүнг газар зүйн байршлаар харахад төвийн бүсэд хамгийн их батлан даалт гарсан ба нийт 6.0 тэрбум төгрөгийн зээлд 3.4 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан

байна. Харин зүүн бүсийн хувьд хамгийн бага буюу 559.9 сая төгрөгийн зээлд 330.4 сая төгрөгийн батлан даалт олгосон байна.

Зураг 74: Олгосон батлан даалтын хэмжээ, бүсээр /тэрбум төгрөгөөр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Улаанбаатар хотын хувьд Баянзүрх дүүрэгт хамгийн өндөр буюу 12.0 тэрбум төгрөгийн зээлд 6.9 тэрбум төгрөгийн батлан даалт гарсан

бол Налайх дүүрэгт хамгийн бага буюу 732.3 сая төгрөгийн зээлд 439.4 сая төгрөгийн батлан даалт гаргасан байна.

Зураг 75: Олгосон батлан даалтын хэмжээ, дүүргээр /тэрбум төгрөгөөр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


Нэг батлан даалтад ногдох дүнгээр Улаанбаатар хотын хувьд Хан-Уул дүүрэг хамгийн өндөр буюу 300 сая байгаа бол Чингэлтэй дүүрэгт хамгийн бага буюу 193.1 сая төгрөг байна. Харин бүс нутгаар үзвэл Хангайн бүс нэг батлан даалтад

олгосон дүнгээр хамгийн бага буюу 70.8 сая төгрөг байна. Харин уг үзүүлэлт Төвийн бүсэд хамгийн өндөр дүнтэй байгаа буюу нэг батлан даалтын дундаж дүн 200.5 сая төгрөг байна.

Зураг 76: Нэг батлан даалтын дундаж хэмжээ / дүүргээр/



Зураг 77: Нэг батлан даалтын дундаж хэмжээ / бүсээр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

НИЙТ АРИЛЖААНЫ ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН

245.5 ТЭРБУМ ТӨГРӨГ

ҮҮНЭЭС:



КОМПАНИЙН БОНДЫН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН:
1.7 ТЭРБУМ ТӨГРӨГ




ХУВЬЦААНЫ ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН:
210.3 ТЭРБУМ ТӨГРӨГ



ЗАСГИЙН ГАЗРЫН БОНДЫН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН:
33.5 ТЭРБУМ ТӨГРӨГ

ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ /тэрбум төгрөг/



TOP 20

ИНДЕКС

2017 20,736.9 нэгж

2018 21,466.8 нэгж



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
26.7 ТЭРБУМ ТӨГРӨГ



МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ БИРЖ
АНХНЫ КОМПАНИЙН БОНД
1.0 ТЭРБУМ ТӨГРӨГ

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АРИЛЖААНД ЭЗЛЭХ ХУВЬ

ГАДААДЫН ИРГЭН

2.8%

ДОТООДЫН ИРГЭН


20.0%

ГАДААДЫН ААН

36.4%

ДОТООДЫН ААН


40.8%




ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ



САЛБАРЫН ХӨРӨНГӨ /тэрбум төгрөг/




НИЙТ ХУРААМЖИЙН ОРЛОГО /тэрбум төгрөг/



Даатгалын салбарын нийт хураамжийн орлого

23.8%-аар өсөв

ДААТГАЛЫН НӨӨЦ САН /тэрбум төгрөг/




НИЙТ НӨХӨН ТӨЛБӨР

58.2

ТЭРБУМ ТӨГРӨГ



ХОХИРОЛ НӨХӨЛТИЙН ХАРЬЦАА





Ердийн даатгалын компани	15
Урт хугацааны даатгалын компани	1
Давхар даатгалын компани	2
Даатгалын зуучлагч компани	49
Даатгалын хохирол үнэлэгч компани	27
Даатгалын төлөөлөгч	2430




БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА




НИЙТ ХӨРӨНГӨ /тэрбум төгрөг/



ББСБ-УУДЫН ХАРИЛЦАГЧИД



ХУУЛИЙН ЭТГЭЭД





ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО


2017

2018

153.1
ТЭРБУМ ТӨГРӨГ

ХӨРӨНГИЙН ӨСӨЛТ
30.7%

200.2
ТЭРБУМ ТӨГРӨГ



НИЙТ ОРЛОГЫН ӨСӨЛТ


29.8%

2017


29.6%

2018

НИЙТ ХАДГАЛАМЖ /тэрбум төгрөг/




НИЙТ ЗЭЭЛ /тэрбум төгрөг/



УЛААНБААТАР ХОТОД **176** ХЗХ
ХӨДӨӨ ОРОН НУТАГТ **103** ХЗХ



Хадгаламж, зээлийн хоршоодын тоо








БҮТЭЭГДЭХҮҮН,
ҮЙЛЧИЛГЭЭ

4.1. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

2018 оны жилийн эцсийн байдлаар нийт 245.5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арилжаа хийгдсэн. Нийт арилжааны үнийн дүнг бүтцээр нь авч үзвэл хувьцааны арилжаа 85.7 хувь, ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаа 13.6 хувь, компанийн бондын зах зээлийн арилжаа 0.7 хувийг тус тус бүрдүүлж байна.

Зураг 78: Нийт арилжааны бүтэц /бүтээгдэхүүнээр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хувьцааны арилжаа: Тайлант жилд МХБ болон МҮЦБ – ээр дамжуулан нийт 210.3 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдсэн бөгөөд

өмнөх оноос 132.2 тэрбум төгрөгөөр өссөн. Энэхүү дүн нь хувьцааны арилжааны түүхэн дэх хамгийн өндөр дүн бүхий арилжаа болсон билээ.

Зураг 79: Хувьцааны арилжаа /тэрбум төгрөгөөр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ЗГҮЦ-ны арилжаа: Тайлант хугацаанд ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаа явагдаагүй байна. ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлд 332.8 мянган ширхэг үнэт цаасыг 33.5 тэрбум төгрөгөөр арилжсан бөгөөд өмнөх оны ЗГҮЦ-ны хоёрдогч

зах зээлийн арилжааны дүнтэй харьцуулахад 108.8 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлт юм. Харин нийт дүнтэй харьцуулахад 739.0 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Зураг 80: Засгийн газрын үнэт цаасны арилжаа /тэрбум төгрөгөөр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Компанийн бондын арилжаа: Тайлант хугацаанд компанийн бондын анхдагч зах зээлийн арилжаагаар 100 мянган ширхэг бондыг 1 тэрбум

төгрөгөөр, хоёрдогч зах зээлийн арилжаагаар 12.9 мянган ширхэг бондыг 697.6 сая төгрөгөөр тус тус арилжаалав.

Зураг 81: Компанийн бондын арилжаа /тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ШИГТГЭЭ 3.

“СҮҮ БОНД”-ЫН ЭРГЭН ТӨЛӨЛТ ХИЙГДЛЭЭ

Үндэсний ууган үйлдвэрийн нэг 60 жилийн түүхтэй “Сүү” ХК-ийн нийтэд санал болгон гаргах 12 сарын хугацаатай, жилийн 17.5%-ийн хүүтэй, нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 60,000 ширхэг “Сүү” бонд өрийн хэрэгслийг 2017 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн тогтоолоор Хороо бүртгэсэн билээ. Ийнхүү гадаад, дотоодын иргэд, ААН-үүдээс нийт 6 тэрбум төгрөгийг татсан нь хамгийн өндөр дүнтэй компанийн бонд болсон юм.


Харин 2018 онд буюу нэг жилийн дараагаар “Сүү” ХК нь бонд эзэмшигчдийнхээ дансанд бондын эргэн төлөлтийг хүүгийн хамтаар буюу 7.05 тэрбум төгрөгийг байршуулснаар хөрөнгө оруулагчдынхаа өмнө хүлээсэн үүргээ 100 хувь биелүүллээ.

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хэмжээ: 2018 оны жилийн эцсийн байдлаар хувьцааны, ЗГҮЦ-ны болон компанийн бондын хоёрдогч зах зээлийн нийт арилжааны дүнд хөрөнгө

оруулагчдын эзлэх хувиар ангилан авч үзвэл дотоодын иргэн 20.0 хувь, дотоодын ААН 40.8 хувь, гадаадын иргэн 2.8 хувь, гадаадын ААН 36.4 хувийг тус тус бүрдүүлсэн байна.

Зураг 82: Хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хувь



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хувьцаат компанийн мэдээлэл: Тайлант хугацаанд СЗХ-ны үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд нийт 305 компани бүртгэлтэй байна. Харин арилжаа

эрхлэх байгууллагад 217, ҮЦТХТ–д 328 ХК тус тус бүртгэлтэй байна.

Хүснэгт 9: Үнэт цаас гаргагчийн өмчийн бүтэц

Үнэт цаас гаргагчийн өмчийн бүтэц	СЗХ	Арилжаа эрхлэх байгууллага	“ҮЦТХТ” ХХК
Төрийн өмчит	31	18	21
Төрийн өмчийн оролцоотой	19	11	23
Хувийн өмчит	255	188	284
Нийт	305	217	328


Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

4.2. ХАА–Н ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

ХАА–н гаралтай бараа, түүхий эдийн арилжаа: 2013 оны 4 дүгээр сард биржээр дамжин зөвхөн нэг төрлийн түүхий эд буюу ямааны ноолуур арилжаалагддаг байсан бол 2018 оны жилийн эцсийн байдлаар бараа бүтээгдэхүүний төрөл нэмэгдэж 8 төрлийн хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд арилжаалагддаг болсон. Үүнд: ямааны ноолуур, хонины ноос, тэмээний ноос, завод ноос, бодын хөөвөр, мал бэлтгэл, хүнсний буудай болон тосны ургамал зэрэг багтдаг. Завод ноос нь адуу болон үхрийн, хонины, ямааны,

сарлагийн, тэмээний гэж 5 ангилалддаг бол бодын хөөвөр нь сарлагийн, адууны, үхрийн гэсэн 3 ангилалд хуваагддаг. Тайлант жилд Хөдөө аж ахуйн биржээр нийт 711.4 тэрбум төгрөгийн үнэ бүхий ямааны ноолуур, хонины ноос, тэмээний ноос, завод ноос, бодын хөөвөр арилжаалагдсан бөгөөд нийт арилжааг бүтцээр ангилан үзвэл 83.1 хувийг ямааны ноолуур, 8.4 хувийг завод ноос, 7.9 хувийг хонины ноос 0.6 хувийг тэмээний ноос, 0.1 хувийг бодын хөөвөр тус тус эзэлж байна.

Зураг 83: Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн арилжаа /тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

4.3. ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Даатгалын зах зээл дээр ердийн, урт хугацааны нийт 23 хэлбэрийн даатгалын бүтээгдэхүүн арилжаалагдаж байна. Жолоочийн хариуцлагын


албан журмын даатгалаас бусад бүх хэлбэрийн даатгал нь сайн дурын үндсэн дээр хийгдэж байгаа билээ.

Тайлант хугацаанд даатгалын зах зээлийн хэмжээнд нийт 178.7 тэрбум төгрөгийн хураамжийн орлоготой ажилласнаас ердийн даатгал 175.5 тэрбум төгрөг буюу нийт хураамжийн орлогын 98.2 хувь, урт хугацааны даатгал 1.4 тэрбум төгрөг буюу 0.8 хувь, давхар даатгал 1.7 тэрбум төгрөг буюу 1 хувийг бүрдүүлэв. Харин нийт нөхөн төлбөрийн зардалд ердийн даатгал 57.1 тэрбум төгрөг буюу 98.1

хувь, урт хугацааны даатгал 559.3 сая төгрөг буюу 1 хувийг, давхар даатгал 521.9 сая төгрөг буюу 0.9 хувийг эзэлж байна.

Даатгалын компанийн хураамжийн орлогын 70 гаруй хувийг хөрөнгийн даатгал, жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, авто тээврийн хэрэгслийн даатгал болон гэнэтийн осол, эмчилгээний даатгал бүрдүүлж байна.

Зураг 84: Даатгалын хураамжийн орлого /бүтээгдэхүүнээр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Харин нийт нөхөн төлбөрийн зардалын бүтцийн хувьд эхний дөрвөн даатгалын бүтээгдэхүүн нийт нөхөн төлбөрийн зардлын 80 орчим хувийг бүрдүүллээ. Нийт хураамжийн орлогын бүтцэд хөрөнгийн даатгал, нийт нөхөн төлбөрийн зардалд жолоочийн хариуцлагын албан журмын

даатгал хамгийн их хувийг эзэлж байна. Түүнчлэн тайлант жилд барилга угсралтын даатгалын нөхөн төлбөрийн зардал нэмэгдсэн ба 2017 онд нийт нөхөн төлбөрийн зардлын 4 хувь байсан бол 2018 онд 14.5 болж өсжээ.


Зураг 85: Даатгалын нөхөн төлбөрийн зардал /бүтээгдэхүүнээр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Албан журмын даатгал: Манай улсад энэхүү даатгалын бүтээгдэхүүн 2012 оноос бий болсон бөгөөд албан журмын даатгалын нэг бүтээгдэхүүн

үйлчилгээ байгаа нь жолоочийн албан журмын хариуцлагын даатгал юм.



Жолоочийн хариуцлагын даатгалын хураамжийн орлого 2017 онд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 9.5 хувийн өсөлтийг үзүүлж байсан бол тайлант онд 8.3 хувийн өсөлттэй байлаа. Улмаар жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нийт хураамжийн орлого тайлант онд 33 тэрбум төгрөг болж, нийт даатгалын хураамжийн орлогын 18.5 хувийг эзэлж байна. Харин нөхөн төлбөрийн хувьд өнгөрсөн онд 4.7 хувийн өсөлттэй байсан бол энэ онд 10 хувиар өсөж, 17.1 тэрбум төгрөгт хүрсэн нь салбарын нийт нөхөн төлбөрийн зардлын 29.3 хувийг бүрдүүлжээ. Сүүлийн гурван жилийн статистикийг үзэхэд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамжийн орлогын өсөлт удаахрах хандлагатай байгаа бол нөхөн төлбөрийн зардлын өсөлт эрчимжих төлөвтэй байна.

Тус даатгалын бүтээгдэхүүний нөхөн төлбөр болон хураамжийн орлогын харьцаа 2016 оноос эхлэн харьцангуй тогтворжих төлөвтэй байгаа ба сүүлийн 5 жилийн дунжийг авч үзвэл 56 хувь байгаа юм. Харин тайлант онд дундажаас ялимгүй доогуур 51.7 хувийн үзүүлэлттэй байлаа.

Даатгалын зуучлагчид: Тайлант онд даатгалын зуучлагчид нийт 66.2 их наяд төгрөгийн үнэлгээ бүхий даатгалын бүтээгдэхүүнийг зуучилж, зуучилсан даатгалын хураамжийн орлогын дүн 48.6 тэрбум төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оноос 14.3 хувиар өссөн үзүүлэлт байлаа. Харин даатгалын зуучлагчдын зуучлалын шимтгэлийн орлого өнгөрсөн онд 7.1 тэрбум төгрөг байсан бол тайлант онд өмнөх оноос 2.2 тэрбум төгрөг буюу 31.3 хувиар өсөж 9.4 тэрбум төгрөгт хүрэв.

Сүүлийн 3 жилийн зуучилсан даатгалын хураамжийн орлого болон зуучлалын шимтгэлийн орлогыг даатгалын бүтээгдэхүүний зах зээлд эзлэх хувь хэмжээгээр харьцуулсан үзүүлэлтийг доорх графикт дүрсэллээ. Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ зах зээлд нэвтэрч, иновацийн шинэчлэлт хийгдсэнтэй холбоотойгоор даатгалын зах зээлийн бүтцэд 2010 оноос хойш нилээдгүй өөрчлөлт орсон. Тухайлбал 2010 онд хөрөнгийн даатгал зуучилсан даатгалын хураамжийн орлогын 60 орчим хувийг бүрдүүлж байсан бол 2018 онд зах зээлийн 18 хувийг эзэлж байна. 2014 оноос хойш зах зээл дэх төвлөрөлт саарч, даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээний төрөлжилт бий болсноор даатгалын нэг бүтээгдэхүүний зах зээлд давамгайлах хандлага өөрчлөгдөх болсон.

Зураг 87: Зуучилсан даатгалын нийт хураамжийн орлого /бүтээгдэхүүнээр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зураг 88: Зуучлалын шимтгэлийн орлого /бүтээгдэхүүнээр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Даатгалын зуучлагчдын хувьд жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, хөрөнгийн даатгал, зээлийн даатгал, авто тээврийн хэрэгслийн даатгалын бүтээгдэхүүн нь нийт зуучилсан хураамжийн орлого болон зуучлалын шимтгэлийн орлогын дийлэнхи хэсгийг бүрдүүлж байна.


Харин сүүлийн жилүүдэд бусад даатгалын бүтээгдэхүүн, тэр дундаа гэнэтийн осол эмчилгээний даатгал, агаарын хөлгийн даатгалын зуучлалын зах зээлд эзлэх хувь өсөх төлөвтэй байна. Тухайлбал 2018 онд зуучилсан даатгалын хураамжийн орлогын 4.6 хувийг гэнэтийн осол эмчилгээний даатгал, 2.8 хувийг агаарын хөлгийн даатгал тус тус эзэлж байна.

Даатгалын хохирол үнэлэгчид: Тайлант онд даатгалын хохирол үнэлэгч компаниуд нийт

26,392 хохирлыг 47.2 тэрбум төгрөгөөр үнэлэв. Нийт хохирол үнэлгээний орлого өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 259.1 сая төгрөгөөр буюу 33.7 хувиар өсөж, 1 тэрбум төгрөгт хүрэв. Энэхүү өсөлтийн 39.9 хувийг авто тээврийн хэрэгслийн даатгал, 29.7 хувийг жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, 12.9 хувийг барилга угсралтын даатгалын хохирол үнэлгээний орлогын өсөлт бүрдүүллээ.


Тайлант улирлын даатгалын хохирол үнэлгээний орлогын бүтцийг авч үзвэл жолоочийн хариуцлагын албан журмын даатгал 52.4 хувь, авто тээврийн хэрэгслийн даатгал 25.6 хувь, хөрөнгийн даатгал 10.3 хувь, авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал 8.2 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 89: Даатгалын хохирлын тоо /бүтээгдэхүүнээр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зураг 90: Даатгалын хохирол үнэлгээний орлого /бүтээгдэхүүнээр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

4.4. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Бүтээгдэхүүн, үйлчилгээ: Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд зааснаар Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж буй банк бус санхүүгийн байгууллагууд зээл, төлбөрийн баталгаа гаргах, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах, цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, гадаад валютын арилжаа, итгэлцлийн үйлчилгээ, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр мэдээлэл зөвлөгөө өгөх,

факторингийн үйлчилгээ, үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үндсэн үйл ажиллагаа гэсэн үндсэн 10 үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхэлж байна. Эдгээр үйл ажиллагаанаас зээлийн үйл ажиллагааг нийт 492 банк бус санхүүгийн байгууллага, гадаад валютын арилжааг 157 банк бус санхүүгийн байгууллага дагнан болон бусад төрлийн үйлчилгээтэй хавсран эрхэлж байна.


Зураг 91: ББСБ-уудын тоо /үйлчилгээний төрлөөр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


Бүтээгдэхүүн, үйлчилгээний орлого: 2018 оны жилийн эцсийн байдлаар банк бус санхүүгийн байгууллагуудын нийт орлого 259.5 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд нийт орлогын 96.7 хувийг үндсэн үйл ажиллагааны орлого буюу хүүгийн болон хүүгийн бус орлого бүрдүүлж байна. Үүнээс нийт орлогын 83.8 хувь буюу 217.4 тэрбум төгрөгийг хүүгийн орлого, 12.9 хувь нь буюу 33.5 тэрбум төгрөгийг хүүгийн бус орлого бүрдүүлж байна.

Зураг 92: ББСБ-ын салбарын нийт үйл ажиллагааны орлого /төрлөөр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зураг 93: ББСБ-ын салбарын нийт хүүгийн бус орлого




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Факторингийн үйлчилгээ: Өмнө дурдсанчлан банк бус санхүүгийн байгууллагуудын дийлэнх нь зөвхөн зээлийн үйлчилгээг эрхэлж орлогын ихэнх хувиа хүүгийн орлогоос олдог. Гэхдээ банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасны дагуу банк бус санхүүгийн байгууллагууд нь нийт 10 төрлийн үйл ажиллагааг эрхлэх боломжтой байдаг ба цөөн тооны байгууллагууд факторинг, итгэлцэл, болон мөнгөн гуйвуулга, валютын үйлчилгээг дагнан болон бусад үйлчилгээтэй хавсран эрхэлж байна.

Факторингийн үйлчилгээ гэдэг нь зээлдүүлэгч буюу үүрэг гүйцэтгүүлэгчээс мөнгөн төлбөрийн үүргийг шаардах эрхээ гуравдагч этгээдэд бүхэлд нь худалдах, энэхүү эрхийг хүлээн авагч нь эрхээ хэрэгжүүлэх болон үүсэн гарах үр дагаврыг бүхэлд нь хариуцах үйл ажиллагааг хэлдэг. 2018 оны жилийн эцсийн байдлаар салбарын хэмжээнд нийт 7.3 тэрбум төгрөгийн факторингийн цэвэр авлага бүртгэлтэй байна.

Зураг 94: Факторингийн үйлчилгээний цэвэр авлага /сая төгрөгөөр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Итгэлцлийн үйлчилгээ: Итгэлцлийн үйлчилгээ гэдэг нь итгэл хүлээлгэгчийн активыг үнэгүйдлээс хамгаалж, ашиг олж өгөх зорилгоор тэдгээртэй харилцан тохиролцсон гэрээний үндсэн дээр итгэл хүлээгчээс нэр бүхий активыг түр хугацаанд хянах, ашиглах, захиран зарцуулах үйл ажиллагааг хэлдэг.

Салбарын хэмжээнд нийт 30 банк бус санхүүгийн байгууллага итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг эзэмшиж байгаа хэдий ч тайлант онд 24 банк бус санхүүгийн байгууллага уг үйлчилгээг эрхэлж байна. Тэдгээрийн үзүүлсэн итгэлцлийн үйлчилгээний нийт өглөг 57.6 тэрбум төгрөг байгаа ба өмнөх оноос 46.9 хувиар өссөн дүнтэй байна.

Зураг 95: Итгэлцлийн үйлчилгээний өглөг /тэрбум төгрөгөөр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ: Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн дагуу банк бус санхүүгийн байгууллагууд нь мөнгөн гуйвуулга, цахим төлбөр тооцооны үйлчилгээг эрхлэх боломжтой байдаг бөгөөд салбарын хэмжээнд нийт 30 байгууллага уг үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаагаас

тайлант онд 11 нь уг үйлчилгээнээс орлого олсон байна.

2018 оны байдлаар банк бус санхүүгийн байгууллагууд мөнгөн гуйвуулгын үйлчилгээнээс нийт 1.3 тэрбум төгрөгийн орлогыг олжээ.

Зураг 96: Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг /сая төгрөгөөр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Гадаад валют арилжааны үйлчилгээ: Салбарын хэмжээнд 157 банк бус санхүүгийн байгууллага гадаад валют арилжааны үйлчилгээг дагнан болон бусад төрлийн үйлчилгээтэй хавсран эрхэлж байна. 2018 оны жилийн эцсийн байдлаар эдгээр байгууллагууд нийт 1061.3 тэрбум төгрөгтэй тэнцэхүйц гадаад валютыг худалдаж аван, 1061.6 тэрбум төгрөгтэй тэнцэхүйц гадаад валютыг худалдан борлуулсан байна.

Тайлант онд нийт 13 төрлийн валютаар арилжаа хийгдсэнээс хамгийн өндөр дүнтэй нь БНХАУ-ын юань байгаа ба нийт 449.5 тэрбум төгрөгийн юанийг худалдан авч, 454.8 тэрбум төгрөгийн юанийг худалдан борлуулсан байна. БНХАУ-ын юанийн дараагаар хамгийн их арилжаалагдсан валют нь америк доллар болон евро байна.

Зураг 97: Гадаад валют арилжааны худалдаж авсан, худалдсан дүн /тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

4.5. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй 279 ХЗХ хадгаламж, зээлийн гэсэн үндсэн үйл ажиллагаа эрхлэхээс гадна нэмэлтээр төслийн санхүүжилтийн үйлчилгээ, төсөл хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх үйлчилгээ, санхүүгийн түрээсийн үйлчилгээ, даатгалын төлөөлөгчийн

үйлчилгээг эрхлэн явуулж байна. Тайлант онд төслийн санхүүжилтийн үйлчилгээ эрхэлж буй 113 ХЗХ, санхүүгийн түрээсийн үйлчилгээ эрхэлж буй 3 ХЗХ, даатгалын төлөөлөгчийн үйлчилгээ эрхэлж буй 3 ХЗХ байна.

Хүснэгт 10: ХЗХ-дын тоо /үйл ажиллагааны төрлөөр/

Үйл ажиллагаа	ХЗХ-дын тоо
Хадгаламж, зээл	279
Төслийн санхүүжилтийн үйлчилгээ	113
Санхүүгийн түрээсийн үйлчилгээ	3
Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа	3


Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хадгаламж, зээлийн хоршоодын хүүгийн орлого өнгөрсөн онтой харьцуулахад 31.2 хувиар өсөж 39.6 тэрбум төгрөгт хүрчээ. Нийт хүүгийн орлогын 92.5 хувийг зээлийн хүүгийн орлого эзэлж байна. Түүнчлэн хүүгийн орлогыг бүрдүүлэгч зээлийн нэмэгдүүлсэн хүүгийн орлого өнгөрсөн оноос 27.2 хувиар буурч 239.5 сая төгрөгт хүрсэн бол

банк санхүүгийн байгууллагаас авсан хүүгийн орлого 94.0 хувиар өсөж 2.7 тэрбум төгрөг, санхүүгийн түрээсийн орлого 245.0 мянган төгрөг хүрчээ. Харин хүүгийн цэвэр орлого өнгөрсөн оноос 17.7 хувиар өсөж тайлант онд 16.5 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Зураг 98: ХЗХ-ны салбарын хүүгийн орлогын бүтэц /хувиар/

- Зээлийн хүүгийн орлого
- Банк, санхүүгийн байгууллагаас авсан хүүгийн орлого
- Зээлийн нэмэгдүүлсэн хүүгийн орлого




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хадгаламж, зээлийн хоршоодын хүүгийн зардал өнгөрсөн онтой харьцуулахад 42.9 хувиар өсөж 23.1 тэрбум төгрөгт хүрсэн байна. Нийт хүүгийн зардлын 97.7 хувийг хадгаламжийн хүүгийн зардал эзэлж байна. Мөн хүүгийн зардлын 1.9

хувийг эзэлж буй банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүүгийн зардал өмнөх оноос 21.7 хувиар өсөж 448.7 сая төгрөг болсон бол санхүүгийн түрээсийн хүүгийн зардал 25.9 сая төгрөгт хүрсэн нь хамгийн өндөр өсөлт буюу 156.2 хувиар өсжээ.

Зураг 99: ХЗХ-ны салбарын хүүгийн зардлын бүтэц /хувиар/

- Хадгаламжийн хүүгийн зардал
- Банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүүгийн зардал
- Санхүүгийн түрээсийн хүүгийн зардал
- Бусад хүүгийн зардал



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ШИГТГЭЭ 4.

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН ДУНДЫН КАҮА ТӨЛБӨР ТООЦООНЫ СИСТЕМ

Филиппин улсын хадгаламж, зээлийн хоршоодын сургалтын төвүүдийн үндэсний холбоо /NATCCO/ нь Азийн хадгаламж, зээлийн хоршоодын холбоо /ACCU/-той хамтран KAYA payment platform буюу ХЗХ-дын дундын төлбөр тооцооны системийг 2017 онд үүсгэж, 2018 оны 8 дугаар сарын байдлаар Филиппин улсын 74 ХЗХ-дыг тус системдээ нэгтгэн 151 агенттайгаар үйл ажиллагаа явуулж байна. Ингэснээр нэг санхүүгийн байгууллагаас гарах технологийн зардлыг бууруулж, нэгдсэн аюулгүй байдлын системийг бүрдүүлэх эхний алхмыг хийсэн байна.

KAYA систем нь Филиппин улсын төв банкны төлбөр, тооцооны системээс тусдаа ХЗХ-дын бие даасан төлбөр, тооцооны систем ба үүлэн тооцоололд суурилсан /cloud based/ платформ юм. Мөн ХЗХ-д зах зээлээ өргөжүүлж, санхүүгийн үйлчилгээгээ гишүүддээ хүргэх үр ашгийг дээшлүүлэх, онлайнаар төлбөр тооцоо хийх, вэб дээр суурилан теллер, мобайл банк, АТМ, дебит карт, ПОС-ын гүйлгээ, даатгал зэрэг үйлчилгээг хийх боломж бүхий систем юм. KAYA системд данс нээж бүртгүүлэхийн тулд ХЗХ-ны гишүүд 100 песо буюу ойролцоогоор 1.9 ам.доллар байршуулах, идэвхтэй үүрэн холбооны дугаартай байх гэсэн маш хялбар нөхцөлөөр бүртгүүлж, үйлчилгээ авах боломжтой болдог байна.


Эх сурвалж: www.kayapayment.wordpress.com

4.6. ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

2018 онд батлан даалт гаргуулах нийт 356 хүсэлт ирснээс 162 хүсэлт нь зөвшөөрөгдсөн байна. 2018 он гарснаар батлан даалтын үйлчилгээг хүсэгчдийн тоо эрс өссөн байна. Тухайлбал 2017

онд ердөө 107 батлан даалтын хүсэлт ирсэн бол тайлант онд уг үзүүлэлт 3.3 дахин нэмэгдсэн байна.

Зураг 100: Батлан даалт гаргуулахаар ирүүлсэн хүсэлтийн тоо




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант онд шинээр гаргасан батлан даалтын хэмжээг эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудаар ангилан харвал нийт дүнгийн дийлэнх нь буюу 49.3 хувь нь үйлдвэрлэлийн салбарт, 25.8 хувь нь үйлчилгээний салбарт, 19.6 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 4.3 хувь нь хөдөө аж ахуйн салбарт

үлдсэн 0.9 хувь нь бусад салбаруудад олгогдсон байна. 2016 оны эхэн үед хөдөө аж ахуйн салбарт батлан даалт түлхүү гаргаж байсан бол сүүлийн үед үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт гаргасан батлан даалт, нийт батлан даалтын дийлэнх хэсгийг бүрдүүлж байна.

Зураг 101: Шинээр гаргасан батлан даалт /эдийн засгийн салбараар/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2016 оны сүүл үеэс эхлэн батлан даалт гаргах дундаж хугацаа өссөн дүнтэй байгаа ба 2018

оны 4 дүгээр улиралд гаргасан батлан даалтын дундаж хугацаа 97.4 сар буюу 8.1 жил байна.

Зураг 102: Батлан даалт гаргах дундаж хугацаа




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2018 оны Сангаас гаргасан батлан даалтын 43.2 хувийг Худалдаа хөгжлийн банк, 33.7 хувийг Төрийн банк, 11.3 хувийг Хас банк, 6.0 хувийг

Капитрон банк, 4.9 хувийг Хаан банкны зээлд гаргасан батлан даалт тус тус бүрдүүлж байна.

Зураг 103: Шинээр гаргасан батлан даалт /арилжааны банкаар/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо





АШИГТ


АЖИЛЛАГАА

5.1. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Тайлант хугацаанд хөрөнгийн зах зээлд 54 ҮЦК тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байна. 2018 оны жилийн эцсийн ҮЦК-уудын нийт орлого 13.1 тэрбум төгрөг, нийт зардал 9.5 тэрбум төгрөг, цэвэр ашиг 2.5 тэрбум төгрөг байна.

Тайлант хугацаанд ҮЦК-уудын нийт хөрөнгө 85.4 тэрбум төгрөг байгаа бөгөөд хөрөнгийн бүтцийн 89.9 хувийг эргэлтийн хөрөнгө, 10.1 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлсэн байна.

Зураг 104: Үнэт цаасны компаниудын орлогын болон балансын тайлангийн үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2018 жилийн эцсийн байдлаар ҮЦК-уудын орлого 13.1 тэрбум төгрөг. Орлогын бүтцийг тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаанаас олсон орлогоор авч үзвэл хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа 34.2 хувь, брокерийн үйл ажиллагаа 33.1 хувь, андерайтерийн үйл ажиллагаа 8.5 хувь,

бусад орлого 8.2 хувь, хүүний орлого 7.2 хувь, үнэт цаасны арилжааны цэвэр орлого 3.9 хувь, бусад үйл ажиллагаа 3.0 хувь, түрээсийн орлого 1.1 хувь, дилерийн үйл ажиллагааны орлого 0.8 хувь, ногдол ашгийн орлого 0.1 хувийг эзэлж байна.

Зураг 105: Үнэт цаасны компаниудын орлогын бүтэц




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант онд ҮЦК-уудын нийт зардал 9.5 тэрбум төгрөг байсан. Нийт зардлын бүтцийг авч үзвэл борлуулалт, маркетингийн болон ерөнхий ба

удирдлагын зардал 92.6 хувь, санхүүгийн зардал 4.7 хувь, бусад зардал 2.7 хувийг эзэлж байна.

Зураг 106: Үнэт цаасны компаниудын зардлын бүтэц



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант хугацаанд салбарын нэгтгэлд хамрагдсан нийт 53 ҮЦК-уудаас 22 үнэт цаасны компани алдагдалтай, 30 үнэт цаасны компани ашигтай, 1 компани ашиггүй ажилласан байна. Алдагдалтай ажилласан үнэт цаасны компаниудын хувьд,

албан татвар төлбөр хураамжийн зардал, түрээсийн болон ашиглалтын зардал зэрэг тогтмол шинжтэй үйл ажиллагааны зардлуудаас хамааран алдагдал хүлээсэн байна.

Хүснэгт 11: Үнэт цаасны компаниудын орлогын хураангуй тайлан /тэрбум төгрөгөөр/

	2017	2018	Зөрүү
Нийт орлого	9.26	13.12	3.86
Үйл ажиллагааны орлого	6.61	10.96	4.35
Түрээсийн орлого	0.16	0.14	-0.02
Хүүгийн орлого	1.28	0.94	-0.34
Ногдол ашгийн орлого	0.86	0.01	-0.85
Бусад орлого	0.35	1.07	0.72
Нийт зардал	7.21	9.49	2.28
Борлуулалт маркетингийн болон ерөнхий ба удирдлагын зардал	6.33	8.79	2.46
Санхүүгийн зардал	0.76	0.45	-0.31
Бусад зардал	0.12	0.25	0.13
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-0.01	0.04	0.05
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.11	-0.1	-0.21
Бусад ашиг (алдагдал)	-0.81	-0.65	0.16
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1.34	2.91	1.57
Татварын зардал	0.27	0.39	0.12
Татварын дараах ашиг (алдагдал)	1.07	2.52	1.45
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1.07	2.52	1.45

Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

2017 оны жилийн эцсийн байдлаар нийт 52 ҮЦК компани үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд 2018 оны жилийн эцсийн байдлаар ҮЦК-уудын нийт орлого 2017 оны мөн үеийнхээс 4.16 тэрбум төгрөгөөр өссөн. Уг өсөлтөд үйл ажиллагааны орлого 4.65 тэрбум төгрөгөөр өссөн нь голчлон


нөлөөлөв. Харин нийт зардал өмнөх оны мөн үеийнхээс 2.59 тэрбум төгрөгөөр өсөхөд борлуулалт маркетингийн болон ерөнхий зардал 2.75 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлөв. Мөн тайлант үеийн цэвэр ашиг 1.44 тэрбум төгрөгөөр өсчээ.

5.2. ХАА-Н ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Тайлант онд хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийн зах зээлд зуучлалын үүрэг гүйцэтгэх нийт 12 брокерийн компани Хорооноос тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж

байна. 2018 жилийн эцсийн байдлаар нэгтгэлд хамрагдсан компаниудын нийт хөрөнгийн дүн 1.6 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

Зураг 107: Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-дын тайлангийн үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагчдын нийт орлого 0.14 тэрбум төгрөг байгаа бөгөөд борлуулалтын орлого болон хүүгийн орлогоос бүрдсэн. Харин нийт зардал 0.15 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд борлуулалт, маркетингийн зардал,

ерөнхий ба удирдлагын зардал болон бусад зардлаас бүрдсэн байна. Мөн тайлант онд компаниуд нийт 1.23 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ.


5.3. ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Тайлант онд даатгалын компаниудын цэвэр ашиг өмнөх онтой харьцуулахад 5.2 тэрбум төгрөгөөр буюу 39.7 хувиар өсөж 18.4 тэрбум төгрөг болсон байна. Татварын дараах цэвэр ашгийн өсөлтийг бүлэглэн авч үзвэл хасах өсөлттэй буюу цэвэр ашгийн хэмжээ буурсан 8 даатгалын компани, 50% хүртэлх өсөлттэй 5 даатгалын компани, 50%-100%-ийн өсөлттэй 1 даатгалын компани, 100%-аас дээш өсөлттэй 3 даатгалын компани байна. Ердийн даатгалын компаниудын татварын

дараах цэвэр ашгийн хэмжээ дунджаар 1.9 дахин өсжээ.

“ХААДД” ХК-ийн хувьд өмнөх онтой харьцуулахад татварын дараах цэвэр ашгийн хэмжээ 6 хувиар буюу абсолют дүнгээр 262.7 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй гарчээ. Харин урт хугацааны даатгалын компанийн ашгийн үзүүлэлт тайлант онд 49 хувийн буюу 88.4 сая төгрөгийн бууралттай байлаа.

Зураг 108: Даатгалын салбарын татварын дараах цэвэр ашиг



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Голлох харьцаанууд: Хохирол нөхөлтийн харьцаа тайлант онд өнгөрсөн онтой харьцуулахад ялимгүй өссөн үзүүлэлттэй байв. Энэ нь нийт нөхөн төлбөрийн зардал 28.7 хувиар, орлогод тооцсон хураамж 27.5 хувиар өссөнтэй, өөрөөр хэлбэл орлогод тооцсон хураамжийн өсөлт нөхөн төлбөрийн зардлын өсөлтөөс илүү бага байсантай холбоотой юм.


Сүүлийн жилүүдэд даатгагчид үйл ажиллагааны зардлыг хамгийн оновчтой түвшинд хүргэхийг зорих болсон нь зардлын харьцааг сайжрахад түлхэц өгч байна. 2015 онтой харьцуулахад зардлын харьцаа 67.5 хувиас 46.6 хувь болж буурчээ. Даатгалын компаниуд зардлын удирдлагаа сайжруулан, өсөлтийг дэмжих шинэ

бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлснээр энэхүү харьцааг цаашид ч бууруулах боломжтой юм.

Салбарын хэмжээнд зардлын хосолсон харьцааг авч үзвэл нөхөн төлбөр болон үйл ажиллагааны зардал нийт орлогод тооцсон хураамжийн орлогын 101.6 хувьтай тэнцэв. Зардлын хосолсон харьцаа 2017 онд өссөн үзүүлэлттэй байсан бол тайлант онд буурсан байна.

Даатгалын салбарын цэвэр ахиуц ашгийн харьцаа тайлант онд өссөн үзүүлэлттэй байна. 2016 онд цэвэр ахиуц ашиг 10 хувь, 2017 онд буурч 9.1 хувь болж байсан бол тайлант онд эргэн өсөж 10.3 хувьд хүрлээ.

Зураг 109: Цэвэр ахиуц ашиг, хосолсон харьцаа




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Ашигт ажиллагааны коэффициент: Салбарын өөрийн хөрөнгийн өгөөж 2010 онд хамгийн өндөр буюу 22.7 хувь байсан бол 2014 онд уг үзүүлэлт буурч 3 хувьд хүрсэн билээ. 2014 оноос хойш өөрийн хөрөнгийн өгөөжийн харьцаа өсөх хандлагатай байгаа бөгөөд тайлант хугацаанд өмнөх оноос 1.4 пунктээр өссөнөөр 13.1 хувьд хүрсэн үзүүлэлттэй байна.

Нийт хөрөнгийн өгөөж болон өөрийн хөрөнгийн өгөөжийн графикийн чиглэлд ижил төлөв ажиглагдаж байна. 2014 онд нийт хөрөнгийн өгөөж хамгийн доод цэгтээ буюу 1.4 хувьд хүрсэн боловч дараах жилүүдэд сэргэж эхэлсэн. Тайлант хугацаанд нийт хөрөнгийн өгөөж өмнөх оны мөн үеэс 0.3 пунктээр өсөж 5.6 хувьтай байна.

Зураг 110: Нийт хөрөнгө, өөрийн хөрөнгийн өгөөж




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

5.4. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Банк бус санхүүгийн байгууллагуудын ашиг, түүний өсөлт: Тайлант онд банк бус санхүүгийн байгууллагуудын нийт орлого өмнөх оноос 32.5 хувиар өсөж 259.5 тэрбум төгрөгт хүрсэн бол, нийт зарлага өмнөх оноос 22.7 хувиар өсөн

158.4 тэрбум төгрөгт хүрчээ. Ингэснээр банк бус санхүүгийн байгууллагуудын нийт цэвэр ашиг өмнөх оноос 51.4 хувиар өсөн 101.1 тэрбум төгрөг болсон байна.

Зураг 111: ББСБ-уудын орлого, зарлага, ашгийн динамик /тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


Салбарын хэмжээнд 539 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаагаас 461 банк бус санхүүгийн байгууллага нь 109.0 тэрбум төгрөгийн

ашигтай, 65 банк бус санхүүгийн байгууллага нь 7.9 тэрбумын алдагдалтай ажиллаж, харин 13 банк бус санхүүгийн байгууллага нь тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй байна.

Нийт хөрөнгийн болон өөрийн хөрөнгийн өгөөж: Банк бус санхүүгийн салбарын хэмжээнд нийт хөрөнгийн өгөөж өмнөх оноос 1.6 пунктээр өсөж

7.0 хувь, өөрийн хөрөнгийн өгөөж 1.9 пунктээр өсөж 8.9 хувь тус тус хүрсэн байна.

Зураг 112: ББСБ-ын салбарын нийт болон өөрийн хөрөнгийн өгөөж




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


ББСБ-уудын нийт болон өөрийн хөрөнгийн өгөөжийг тооцоход 30.8 хувь нь 1 хувиас доош, 24.5 хувь нь 1-5 хувь, 16.9 хувь нь 5-10 хувь, 27.8 хувь нь 10 хувиас дээш нийт хөрөнгийн өгөөжтэй

ажилласан бол 30.1 хувь нь 1 хувиас бага, 23.4 хувь нь 1-5 хувь, 17.3 хувь нь 5-10 хувь, 29.3 хувь нь 10 хувиас дээш өөрийн хөрөнгийн өгөөжтэй ажилласан байна.

Зураг 113: ББСБ-уудын ангилал /нийт хөрөнгийн өгөөжөөр/



Зураг 114: ББСБ-уудын ангилал /өөрийн хөрөнгийн өгөөжөөр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зураг 115: ББСБ-уудын хөрөнгийн өгөөжийн медиан утга /хувь нийлүүлсэн хөрөнгөөр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Банк бус санхүүгийн байгууллагуудын нийт болон өөрийн хөрөнгийн өгөөжийг хувь нийлүүлсэн хөрөнгийн ангиллаар харахад 1 тэрбумаас доош хувь нийлүүлсэн хөрөнгөтэй банк бус санхүүгийн байгууллагуудын тал хувь нь 1.1 хувиас бага нийт хөрөнгийн өгөөжтэй, 1-2.5 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй банк бус санхүүгийн байгууллагуудын тал хувь нь 4.9 хувиас бага нийт хөрөнгийн өгөөжтэй, 2.5 тэрбум төгрөгөөс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй банк бус санхүүгийн байгууллагуудын тал хувь нь 8.8 хувиас бага нийт хөрөнгийн өгөөжтэй байна.

Зардал, орлогын харьцаа: Банк бус санхүүгийн байгууллагууд нэг төгрөгийн орлого олохын тулд дунджаар хэдэн төгрөгийн зардал гаргаж буйг тооцдог харьцаа болох зардал, орлогын харьцаа тайлант онд 44.9 хувь гарсан буюу өмнөх оноос 2.8 нэгжээр буурчээ. Өөрөөр хэлбэл банк бус санхүүгийн байгууллагууд 100 төгрөгийн орлого

олохын тулд дунджаар 45 төгрөгийн зардал гаргаж байна гэсэн үг юм. Тайлант онд банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн хүү буурсан байхад зардал орлогын харьцаа нь мөн буурсан нь банк бус санхүүгийн байгууллагуудын үр ашигт байдал нэмэгдэж буйг харуулж байна.

Зураг 116: Банк бус санхүүгийн байгууллагуудын зардал, орлогын харьцаа




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

5.5. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Хадгаламж, зээлийн хоршоодын нийт орлого, зардал: Сүүлийн 10 жилийн хугацаанд салбарын нийт орлого, зардал аажмаар өссөөр байгаа ба тайлант онд нийт ХЗХ-д 41.2 тэрбум төгрөгийн орлого, 35.9 тэрбум төгрөгийн зардал, 5.3 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Харин цэвэр ашгийн нийт орлогод эзлэх хувь

өмнөх оноос 4 пунктээр буурч 12.9 хувьд хүрчээ. Салбарын хэмжээнд нийт 279 ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаагаас 198 ХЗХ нь 5.6 тэрбум төгрөгийн ашигтай, 73 ХЗХ 0.3 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан бол 8 ХЗХ үйл ажиллагаа явуулаагүй байна.

Зураг 117: ХЗХ-дын орлого ба зардал /тэрбум төгрөгөөр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хадгаламж, зээлийн хоршоодын цэвэр ашиг: Тайлант онд ХЗХ-дын нийт орлого өмнөх оноос 29.6 хувиар өсөж 41.2 тэрбум төгрөгт хүрсэн бол нийт зарлага 36.5 хувиар өсөж 35.9 тэрбум төгрөгт хүрчээ. Эндээс салбарын нийт цэвэр ашиг 5.3 тэрбум төгрөгт хүрснээр өнгөрсөн онтой харьцуулахад 3.7 хувиар буурсан үзүүлэлттэй

байна. Энэхүү цэвэр ашгийн бууралтад санхүүгийн түрээсийн хүүгийн зардлын 2.6 дахин өсөлт, болзошгүй эрсдэлийн сангийн зардлын 1.7 дахин өсөлт, ажилтнуудад олгосон нөхөн олговрын зардлын 11.4 дахин өсөлт, торгуулийн зардлын 7.2 дахин өсөлт зэрэг зардлын өндөр өсөлтүүд нөлөөлжээ.

Зураг 118: ХЗХ-дын ашигт ажиллагааны өсөлт /хувиар/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хадгаламж, зээлийн хоршоодын нийт хөрөнгийн болон өөрийн хөрөнгийн өгөөж: Тайлант онд ХЗХ-дын өөрийн хөрөнгийн өгөөж нь өмнөх

онтой харьцуулахад 3.7 пунктээр буурч 18.7 хувьд хүрсэн бол нийт хөрөнгийн өгөөж нь 1.2 пунктээр буурч 3.4 хувьд хүрчээ.

Зураг 119: ХЗХ-ны салбарын нийт болон өөрийн хөрөнгийн өгөөж /хувиар/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Голлох харьцаанууд: Тайлант онд гишүүдэд олгож буй зээлийн хүүгийн орлогын нийт зээлд эзлэх хувь өмнөх оноос 0.9 пунктээр өсөж 29.6 хувьд хүрчээ. Энэхүү үзүүлэлт нь ХЗХ-д зээлийн үйлчилгээнээс олж буй дундаж орлогыг харуулдаг ба эндээс тайлант онд ойролцоогоор

100 төгрөгийн зээлийн үйлчилгээнээс олсон орлого нь 29.6 төгрөг байна. Харин цэвэр ашгийг нийт орлогод харьцуулан тооцдог цэвэр ахиуц ашгийн харьцаа нь өмнөх оноос 4.4 пунктээр буурч 12.9 хувь болсон байна.

Зураг 120: ХЗХ-ны салбарын хүүгийн орлогын хувь болон цэвэр ахиуц ашгийн харьцаа /хувиар/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зардал, орлогын харьцаа: Энэхүү харьцаа нь ХЗХ-д нэг төгрөгийн орлого олохын тулд дунджаар хэдэн төгрөгийн зардал гаргаж буйг тооцдог ба тайлант онд тус үзүүлэлт 22.9 хувь гарч

өмнөх оноос 2.1 пунктээр буурчээ. Энэ нь ХЗХ-д 100 төгрөгийн орлого олохын тулд дунджаар 23 төгрөгийн зардал гаргаж байна гэсэн үг юм.

Зураг 121: ХЗХ-дын зардал, орлогын харьцаа




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

5.6. ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

2018 оны жилийн эцсийн байдлаар зээлийн батлан даалтын сан 3.8 тэрбум төгрөгийн орлого олж, 1.9 тэрбум төгрөгийн зардалтай ажилласнаар 1.8 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Үндсэн үйл ажиллагааны орлогын 85.9 хувийг

гишүүдийн татварын орлого /хүүгийн орлого/, үлдсэн 14.1 хувийг батлан даалт, хураамж, шимтгэлийн орлого бүрдүүлж байна. Тайлант онд Сангийн цэвэр орлогын дүн өмнөх оноос 1.5 дахин өссөн дүнтэй байна.

Зураг 122: Ашигт ажиллагаа /тэрбум төгрөгөөр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2018 оны жилийн эцсийн байдлаар Сангийн нийт хөрөнгийн өгөөж 3.9 хувьтай байгаа ба өмнөх

улирлаас 2.0 нэгжээр өссөн, өмнөх оноос 4.4 нэгжээр буурсан дүнтэй байна.

Зураг 123: Нийт хөрөнгийн өгөөж



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо






ТОГТВОРТОЙ
БАЙДАЛ

6.1. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

IPO, SPO түүхэн замнал: “Монголын хөрөнгийн бирж” ХК 1991 онд байгуулагдаж 1992 онд МХБ – ээр дамжуулан 475 улсын өмчит компанийг хувьчилсан түүхтэй. Үүнээс хойш 2005 онд “Монгол шилтгээн” ХК МХБ–ээр дамжуулан анхдагч зах зээлээс хөрөнгө татан төвлөрүүлсэн нь Монголын анхны IPO гаргасан тохиол болсон юм. 2005 оноос хойш 2018 он хүртэл нийт 23 компани ХК IPO гаргаж нийт 114.02 тэрбум төгрөгийн хөрөнгийг анхдагч зах зээлээс татан төвлөрүүлээд байна. 2008 оноос хойш анхдагч зах зээлийн арилжаа төдийлөн идэвхгүй байсан

бөгөөд 2018 онд арилжааны идэвх эргэн сэргэж, 6 компанид нийтэд хувьцаагаа санал болгон гаргах зөвшөөрөл олгосноос 5 компани нь 2018 онд IPO гарган 26.7 тэрбум төгрөгийг амжилттайгаар татан төвлөрүүлээд байна. Энэ нь иргэдийн хөрөнгийн зах зээлийн талаарх мэдлэг, мэдээлэл нэмэгдэж, энэхүү салбарт хөрөнгө оруулах сонирхол нэмэгдсэнтэй холбон тайлбарлаж болох юм. Хөрөнгө оруулагчдын арилжаанд оролцох идэвхи, сонирхол нэмэгдэх нь цаашид зах зээл тогтвортойгоор өсөн дэвжихийн үндэслэл мөн юм.

Зураг 124: IPO түүхэн замнал




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Монголын анхны Follow on Public Offering (FPO) буюу нэмэлт хувьцаа гарган хөрөнгө татан төвлөрүүлэх арилжаа 2007 онд явагдаж байв. 2007 оноос хойш 2018 он хүртэл давхардсан

тоогоор 8 компани 10 удаагийн арилжаагаар нийт 31.6 тэрбум төгрөгийн хөрөнгийг нэмэлт хувьцаа гаргах замаар татан төвлөрүүлжээ.

Зураг 125: FPO түүхэн замнал



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хөрөнгийн зах зээлийн үзүүлэлтүүдийг харьцуулсан нь: Дэлхийн банкнаас гаргасан Дэлхийн санхүүгийн зах зээлийн хөгжлийн тайлан 2017/2018 –д хөрөнгийн зах зээлийн голлох үзүүлэлтүүдийг харьцуулсан байдлаар гаргасан байдаг. Тэдгээр үзүүлэлтүүдийг Хүснэгт 6–д харуулсан бөгөөд үзүүлэлт тус бүрийг дэлхийн дундаж, хөгжсөн орнуудын дундаж, хөгжиж буй орнуудын дундаж болон Зүүн Азийн орнуудын дундажтай харьцуулан гаргалаа.

3ЗҮ–г ДНБ–д харьцуулсан үзүүлэлт Монгол улсад 7.8 хувь байгаа бөгөөд дэлхийн дундажтай харьцуулахад 64.6 пунктээр бага байгаа юм. 3ЗҮ

өндөр 10 компанийг хасаж тооцсон үнэлгээг 3ЗҮ–нд харьцуулсан үзүүлэлт дэлхийн дунджаар 45.7 хувь байгаа бол Монгол улсын хэмжээнд 22.5 хувь байгаа нь 23.2 пунктээр бага байна. Хувьцаа хэр хурдан эргэлдэж байгааг илтгэх хувьцааны хөрвөх чадвар нь дэлхийн улсуудын дунджаар 30.6 хувь байгаа бол Монгол улсад 8.4 хувьтай байна. Харин тухайн улсын хувьцааны гол индексийн стандарт хазайлтыг илтгэх Stock price volatility буюу хувьцааны үнийн хэлбэлзэл нь дэлхийн дундаж үзүүлэлтээр 15.5 байдаг бол Монгол улсад 17.2 байна.

Хүснэгт 12: Хөрөнгийн зах зээлийн хөгжлийн үзүүлэлтүүдийг харьцуулсан нь


	3ЗҮ/ДНБ	3ЗҮ өндөр 10 компанийг оруулалгүйгээр тооцсон үнэлгээг нийт 3ЗҮ–нд харьцуулах нь	Хөрвөх чадвар	Хувьцааны үнийн хэлбэлзэл
Монгол	7.8%	22.5%	8.4%	17.2
Дэлхийн дундаж	72.4%	45.7%	30.6%	15.5
Хөгжсөн орнуудын дундаж	110.8%	43.8%	42.2%	15.6
Хөгжиж буй улсын дундаж	44.8%	48.2%	21.3%	15.4
Зүүн Азийн орнуудын дундаж	73.2%	64.5%	58.8%	16.6

Эх сурвалж: Дэлхийн банк

Хувьцааны үнийн хэлбэлзэл нь тухайн улс орны хувьцааны зах зээлийн тогтвортой байдлыг илтгэх гол үзүүлэлт юм. Тус үзүүлэлт нь тухайн улсын гол хувьцааны индексийн өгөөжийн 360 өдрийн

стандарт хазайлтыг тооцож гаргасан үзүүлэлт юм. Монгол улсын хувьд ТОП 20 индексийн өгөөжийн стандарт хазайлт 2017 онд 17.2 байсан бөгөөд энэ нь дэлхийн дундажтай ойролцоо байгаа юм.

Зураг 126: Хувьцааны үнийн хэлбэлзэл



Эх сурвалж: Дэлхийн банк

6.2. ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Даатгалын компаниудын эрсдэлийн удирдлагын судалгаа: Даатгалын зах зээлийн санхүүгийн тогтвортой байдалд нийгэм эдийн засаг, улс төр, зохицуулалт, байгууллагын дотоод үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт болон үйл ажиллагааны онцлогоос хамаарсан эрсдэлүүд нөлөө үзүүлдэг.

Санхүүгийн зохицуулах хороо 2017, 2018 онуудад даатгалын компаниудад тулгамдаж буй эрсдэлүүд болон эрсдэлийн удирдлагын түвшинг тандах зорилгоор түүвэр судалгааг авсан бөгөөд тус судалгааны хүрээнд бид даатгалын компаниудын эрсдэлийн удирдлагын одоогийн нөхцөл байдал болон ойрын хугацааны түүний хандлагыг илрүүлэх тандалтыг хийхийг зорилоо. Судалгааны асуулга 3 хэсгээс бүрдэх

бөгөөд нэгдүгээр хэсэгт, цаашид судалгааны үр дүнг бүлэглэх болон мэдээллийг задлахад ашиглагдах ерөнхий мэдээлэл; хоёрдугаар хэсэгт даатгалын компаниудын салбарын хэмжээнд эрсдэлийн удирдлагын түвшинг хэрхэн харж буйг тандах асуултууд; гуравдугаар хэсэгт, асуулгад хамрагдсан тухайн даатгалын компанийн эрсдэлийн удирдлагын түвшин, түүний хэмжилт, үнэлгээний аргачлалыг тодруулах асуулгууд багтсан болно.

Энэхүү судалгаанд ердийн даатгалын 15 компани хамрагдсан ба судалгаанд хамрагдсан компаниудыг хураамжийн орлогын тархалтаар ангилахад дараах 3 сегментэд хуваав. Энд хураамжийн орлогыг 2018 оны 3 дугаар улирлын байдлаар авсан болно.

Хүснэгт 13: Даатгалын компанийн хураамжийн орлогын хэмжээ

Хураамжийн орлогын хэмжээ	Компанийн тоо		Компанийн ангилал
	2017	2018	
2 тэрбум төгрөгөөс доош	4	4	<4 тэрбум төгрөг
2 – 4 тэрбум төгрөгийн хооронд	4	2	
4 – 10 тэрбум төгрөгийн хооронд	4	4	4–10 тэрбум төгрөг
10 тэрбум төгрөгөөс дээш	3	5	>10 тэрбум төгрөг

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2017 оны 3 дугаар улирлын байдлаар 4 тэрбум төгрөгөөс бага хураамжийн орлоготой даатгалын компанийн ангилалд 8 ердийн даатгалын компани буюу нийт компаниудын 53.3 хувь хамрагдаж байсан бол 2018 оны мөн үед тус ангилалд багтах компаниудын тоо 2-оор буурч 40 хувьд хүрсэн

байна. Харин 4 тэрбумаас 10 тэрбум төгрөгийн хураамжийн орлоготой даатгалын компанийн тоо хэвээр байгаа бол 10 тэрбум төгрөгөөс дээш хураамжийн орлоготой даатгалын компанийн тоо 2-оор нэмэгдэж, салбарын 33.3 хувийг эзэлж байна.

Зураг 127: Даатгалын компаниудын зах зээлд эзлэх хувь



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


Дийлэнх даатгалын компаниудын хувьд салбарын хэмжээнд эрсдэлийн удирдлагыг ямар нэгэн байдлаар стратегийн зорилт болгон авч үзэж байгаа ба судалгаанд хамрагдсан нийт даатгалын компаниудын 20 хувь нь бүрэн байдлаар, 53 хувь нь хэсэгчилсэн байдлаар эрсдэлийн асуудлыг стратегийн зорилтдоо тусган, холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Судалгааны үр дүнгээс харахад даатгалын компаниудад тулгарч буй гол эрсдэлүүдэд

нэгдүгээрт даатгалын эрсдэл, хоёрдугаарт үйл ажиллагааны эрсдэл, гуравдугаарт хөрвөх чадварын эрсдэлийг онцлон тодорхойлжээ.

Даатгалын компаниудын 80 хувь нь даатгалын эрсдэлийг ач холбогдолтойд тооцсон ба тус эрсдэлийн төрөл нь ач холбогдлын түвшингээрээ бусад эрсдэлээс хамгийн өндөр байна. Харин түүний дараагаар нийт судалгаанд хамрагдагсдын 53.3 хувь нь үйл ажиллагааны эрсдэлийг ач холбогдолтой эрсдэлээр эрэмбэлжээ.

Зураг 128: Даатгалын салбарт түгээмэл тулгардаг эрсдэлүүд /эрсдэлийн төрлөөр/




Эх сурвалж: “Даатгалын компаниудын эрсдэлийн удирдлагын судалгаа” 2017, 2018 СЗХ

Компаниудын хэмжээгээр салбарын эрсдэлийн түвшинг ангилан үзэхэд компанийн хэмжээнээс үл хамааран даатгалын эрсдэл хамгийн ач холбогдолтой, зээлийн эрсдэл хамгийн ач холбогдолгүйд тооцогдсон байна. Нийт 10 тэрбум төгрөгөөс дээш болон 4 тэрбумаас бага хураамжийн орлоготой компаниуд, 4-10 тэрбум төгрөгийн хураамжийн орлоготой компаниудын 75 хувь нь даатгалын эрсдэлийг хамгийн ач

холбогдолтой эрсдэлийн төрлөөр тодорхойлжээ. Харин 10 тэрбумаас дээш орлоготой компаниудын хувьд хөрвөх чадварын эрсдэл хоёрдох ач холбогдолтой эрсдэл байсан бол 4 тэрбумаас бага орлоготой (80 хувь нь) болон 4-10 тэрбум орлоготой (50 хувь нь) компаниудын хувьд үйл ажиллагааны эрсдэлийг хөрвөх чадварын эрсдэлээс илүүд үзсэн байна.

Зураг 129: Даатгалын салбарын эрсдэлийн түвшин /эрсдэлийн төрлөөр/




Эх сурвалж: “Даатгалын компаниудын эрсдэлийн удирдлагын судалгаа” 2017, 2018 СЗХ

Даатгалын компаниудаас тухайн байгууллага эрсдэлийн төрлүүдийн талаарх ойлголттой эсэхийг асуухад 40 хувь нь хангалттай ойлголттой, 47 хувь нь хэсэгчилсэн ойлголттой, 13 хувь нь хангалттай ойлголтгүй гэсэн хариултыг өгсөн байна.

Харин эрсдэл тус бүрээр тухайн эрсдэлийг нарийвчлан тодорхойлж, эрсдэлийн удирдлага хэрэгжүүлж байгаа эсэх болон тоон үнэлгээ хийгддэг, мөн үнэлгээний загвартай эсэхийг тодруулан дэлгэрэнгүй асуухад даатгалын

эрсдэлийн удирдлагын хэрэгжилт бусад эрсдэлийн төрөлтэй харьцуулахад сайн байв. Тухайлбал нийт даатгалын компаниудын 60 хувь нь эрсдэлээ нарийвчлан тодорхойлж, 53 хувь нь эрсдэлийн менежмент хэрэгжүүлэн, тоон үнэлгээ хийж байна гэжээ. Үүний дараагаар эрсдэлээ нарийвчлан тодорхойлсон байдал үйл ажиллагааны эрсдэлийн хувьд өндөр (60 хувь) байгаа боловч эрсдэлийн үнэлгээ хийгдэх байдал сул (27 хувь) байв.

Зураг 130: Даатгалын компаниудын эрсдэлийн ойлголтын түвшин /эрсдэл тус бүрээр/




Эх сурвалж: “Даатгалын компаниудын эрсдэлийн удирдлагын судалгаа” 2017, 2018 СЗХ

Даатгалын компаниудаас эрсдэлийн удирдлага хэрэгжүүлэхэд тулгамдаж буй нөхцөл байдлыг тодорхойлуулахад 73 хувь нь мэдээлэл, тоон өгөгдөлтэй холбогдох хүндрэл, мөн 53 хувь нь эрсдэлийн удирдлагын мэдээллийн системтэй холбогдох хүндрэлүүдийг онцоллоо. Судалгааны үр дүнгээс харахад даатгалын компаниуд үр ашигтай эрсдэлийн удирдлага хэрэгжүүлэхэд дата мэдээлэл болон арга зүйтэй холбоотой хүндрэлүүд тулгамдаж байгаа бөгөөд харин зардал, төсвийн асуудлууд төдийлөн хүндрэл

учруулахгүй байна гэжээ.

Даатгалын компаниудын хувьд 2017 онд даатгалын эрсдэлийг судлах болон үнэлэхэд бусад эрсдэлтэй харьцуулахад хамгийн өндөр буюу нийт хүн цагийн 42.1 хувийг зарцуулдаг гэсэн хариултыг өгч байсан бол 2018 онд тус үзүүлэлт 14.6 пунктээр өсөж 56.7 хувьд хүрсэн үзүүлэлттэй байна. Түүний дараа үйл ажиллагааны эрсдэлд 21.7 хувийг зарцуулдаг бөгөөд тус үзүүлэлт 2017 онд 26.8 хувь байсан ба тайлант онд буурчээ.

Зураг 131: Эрсдэлийн үйл ажиллагаанд зарцуулж буй хүн цаг



Эх сурвалж: “Даатгалын компаниудын эрсдэлийн удирдлагын судалгаа” 2017, 2018 СЗХ

Дээрх эрсдэлийн төрлийн талаар ойлголт даатгалын компаниудын хувь хамгийн өндөр, түүнчлэн үнэлгээний аргачлал, загварчлал бусад эрсдэлийн төрлүүдээс илүү нэвтэрсэн байсан бөгөөд тус үр дүнгээс үзэхэд эдгээр 2 эрсдэлийг үндсэн тулгамдаж буй эрсдэлээр тодорхойлж болохоор байна.

Даатгалын эрсдэл: Даатгалын компаниудын үндсэн эрсдэл бол даатгалын тохиолдол гарах магадлал болон даатгуулагчид нөхөн төлбөр төлөх магадлал юм. Даатгалын компаниуд даатгалын гэрээ, даатгалын тохиолдол, нөхөн төлбөрийн түүхэн мэдээлэлд үндэслэн даатгалын эрсдэлийг тооцоолон даатгалын хураамжийн хувийг тогтоох замаар энэ эрсдэлээс үүсэх зардлыг нөхөхөөр төлөвлөдөг. Даатгалын эрсдэлийг онцлогоос нь хамааран даатгаж болох, даатгаж болохгүй гэж ангилна. Даатгалын эрсдэлд даатгуулагчийн гаргадаг ёс зүйгүй үйлдлүүд болон даатгалын компани даатгалын тохиолдол гаргах өндөр магадлалтай даатгуулагчийг даатгасны улмаас нөхөн төлбөрийн зардал өндөр гарахыг хэлнэ. Эдгээр эрсдэлийг багасгахын тулд даатгуулагчийн буруутай үйлдлээс болж даатгалын тохиолдол үүссэн болон даатгалын тохиолдол үүсэхэд ямар нэгэн байдлаар даатгуулагчаас шалтгаалсан бол даатгагч гэрээнд заасны дагуу нөхөн төлбөр олгохгүй байхаар тусгаж болохыг хууль эрх зүйн хүрээнд зохицуулсан байдаг.

Үйл ажиллагааны эрсдэл: Санхүүгийн зохицуулах хороо гүйцэтгэлд суурилсан хяналт шалгалтаас эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоо руу шилжихээр холбогдох бодлогын баримт

бичгүүдийг боловсруулж, үйл ажиллагаандаа мөрдөж эхлээд байна. Үүний хүрээнд даатгалын салбарын “Эрсдэлд суурилсан хөрөнгө тооцох аргачлал”, “Даатгалын компанийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт, шалгалт хэрэгжүүлэх журам” болон “Даатгагч өөрийн эрсдэл болон төлбөрийн чадвараа үнэлэх заавар”-ыг батлан, 2019 оны нэгдүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн мөрдүүлж эхлээд. Эдгээр журам, заавар, аргачлалыг мөрдүүлснээр даатгалын зах зээлийн оролцогчдын эрсдэлийг тооцох, удирдах тогтолцоо бүрдэх юм. “Эрсдэлд суурилсан хөрөнгө тооцох аргачлал” нь ердийн даатгал, урт хугацааны даатгал, давхар даатгалын компаниудын даатгуулагчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлэхэд хүрэлцэхүйц хэмжээний хөрөнгөтэй эсэхийг тодорхойлох бөгөөд энэхүү аргачлалд тооцогдож байгаа эрсдэлүүдээс өөрөөр тоон утгаар илэрхийлэгдэж болох эрсдэлийг мөн тооцох бололцоотой юм. Мөн аргачлалыг ашигласнаар цаашид тооцож болох эрсдэлийн төрлийг нэмэгдүүлэх, даатгалын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн хүрэлцээтэй болон үнэн зөв байдлыг бий болгох боломжтой болж байгаа юм.


Хөрвөх чадварын эрсдэл: Хөрвөх чадварын эрсдэлийн хувьд банк болон даатгалын компаниуд нь богино хугацаанд санхүүгийн хэрэгцээтэй тулгарах нь бий. Энэ нь даатгалын компаниудын хувьд гэнэт их хэмжээний нөхөн төлбөрийн нэхэмжлэл үүсэх зэрэг богино хугацаанд санхүүгийн эх үүсвэр шаардлагатай үед төлбөрийн чадваргүй болох эрсдэл юм.

Энэхүү эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс гадаадын зарим улс орнууд хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэг. Тухайлбал: Швейцарийн “Swiss Re” давхар даатгалын компани нь хөрөнгийн чөлөөт урсгалыг хангалттай хөрвөх чадвартай байлгаж, тохиолдож болох гэнэтийн таагүй үйл явдлаас гарахад шаардлагатай боломжит мөнгөн хөрөнгийн санхүүжилтыг бий болгох бодлого баримталдаг байна. Тус давхар даатгалын компани нь группын толгой компани болон бизнесийн гурван нэгжийг төлөөлөх дөрвөн үндсэн хөрвөх чадварын санг бүрдүүлдэг байна.

Зах зээлийн эрсдэл: Харин зах зээлийн эрсдэлийн хувьд хүүгийн хэлбэлзэл, хөрөнгийн зах зээлийн үнэлгээ, үл хөдлөх хөрөнгийн үнийн индекс, валютын ханш гэх мэт макро хүчин зүйлс багтана. Монгол улсын даатгалын зах зээлийн хамгийн

том тулгамдаж буй асуудал нь валютын ханштай холбогдох эрсдэл юм. Даатгалын компаниудын дийлэнх нь давхар даатгалаа гадны даатгалын компанид хийлгэдэг бөгөөд сүүлийн гурван жилд дунджаар 30 гаруй тэрбум төгрөгийг гадаад валют хэлбэрээр шилжүүлсэн нь даатгалын нийт хураамжийн орлогын 33 хувийг эзэлж байна. Харин 2018 оны байдлаар энэхүү дүн нь 55 тэрбум төгрөг болж өссөн нь нийт хураамжийн орлогын 30.9 хувийг эзэллээ. Даатгалын салбар өргөжихийн хэрээр тус салбар дахь гадаад валютын гадагшлах урсгал нэмэгдэж байгаа нь салбарын тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлэх магадлал бий болгож байна. Түүнчлэн сүүлийн жилүүдэд төгрөгийн ам.доллартай харьцах ханш суларч буй нь даатгалын компаниудад томоохон дарамт үүсгэх болсон.

Зураг 132: Давхар даатгалын хураамж, ам.долларын ханш /улирлын дүнгээр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк

Даатгалын салбар нь нийгэм, эдийн засагт учрах хүлээгдээгүй эрсдэлийг бууруулж, санхүүгийн тогтвортой байдлыг хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг хэдий ч, тус салбарын өөрийн тогтворгүй байдал, системийн эрсдэлийн түвшин нь эргээд санхүүгийн тогтвортой байдалд томоохон нөлөө үзүүлдэг. Иймд манай орны хувьд үндэсний давхар даатгалын компанийг нэмэгдүүлэх, хууль эрх зүйн орчинг сайжруулан дэмжих шаардлага үүсч байгаа бөгөөд энэ нь цаашлаад гадаад валютын гадагшлах урсгалыг сааруулах, төгрөгийн тогтвортой байдлыг дэмжихэд чухал нөлөөтэй юм.


Тайлант онд даатгалын компаниудын хөрөнгийн 54.4 хувийг хөрөнгө оруулалтын дүн эзэлсэн ба үүний 91.4 хувийг хадгаламж, хадгаламжийн сертификат хэлбэрээр хийсэн хөрөнгө оруулалт бүрдүүлж байгаа юм. Хадгаламж, хадгаламжийн сертификат болон үнэт цаасаарх хөрөнгө оруулалтаас даатгалын компаниуд 2018 оны байдлаар нийт 20.6 тэрбум төгрөгийн хүүгийн орлого олсон нь даатгалын орлогын¹ дүнгийн 29.7 хувийг эзэлжээ. Үүнийг задлан үзвэл ердийн даатгалын компаниудын хувьд хүүгийн орлого нь нийт даатгалын орлогын 22.2 хувь, урт хугацааны

¹ Даатгалын үйл ажиллагааны ашиг дээр даатгалын бус орлогыг нэмсэн дүн.

даатгалын компанийн 68.7 хувь, давхар даатгалын компанийн 90.7 хувийг бүрдүүлсэн байна. Эндээс дүгнэхэд урт хугацааны болон давхар даатгалын компанийн хувьд орлогын дийлэнх хувь нь хүүгийн түвшнээс, өөрөөр хэлбэл хөрөнгө

оруулалтын хүүгийн орлогоос хамааралтай болох нь харагдаж байна. Гэвч манай улсын хувьд хүүгийн хэлбэлзэл харьцангуй тогтвортой байгаа тул энэ талын эрсдэл тулгамдах магадлал тун бага юм.

Зураг 133: Даатгалын нийт хөрөнгө оруулалт ба хадгаламжийн жигнэсэн дундаж хүү



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк

6.3. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

AFI буюу “Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг”-ээс санхүүгийн хүртээмж болон санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдийг тодорхойлон цаашид гишүүн орнуудын дунд нийтлэг стандарт тогтоох, тоон мэдээллийн нэгдсэн сан үүсгэхээр ажиллаж байгаа бөгөөд санхүүгийн тогтвортой байдлыг тодорхойлох дараах 5 үзүүлэлтийг нэрлэжээ. Үүнд:


- Хөрөнгийн хүрэлцээтэй байдлын харьцаа
- Зээлийн эрсдэлийн сангийн харьцаа
- Чанаргүй зээлийн хувь
- Хөрвөх чадварын харьцаа
- Z индекс

Хөрөнгийн хүрэлцээт байдал: Хөрөнгийн хүрэлцээт байдлын үзүүлэлтийг тооцохдоо

өөрийн хөрөнгийг эрсдэлээр жигнэсэн нийт активд харьцуулах замаар тооцдог бөгөөд 2018 оны жилийн эцсийн байдлаар банк бус санхүүгийн байгууллагуудын хувьд уг харьцаа 134.5 хувьтай байна.

Хөрөнгийн хүрэлцээт байдлын харьцаа нь банк бус санхүүгийн байгууллагыг эрсдэлээс хамгаалах, үйл ажиллагааны тогтвортой байдлыг илэрхийлэх үзүүлэлт байдаг. Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн байгууллагуудын өөрийн хөрөнгийг эрсдэлээр жигнэсэн нийт активд харьцуулсан харьцаа 30 хувиас доошгүй байна гэж заасан байдаг бөгөөд банк бус санхүүгийн салбарын хэмжээнд уг харьцааг ханган ажиллаж байгаа буюу өөрийн хөрөнгийн хэмжээ эрсдэлтэй хөрөнгийг бүрэн нөхөж чадахуйц байна.

Зураг 134: ББСБ-ын салбарын хөрөнгийн хүрэлцээт байдлын харьцаа




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зээлийн эрсдэлийн сангийн харьцаа: Банк бус санхүүгийн байгууллагууд нь олгосон зээлийг хугацаа, чанар, эргэж төлөгдөх магадлалыг нь харгалзан ангилж замаар зээлийн эрсдэлийн санг тооцож байгуулдаг. Санхүүгийн зохицуулах хорооноос зээлийн эрсдэлийн санг байгуулах хувь хэмжээг зээлийн ангилал тус бүр дээр тогтоож өгсөн байдаг. Тухайн банк бус санхүүгийн байгууллага байгуулвал зохих эрсдэлийн сангаа байгуулсан эсэхээс нь хамааран банк бус

санхүүгийн байгууллага чанаргүй зээлээ нөхөх, эрсдэлээс хамгаалах чадвартай эсэхийг нь тодорхойлдог.

Банк бус санхүүгийн байгууллагын салбарын хувьд тайлант онд уг харьцаа 101.8 хувь гарсан буюу байгуулбал зохих эрсдэлийн санг бүрэн байгуулж чадсан бөгөөд эрсдэлийг 101.8 хувиар нөхөх чадамжтайг харуулж байна.

Зураг 135: ББСБ-ын салбарын зээлийн эрсдэлийн сангийн харьцаа




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Чанаргүй зээлийн хувь: Тайлант онд чанаргүй зээлийн хэмжээ 82.9 тэрбум төгрөгт хүрч чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 9.5 хувь

болж буурлаа. Энэ нь өмнөх оноос 3.2 нэгжээр буурсан үзүүлэлт юм.

Зураг 136: ББСБ-ын салбарын чанаргүй зээлийн хувь




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хөрвөх чадварын харьцаа: Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийг, нийт хөрөнгөд харьцуулсан харьцаа буюу хөрвөх чадварын харьцаа тайлант онд 24.5 хувь байна. Өөрөөр хэлбэл банк бус санхүүгийн байгууллагуудын нийт хөрөнгийн 24.5 хувийг мөнгөн хөрөнгө бүрдүүлж байна. Хөрвөх чадварын харьцаа нь тухайн байгууллага богино хугацаат өр төлбөрөө төлөх чадвар хэр байгааг илэрхийлдэг.

Мөнгөн хөрөнгийн хэмжээ хэт их байх нь хөрөнгөө үр ашигтай зарцуулж, үндсэн үйл ажиллагаандаа ашиглаж чадахгүй байгааг харуулах бол, хэт бага байх нь тухайн байгууллага хөрвөх чадвар муутайг илэрхийлдэг. Тайлант онд мөнгөн хөрөнгийн нийт хөрөнгөд эзлэх хувь буурсан нь нийт хөрөнгийн өсөлтийн ихэнх хувийг зээлийн өсөлт бүрдүүлсэнтэй холбоотой.

Зураг 137: ББСБ-ын салбарын хөрвөх чадварын харьцаа




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Z индекс: Z индекс нь банк бус санхүүгийн байгууллагын дампуурах магадлалыг харуулдаг ба активын өгөөж болон өөрийн хөрөнгийн харьцааны нийлбэрийг активын өгөөжийн хэлбэлзэлд харьцуулж тооцдог. Z индексийн утга ашигт ажиллагаа болон өөрийн хөрөнгийн хөшүүрэг өндөр байх үед их гарах ба өгөөжийн хэлбэлзэл ихтэй үед буюу орлогын тодорхойгүй

байдал их үед бага гарна. Өөрөөр хэлбэл индексийн их утга нь эрсдэл багатай, тогтвортой байдлыг илэрхийлдэг. 2018 оны жилийн эцсийн байдлаар банк бус санхүүгийн салбарын Z индекс өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна. Индексийн бууралтад хөрөнгийн өгөөжийн хэлбэлзэл өссөн нь нөлөөллөө.

Зураг 138: ББСБ-ын салбарын Z индекс




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

6.4. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Тайлант онд салбарын хэмжээнд 3.6 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан ба нийт 130.2 тэрбум төгрөгийн цэвэр зээлтэй байна. Салбарын нийт зээл өнгөрсөн онтой харьцуулахад 27.2 хувиар буюу 28.6 тэрбум төгрөгөөр өсөж

133.8 тэрбум төгрөгт хүрсэн байна. Харин нийт чанаргүй зээлийн хэмжээ 1.5 тэрбум төгрөгөөр өсөж 6.0 тэрбум төгрөгт хүрснээр нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь өнгөрсөн оноос 0.3 пунктээр өсөж 4.5 хувьд хүрчээ.

Зураг 139: ХЗХ-дын нийт зээл ба чанаргүй зээл /тэрбум төгрөгөөр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хэвийн зээл өнгөрсөн оноос 28.9 хувиар буюу 27.7 тэрбум төгрөгөөр өсөж 123.4 тэрбум төгрөгт хүрсэн байна. Харин нийт чанаргүй зээл өнгөрсөн оноос 33.6 хувиар буюу 1.5 тэрбум төгрөгөөр өсөж 6.0 тэрбум төгрөгт хүрчээ. Чанаргүй зээлийн ангилал дахь муу зээлийн эзлэх хувь өнгөрсөн

оноос 17.4 пунктээр буурч 21.2 хувь болсон байна. Харин хэвийн бус зээлийн нийт чанаргүй зээлд эзлэх хувь өнгөрсөн оноос 6.8 пунктээр буурч 18.7 хувь болсон бол эргэлзээтэй зээлийн эзлэх хувь 24.2 пунктээр өсөж 60.0 хувьд хүрсэн байна.

Зураг 140: ХЗХ-дын чанаргүй зээлийн үзүүлэлт /эзлэх хувиар/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант онд хадгаламж, зээлийн хоршоодын зээлийн эрсдэлийн сангийн нийт зээлд эзлэх хувь болон нийт хөрөнгөд эзлэх хувь өмнөх оноос

0.2 пунктээр буурч тус тус 2.7 болон 1.9 хувьд хүрсэн байна.

Зураг 141: ХЗХ-ны салбарын зээлийн эрсдэлийн сангийн нийт хөрөнгө болон нийт зээлд эзлэх хувь




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Байгууллагын хөрвөх чадварыг мөнгөн хөрөнгө болон нийт хөрөнгийн харьцаа, богино хугацаат хөрөнгө оруулалтын зээл болон нийт хөрөнгийн харьцаа зэрэг үзүүлэлтүүдээр илэрхийлдэг. Эдгээр үзүүлэлтүүд нь хадгаламж эзэмшигч болон хөрөнгө оруулагч хөрөнгөө татах үед тухайн санхүүгийн байгууллага өөрийн хөрөнгөө мөнгөн хөрөнгөд хэр түргэн хөрвүүлэх боломжтойг харуулдаг. ХЗХ-дын хувьд сүүлийн 5 жилийн

хугацаанд нийт мөнгөн хөрөнгө болон нийт хөрөнгийн харьцаа дунджаар 22.7 хувьтай байсан бол тайлант улиралд 28.9 хувьтай байна. Харин богино хугацаат хөрөнгө оруулалт болон нийт зээлийн нийлбэрийг нийт хөрөнгөд харьцуулсан үзүүлэлт сүүлийн 5 жилийн хугацаанд дунджаар 72.7 хувьтай байсан бол тайлант онд тус үзүүлэлт 66.8 хувьтай байна.

Зураг 142: ХЗХ-ны салбарын хөрвөх чадварын харьцаа




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

6.5. ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

2018 оны эцсийн байдлаар батлан даалтын нийт үлдэгдэлд эзлэх чанаргүй батлан даалтын хувь 14.2 болж өмнөх оноос 3.4 пунктээр буурлаа.

2017 оны 4 дүгээр улиралд 17.6 хувьд хүрээд байсан уг үзүүлэлт сүүлийн 4 улиралд буурсан дүнтэй байгаа юм.

Зураг 143: Чанаргүй батлан даалтын хувь




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Чанаргүй батлан даалтын үлдэгдлийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл 55.7 хувь нь үйлдвэрлэлийн салбарт, 28.4 хувь нь

хөдөө аж ахуйн салбарт, 3.6 хувь нь бөөний болон, жижиглэн худалдаа, 12.3 хувь нь үйлчилгээний салбарт байна.

Зураг 144: Чанаргүй батлан даалт /эдийн засгийн салбараар/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо



The background of the page is a grayscale image of a pen nib pointing at a document. The document contains financial data, including a table with columns for dates, values, and changes. A dark red horizontal band is overlaid on the middle of the image, containing the Roman numeral 'VII' in white.

VII

БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН
ОРЧИН

7.1. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2018 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн ээлжит хуралдаанд төрийн өмчит компаниудын хувьчлалыг хөрөнгийн биржээр дамжуулан хэрэгжүүлэх талаар олон улсын туршлага судалж, боловсруулсан саналыг танилцуулсан. Энэхүү санал нь хөрөнгийн зах зээл дээрх бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагчдын эрэлт, хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн бий болгох зорилготой юм.

Татварын багц хуулийн төсөл боловсруулагдах хүрээнд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль болон Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн төслүүд боловсруулагдаж байгаатай холбогдуулан хөрөнгийн зах зээлийн нийлүүлэлтийг дэмжихээр шинээр үнэт цаас гарган нээлттэй болж байгаа хуулийн этгээд, хөрөнгийн зах зээл дээр арилжаалагдаж буй компанийн хувьцаа, өрийн хэрэгсэл /бонд/-д хөрөнгө оруулсан хөрөнгө оруулагчдад хамаарах орлого, ашигт тусгайлсан татварын зохицуулалт бий болгох, хөнгөлөх, чөлөөлөх асуудлуудаар санал боловсруулж, хууль санаачлагчид хүргүүлэхэд бэлэн болсон.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлын хүрээнд Хороо болон мэргэжлийн байгууллагуудын төлөөллүүдээс бүрдсэн тус компанийн хувьцааны бүртгэлийг баталгаажуулах, ногдол ашиг тараах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж ажиллаа. Ажлын хэсэг “Эрдэнэс Тавантолгой” ХК-тай холбоотой асуудлуудыг судлан, хувьцааг олон нийтэд нээлттэй арилжаалах боломжийг тал бүрээс нь судалж, урьдчилсан байдлаар дүгнэлтээ боловсруулсан.

“МХБ” ХК-ийн зүгээс бүртгэлийн шалгуур шаардлагыг чанаржуулах, олон улсын стандартад нийцүүлэхээр өөрийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”, “Арилжааны журам”, “Үнэт цаасны индекс тооцох журам”-ыг шинэчлэн боловсруулсан ба эдгээр журмуудыг Хорооны даргын 2018 оны 2 дугаар сарын 08-ны өдрийн 68 дугаар тушаалаар бүртгэж авсан.

Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдүүдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоож өгсөн Хорооны 2016 оны 94 дүгээр тогтоолын хэрэгжилтийн байдлыг судалж, өнөөгийн байдал болоод цаашид баримтлах чиглэлийн талаарх саналыг боловсрууллаа.

Хорооны 2016 оны 244 дүгээр тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх, шаардлагатай өөрчлөлтүүдийг оруулах ажлуудыг гүйцэтгэж, “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам” нэртэйгээр Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний 377 дугаар тогтоолоор шинэчлэн баталлаа.

Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 7 дугаар сарын 02-ны өдөр баталсан Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэгт “Зохицуулалттай зах зээл дэх үнэт цаасыг барьцаалахтай холбогдсон харилцааг энэ хуульд үндэслэн үнэт цаасыг зохицуулах, хянах эрх бүхий байгууллагын тогтоосон журмаар зохицуулна” гэж заасны дагуу Үнэт цаас зээлдүүлэх, барьцаалах тухай журмын төслийг боловсруулж, Захиргааны ерөнхий хуулийн дагуу олон нийтээс санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулсан. Үүний үр дүнд зах зээлийн мэргэжлийн байгууллагуудаас зарчмын шинж чанартай өөрчлөлт, нэмэлт тусгуулахаар санал гарган ирүүлсний дагуу журмын төслийг 2 удаа шинэчлэн найруулж Хорооны 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 382 дугаар тогтоолоор “Үнэт цаас барьцаалах тухай журам”-ыг баталлаа.

Гадаад хамтын ажиллагаа: 2018 оны 5 дугаар сард болсон Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага (IOSCO)-ын 43 дахь удаагийн чуулга уулзалтад Хорооны дарга тэргүүтэй төлөөлөгчид оролцсон. Уулзалтаар хөрөнгийн зах зээлийн хөгжлийн хандлага, ялангуяа энэ зах зээлд нэвтэрч буй финтекийн шийдэл, шинэтгэл болон хөгжүүлэлтийн хэтийн төлөв, санхүүгийн



зах зээлүүдийн нэгдэл интеграцийн талаар дэлгэрэнгүй ярилцсан байна.

Европын сэргээн босголт хөгжлийн банк (EBRD)–ны техникийн хамтын ажиллагааны “Монгол Улсын Мөнгөний болон Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх баримт бичиг боловсруулах” төслийн хүрээнд үнэт цаасны төлбөр, тооцооны Төлбөрийн эсрэг Нийлүүлэлт (Delivery versus Payment) зарчим, дараа төлбөрт тооцооны Т+2 горимыг нэвтрүүлэх төсөл хэрэгжиж эхэллээ. Энэ хүрээнд Хороо, Сангийн яам, Монголбанк болон дэд бүтцийн байгууллагуудаас бүрдсэн дотоод ажлын хэсгийг байгуулаад байна. Үүний зэрэгцээ зөвлөх багаас бэлтгэн ирүүлсэн саналыг судалж, цаашдын үйл ажиллагааны чиглэлээ тогтсон ба СТБЗ–д танилцуулсан.

Японы Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА), Хороо болон Сангийн яам, Монголбанк, “Монголын хөрөнгийн бирж” ХК, “Монголын үнэт цаасны бирж” ХК, Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо болон бусад холбогдох байгууллагын төлөөллүүдийг хамарсан уулзалт зохион байгуулсан. Уг уулзалтаар “Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн чадавхыг бэхжүүлэх II үе шатны төсөл”–ийн хүрээнд компанийн бондын зах зээлийн нөхцөл байдлын судалгаа хийж, зөвлөгөө өгөх, зэрэглэл тогтоох байгууллага байгуулах болон биржийн бус арилжааны эрх зүй, зохицуулалт, тогтолцооны зарчмыг тодорхойлж боловсруулах, олон нийтийн хөрөнгийн зах зээлийн талаарх мэдлэг боловсролыг дээшлүүлж, зах зээлд оролцох сонирхлыг нэмэгдүүлэх гэсэн гурван чиглэлээр гүйцэтгэх ажлын хүрээг тодорхойлсон байна. Уг төсөл 2019 оны эхний улирлаас хэрэгжиж эхлэх бөгөөд гурван жилийн хугацаанд үргэлжлэх байна.

Дотоод хамтын ажиллагаа: Монголын Олон Улсын Хөрөнгийн Корпораци (MICS)–ийн Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимтай хамтран 2018 оны 5 дугаар сарын 30–ны өдөр зохион байгуулсан IPO Conference 2018 арга хэмжээнд оролцсон. Тус арга хэмжээ

нь МҮХАҮТ–ын гишүүн компаниуд, ялангуяа ТОП 100 аж ахуйн нэгжүүдэд олон нийтэд нээлттэй компани болох сонирхлыг төрүүлэх, дэмжлэг үзүүлэх зорилготой ба хувьцаа гаргахад тавигдах шаардлагууд болон санхүүжилтийн боломжуудын талаар танилцуулж, санхүүгийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай харилцаа тогтоох, хамтран ажиллах боломжийг олгох явдал байв.

Компанийн засаглалын хөгжлийн төвөөс зохион байгуулж буй Компанийн засаглалын 10 дахь удаагийн форумд Санхүүгийн зохицуулах хороо хамтран зохион байгуулагчаар оролцсон бөгөөд тус арга хэмжээ 2018 оны 6 дугаар сарын 12–ны өдөр хөрөнгийн зах зээлийн зохицуулалттай байгууллагууд болон компаниудыг оролцуулан зохион байгуулагдсан.

Зах зээлийн мэргэжлийн оролцогч байгууллагуудын төлөөллүүдээс бүрдсэн “Хөрөнгө оруулалтын банкны тухай хууль”–ийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэгт Хорооноос бүрэлдэхүүнд орж ажилласан. Ажлын хэсэг өргөн барьсан хуулийн үзэл баримтлал, хуулийн төслөөр зохицуулах харилцааг судалж, хөрөнгө оруулалтын банкийг олон улсын жишгийн дагуу хөгжүүлэх, арилжааны банкнаас ялгарах үүргийг нь тодорхой тусгах, бүртгэл зөвшөөрөл, хяналт тавих этгээдийг тодорхой болгох зэрэг сайжруулалт хийх шаардлагатай гэж үзэн, сайжруулан боловсруулах ажлыг өнгөрсөн хугацаанд хийж гүйцэтгэсэн.

Өөрийн зохицуулж буй салбарын мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагааг эрчимжүүлж, бодит ажил хэрэг болгох үүднээс Компанийн засаглалын хөгжлийн төв, Монголын итгэмжлэгдсэн санхүүгийн шинжээчдийн нийгэмлэг, Монголын хуульчдын холбоо, Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эд бэлтгэн нийлүүлэгчдийн холбоотой тус тус хамтран ажиллах гэрээ байгуулаад байна.

Сургалт, семинар, хамтын ажиллагаа: “FRC PLUS INVESTMENT” сэдвийн дор хөрөнгийн зах

зээлийг сонирхон судалж буй, мөн тус зах зээлд оролцож, хөрөнгө оруулж буй иргэд, олон нийт өөрсдийн мэдлэг туршлага, санал санаачилгыг нээлттэй, чөлөөтэй, хүртээмжтэй байдлаар олон нийтэд хүргэх зорилгоор иргэд, олон нийтийн хөрөнгийн зах зээлийн талаарх ойлголтыг дээшлүүлэх цаашлаад зах зээл дэх иргэдийн оролцоог нэмэгдүүлэхээр “FRC PLUS” илтгэлийн уралдааныг зохион байгуулсан.

Иргэдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих, хөрөнгийн зах зээлийн талаарх иргэдийн ойлголтыг дээшлүүлэх зорилготой “Үнэт цаасны зах зээлийн нээлттэй өдөрлөг” арга хэмжээг Монголын хөрөнгийн биржтэй хамтран орон даяар зохион байгуулахаар төлөвлөж Дархан–Уул, Булган, Орхон аймгуудад нээлттэй өдөрлөг, сургалтыг 2018 оны 6 дугаар сарын 21–ний өдрөөс 23–ны өдрийн хооронд зохион байгууллаа. Уг өдөрлөгийн үеэр хөрөнгө оруулалт болон хөрөнгийн зах зээлийн талаар анхан шатны мэдлэг олгох сургалтууд, иргэдийн үнэт цаасны дансыг шалгаж өгөх, данс нээх, үнэт цаастай холбоотой гомдол хүсэлтийг газар дээр нь хүлээн авах үйл ажиллагаануудыг нэг дороос үзүүлсэн.

Хөрөнгийн зах зээлд шинээр оролцох сонирхолтой компаниудад зах зээлийн онцлогийг тайлбарлан таниулах, анхдагч зах зээл дээр хувьцаагаа амжилттай гаргасан компаниуд өөрсдийн туршлага, мэдлэгээсээ хуваалцаж, амжилт, сорилтоо дэнслэх боломж олгох зорилгоор Үнэт цаасны газраас 2018 оны 9 дүгээр сарын 25–ны өдөр “Шинээр IPO гаргасан компаниудын нээлттэй зөвлөлдөх уулзалт”–ыг зохион байгуулж, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэсэн.

7.2. ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

2018 оны жилийн эцсийн байдлаар даатгалын салбарын хууль эрх зүйн орчныг сайжруулах, зохистой зохицуулалтыг бий болгох чиглэлээр хэд хэдэн журмуудад нэмэлт, өөрчлөлт оруулж, мөн эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр ажлын хэсгүүдэд орж ажиллаа. Үүнд:

Даатгалын салбарт мөрдөгдөж буй журам, зааврыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх ажлын хүрээнд Хорооны 2018 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 207 дугаар тогтоолоор “Сайн дурын даатгалын хэлбэр”-ийг, 208 дугаар тогтоолоор “Тохиромжтой этгээдийг тодорхойлох заавар”-ыг, 209 дүгээр тогтоолоор “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн ёс зүйн журам”-ыг, 2010 дугаар тогтоолоор “Ипотекийн даатгалын үйл ажиллагааны журам”-ыг, 211 дүгээр тогтоолоор “Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам”-ыг, 21, 22 дугаар тогтоолоор “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын мэдүүлгийн маягт, гэрээний стандарт, загвар”-ыг, “Жолоочийн даатгалын сангийн данс байршуулах, санхүүжилтийг төвлөрүүлэх, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах”-ыг тус тус шинэчлэн баталж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлсэн.

Ердийн даатгалын 14 компани, урт хугацааны даатгалын 1 компани Хорооноос тогтоосон дүрмийн сангийн доод хэмжээг хангалаа.

Хорооны 2018 оны 251 тоот тогтоолоор Хувийн хөрөнгө оруулалттай анхны үндэсний давхар даатгалын “Анд ДД давхар даатгал” ХХК-д давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон. Мөн тус компани нь Хорооны 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 381 дүгээр тогтоолоор оноосон нэрээ “Хубилай давхар даатгал” ХХК болгон өөрчлөв.

Даатгалын салбар анхны IPO-г Хөрөнгийн бирж дээр гарган, “Мандал даатгал” ХК, “Ард даатгал” ХК хувьцаагаа олон нийтэд санал болгож, нээлттэй компаниуд болсон.

Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам

хамтран хувийн тэтгэврийн даатгалын тогтолцоог бий болгох чиглэлээр Азийн Хөгжлийн Банкнаас техникийн туслалцаа авахаар хэд хэдэн уулзалт хийсний үр дүнд хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. Энэ санамж бичгийн хүрээнд хувийн тэтгэврийн даатгалын хуулийн төслийг боловсруулахаар ажилласан.

Сургалт, семинар, хамтын ажиллагаа: Япон улсын санхүүгийн үйлчилгээний байгууллагын “Зохицуулагч байгууллагын чадавхыг сайжруулж хамтын ажиллагааг бэхжүүлэх хөтөлбөр”-ийн сургалтад оролцон хамтран ажиллаж байна.

Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам, мэргэжлийн холбоод болон даатгалын зах зээлд оролцогчдын төлөөллийг оролцуулан 2018 оны 5 дугаар сард “Хүртээмжтэй даатгал”, “Даатгалын салбарын асуудал ба шийдэл сэдэвт” хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Олон улсын даатгалын зохицуулагчдын холбоо (IAIS)-ны 25 дахь удаагийн чуулга уулзалтад оролцож, тус холбооны хамтын ажиллагааны санамж бичигт нэгдэх асуудлаар ярилцлаа.

Олон улсын даатгалын зохицуулагчдын холбооны удирдлагатай уулзалт зохион байгуулж, тус холбооны олон талт хамтын ажиллагааны санамж бичигт нэгдэх талаар ярилцан мөн олон улсын даатгалын стандарт, тулгуур зарчмуудыг үе шаттайгаар нэвтрүүлэх талаар санал солилцон, бусад орны туршлагыг судалж, даатгалын тулгуур зарчмыг үе шаттайгаар нэвтрүүлэх шаталсан үнэлгээг хийсэн.

Даатгалын компанид учирч болох эрсдэлийг урьдчилан таамаглаж тогтоох, үүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор даатгалын зохицуулалтын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих хяналтыг боловсронгуй болгоход эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бий болгохоор Дэлхийн банкны зөвлөх Майкл Кохен, Люксембургийн төслийн зөвлөх Холли Бакетай хамтран ажиллаж, холбогдох саналуудыг тусгасан “Даатгагчийн үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих журам”, “Даатгалын компанийн

үйл ажиллаганд эрсдэлд суурилсан хяналт шалгалт хэрэгжүүлэх журам”-уудын төслийг боловсруулан санал авч ажиллаж байна.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга доктор С.Даваасүрэн хүртээмжтэй даатгалын асуудлаарх Азийн орнуудын мэдлэг, туршлага солилцох сүлжээ (MEFIN, The Mutual Exchange forum on Inclusive insurance)-ний 2018 оны даргаар ажиллаж, 2019 оны даргаар улиран сонгогдлоо.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Олон Улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /GIZ/, Дэлхийн манлайллын академи /GLA/ болон Хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэгч Олон Улсын байгууллага /AII/ хамтран хэрэгжүүлж буй “Хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэх төсөл”-ийн олон улсын болон үндэсний 2 дахь удаагийн уулзалт Албани, Монгол улсад 2018 оны 3, 4 дүгээр саруудад зохион байгуулагдлаа.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажлын хүрээнд Улаанбаатар хот, 8 аймагт сургалт зохион байгуулж, тухайн орон нутгийн зохицуулалтын байгууллагуудад эрсдэлийн үнэлгээ хийсэн. Мөн даатгалын чиглэлээр Авилгатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газрын ажилтнуудад, иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд Монголбанктай хамтран Улаанбаатар хот болон 5 аймагт сургалт зохион байгуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 04 тоот хуралдааны тэмдэглэл болон Монгол Улсын Шадар сайдаас ирүүлсэн зөвлөмжийн хүрээнд даатгалын компаниудаас ирүүлсэн Хурдан морины уралдаанч хүүхдийн гэнэтийн ослын даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэж Хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт холбогдох зөвлөгөө, мэдээлэл өгч хамтран ажилласан.

Хорооноос Монголын даатгалын холбоотой хамтран ажиллах гэрээ, Монголын банкны холбоо, Монголын даатгалын зуучлагчдын холбоотой сургалт зохион байгуулах гэрээг тус тус байгуулсан. Тус гэрээнд даатгалын зах

зээлд оролцогчид, тэдгээрийн боловсон хүчнийг чадавхжуулах үүднээс сургалтын үйл ажиллагааг Холбоод мэргэжлийн түвшинд зохион байгуулж, Хороо холбогдох чиг үүргийнхээ хүрээнд хяналт тавьж ажиллахаар тусгасан. Гэрээний хүрээнд Монголын даатгалын холбоо, Монголын банкны холбоотой хамтран даатгалын төлөөлөгч, зуучлагчийн сургалтыг Улаанбаатар хотод 2 удаа, орон нутгийн 5 бүсийн 21 аймагт нийт 42 удаагийн сургалтуудыг хамтран зохион байгуулан ажиллаж байна. Мөн Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институттэй хамтран “Даатгалын байгууллагад аудит хийх үйл ажиллагааны төрөлжсөн сургалт”-ыг 1 удаа, Монголын хохирол үнэлэгчдийн холбоотой хамтран даатгалын хохирол үнэлэгчийн эрх олгох сургалтыг 1 удаа тус тус зохион байгуулж, сургалтад оролцогчдоос шалгалт авч ажиллаа.

7.3. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийг шинэчлэн боловсруулах талаарх тандалтын судалгаа, шинэчлэн боловсруулсан хуулийн төслийн үр нөлөө болон зардлын судалгаа, хуулийн төслийн танилцуулгыг эцэслэн боловсруулж, зөвлөхүүдийн саналыг тусгасан ба Европын сэргээн босголт, хөгжлийн банкны техник туслалцааны хүрээнд олон улсын гадаад зөвлөх хуулийн төсөл дээр ажиллуулахаар харилцан тохиролцож зөвлөхийг сонгон шалгаруулах ажлыг эхлүүлэв.

Банкнаас бусад санхүүгийн салбарт мөрдөгдөх дүрэм журмуудыг хууль тогтоомжид нийцүүлэн шинээр боловсруулах, шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хүрээнд гадаад валютын арилжааг эрхэлж буй банк бус санхүүгийн байгууллагуудын зохицуулалт, Зээлийн батлан даалтын сангийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, хяналт тавих журмыг боловсронгуй болгох чиглэлээр журмын төсөл, танилцуулга, судалгаа хийж, Сангийн яам, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас санал авсан.

Банк бус санхүүгийн байгууллагын хөрөнгө оруулагч, харилцагчдын талаар улирал бүрийн санхүүгийн тайлангийн нэгтгэл дээр нарийвчлан тусгаж, санал дүгнэлт боловсруулах ажлын хүрээнд банк бус санхүүгийн байгууллагуудын 1, 2, 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлд хувьцаа эзэмшигч болон харилцагч үйлчлүүлэгчдийн талаарх мэдээлэл /нас, хүйс, боловсрол, 1–ээс дээш банк бус санхүүгийн байгууллагад хувьцаа эзэмшиж байгаа иргэн болон хуулийн этгээд, хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл, хамгийн олон болон 1 хувьцаа эзэмшигчтэй банк бус санхүүгийн байгууллагууд гэх мэт/–үүдийг дэлгэрэнгүй тусгаж, дүгнэлт гаргалаа.

Хорооны 2016 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шинэчлэн

тогтоох тухай”, “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 2017 оны 90 дүгээр тогтоол, 2017 оны 27 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх” “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 2017 оны 91 дүгээр тогтоолуудад нөлөөллийн шинжилгээ хийж Захиргааны ерөнхий хуульд заасан бүрдлийг ханган бүртгүүлэв.

Засгийн газар, орон нутгаас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр, сангуудаас олгож буй зээлийг бичил санхүүгийн байгууллагаар дамжуулан хэрэгжүүлэх талаар судалгаа хийж, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд төсөл хөтөлбөрийг банк бус санхүүгийн дундын байгууллагаар дамжуулан хэрэгжүүлэх зохицуулалтын орчин бүрдүүлэхээр тусгаад байна. Засгийн газар, орон нутгаас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр, сангуудаас олгож буй зээлийг бичил санхүүгийн байгууллагаар дамжуулан хэрэгжүүлэх талаар судалгаа хийж, саналыг холбогдох байгууллагад хүргүүлсэн.

Банкнаас бусад санхүүгийн салбарын мэргэжлийн оролцогчийн ёс зүйн журмыг шинэчлэн боловсруулж, санхүүгийн зах зээлийн оролцогчдод зориулсан сургалтын хөтөлбөрт ёс зүй, хэм хэмжээ төлөвшүүлэх сэдвийг оруулах төлөвлөгөөт ажлын хүрээнд гадаад улс орны банк болон бичил санхүүгийн салбарын ёс зүйн кодексын тухай судалгааг хийж, салбарын оролцогч байгууллагын ёс зүйн дүрмийн төслийг боловсруулан Монголын банк бус санхүүгийн байгууллагын холбоонд хүргүүлж “Санхүүгийн салбарын комплаенс–2018” форумаар хэлэлцүүлсэн ба гарсан саналыг тусган батлуулахаар болсон.

Хороо болон Монголын банк бус санхүүгийн байгууллагын холбооноос хамтран зохион байгуулж буй “Банк бус санхүүгийн байгууллагуудыг сертификатжуулах” сургалтын хөтөлбөрт “Банк бус санхүүгийн байгууллагын ёс

зүй” сэдвийг нэмсэн.

Сургалт, семинар, хамтын ажиллагаа: Санхүүгийн зохицуулах хорооны 71 тоот тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 2.11-д “Тусгай зөвшөөрлөө авснаас хойш 6 сарын хугацаанд банк бус санхүүгийн байгууллагын удирдлага нь Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооноос зохион байгуулсан сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна” гэж заасны дагуу Хороо, холбоотой хамтран шинээр тусгай зөвшөөрөл авч буй банк бус санхүүгийн байгууллагуудын удирдлагуудад зориулсан “Банк бус санхүүгийн байгууллагуудын сертификатжуулах сургалт”-ыг зохион байгуулж 4 дүгээр сарын 25-наас 27-ны өдрүүдэд 28, 6 дугаар сарын 5-наас 7-ны өдрүүдэд 15, 11 дүгээр сарын 16-наас 18-ны өдрүүдэд 22 банк бус санхүүгийн байгууллагуудын удирдлагуудыг тус тус хамруулав. Уг сургалтаар банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны онцлог, хууль эрх зүйн орчин, хяналт зохицуулалт, банк бус санхүүгийн байгууллагын нягтлан бодох бүртгэл, тайлагнал, олон улс дахь бичил санхүүгийн салбарын хөгжил, өнөөгийн түвшин, банк бус санхүүгийн байгууллагын нийгмийн хариуцлага, харилцагчийн үйлчилгээ, үйлчилгээний байгууллагын стандарт зэрэг зайлшгүй шаардлагатай мэдлэг олгоход чиглэгдсэн мэдээллийг банк бус санхүүгийн байгууллагуудын удирдах албан тушаалтнуудад нэгдсэн байдлаар өгөх зорилготой.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажлын хүрээнд 6 дугаар сарын 13-ны өдөр Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй банк бус санхүүгийн байгууллагуудад мөнгө угаах, терроризмтай тэмцэх гэмт хэргийн тухай ойлголт өгөх зорилгоор сургалт зохион байгуулсан бөгөөд нийт 277 банк бус санхүүгийн байгууллагуудын төлөөллийг хамруулав.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр зохицуулалтын байгууллагуудад зориулсан гарын авлагыг боловсруулан тус сургалтаар тараав. Мөн “Мөнгө угаах болон

терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Монгол Улсын тогтолцоо ба Санхүүгийн зохицуулах хороо” сэдэвт эдийн засгийн сэтгүүлчидтэй хийсэн уулзалтаар Мөнгө угаах гэж юу вэ? Терроризмыг санхүүжүүлэх гэж юу вэ? Яагаад уг гэмт хэрэгтэй тэмцэх шаардлагатай вэ?” сэдвээр илтгэл тавилаа.

5 дугаар сарын 25-ны өдөр Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулдаг 132 банк бус санхүүгийн байгууллагуудын удирдлагуудад зориулж “Комплаенсын ажилтны үүрэг, хариуцлага” сэдвээр мэдээлэл хийсэн. Энэ чиглэлээр 12 дугаар сарын 11-ний өдөр “Санхүүгийн салбарын комплаенс-2018” форумыг зохион байгуулсан ба энэхүү форумд банк бус санхүүгийн байгууллагуудын төлөөлөл оролцож, салбарын хэлэлцүүлэг хийж салбарын мэргэжлийн оролцогчийн ёс зүйн дүрмийн төслийг батлахаар болсон.

“Олон нийтийн санхүүгийн суурь боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр 2016-2021”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 1 дүгээр улиралд 9, 2 дугаар улиралд 8, 3 дугаар улиралд 11 нийт 28, мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн талаар 24 мэдээллийг бэлтгэн хүргүүлж олон нийтэд мэдээлсэн.

Санхүүгийн зах зээлийн талаар нээлттэй өдөрлөг, форум зохион байгуулж, олон нийтэд мэдээлэл хүргэх ажлын хүрээнд Монголбанк, Бичил санхүүгийн хөгжлийн сан, Боловсрол соёл шинжлэх ухаан спортын яамны харьяа Насан туршийн боловсролын үндэсний төв болон аймгуудын Монголбанкны салбар, Санхүү, төрийн сангийн хэлтэстэй хамтран зохион байгуулсан “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хөдөө орон нутгийн иргэдэд санхүүгийн боловсрол олгох тэргүүлэх чиглэлийн хүрээнд БСШУСЯ-ны харьяа Насан туршийн боловсролын үндэсний төвийн аймаг, сумд дахь багш нарт зориулсан “Орон нутгийн иргэдэд зориулсан санхүүгийн боловсрол олгох сургагч багш бэлтгэх” сургалтын хөтөлбөрийн хүрээнд 5 дугаар сарын 14-25-ны өдрүүдэд Говь-



Алтай, Баянхонгор аймгууд, 5 дугаар сарын 24–25–ны өдрүүдэд Улаанбаатар хот, 6 дугаар сарын 11–22–ны өдрүүдэд Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгуудад иргэдэд санхүүгийн мэдлэг түгээх 182 сургагч багшид банк, санхүүгийн салбарын талаар хичээл заасан. Сургалтын үеэр сургалтын үндсэн зорилтот бүлгээс гадна тухайн аймаг, аймгийн төвийн сумдын засаг даргын тамгын газрын албан хаагчид, иргэдийн хурлын ажлын албаны ажилтнууд, арилжааны банк, төрийн бусад нэр бүхий байгууллагуудын ажилтан, ажиллагсад болон хэвлэл мэдээллийн ажилтнуудад чиглэсэн зорилтот сургалтуудыг хамтран зохион байгуулж ажиллалаа. Мөн сургалтын хугацаанд Хорооны зохицуулалтын хүрээний байгууллагуудын төлөөлөлтэй нээлттэй хэлэлцүүлэг хийх ажлыг зохион байгуулан ажилласан ба орон нутгийн хэвлэл мэдээллийнхэнтэй уулзалт зохион байгуулж, иргэд олон нийтэд санхүүгийн мэдээллийг хэрхэн ойлгомжтой хүртээмжтэй хүргэх талаар харилцан санал бодлоо солилцож, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр ярилцлага, мэдээ өгч ажиллалаа.

7.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Татварын багц хуулийн төслийг хэлэлцүүлж байгаатай холбогдуулан хадгаламж, зээлийн хоршоо нь ашгийн төлөө бус байгууллага тул ашгийн төлөө байгууллагуудаас ялгамжтай хандах талаарх саналыг Сангийн яаманд хүргүүлсэн.

Азийн Хөгжлийн Банкнаас Хороотой хамтран хэрэгжүүлж буй “Хадгаламж, зээлийн хоршооны салбарын тогтвортой хөгжлийг дэмжих төсөл”-ийн хүрээнд хийгдсэн ажлыг үргэлжлүүлэхээр төслийн 2 дахь шатны саналыг боловсруулж, Азийн Хөгжлийн Банкинд хүргүүлснээр төслийн санал дэмжигдсэн. Уг төслийн хүрээнд Хороо, Азийн Хөгжлийн Банктай харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан бөгөөд төслийн 2 дахь шат бичил санхүүгийн салбарыг чадавхижуулах чиглэлд хэрэгжихээр болсон.

Захиргааны ерөнхий хуульд журам, заавар нийцүүлэх ажлын хүрээнд “Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоонд тавигдах шаардлага”, “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага”, “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны үзүүлэлт”-ийг шинэчлэн баталж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн.

Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан. Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлал, тандан судалгаа, зардлын тооцоо, үр нөлөөний үнэлгээг тус тус гүйцэтгэсэн. Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд салбарын хөгжлийг дэмжих зохицуулалт болох санхүүгийн дундын байгууллагыг байгуулах, тогтворжилтын сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, гишүүдийн хадгаламжийг даатгах талаар зохицуулалтыг нарийвчлан тусгаад байна.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн

шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж, хуулийн үзэл баримтлалыг боловсруулах уулзалт, хэлэлцүүлгийг 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулсан. Уг уулзалтад оролцож, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр төрөөс олгож буй зээл тусламжийг банкнаас бусад санхүүгийн байгууллагаар дамжуулах боломжийг нээх зохицуулалтыг тусгах талаар танилцуулга хийж, зарчмын хувьд хуульд оруулах өөрчлөлтүүдийн талаар нэг мөр ойлголтод хүрсэн.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын хадгаламж, зээлийн хоршооны улсын бүртгэлийг Хорооны тусгай зөвшөөрлийн бүртгэлтэй тулгаж, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл Хорооноос аваагүй, авсан ч хууль тогтоомжоор тогтоосон нөхцөл, шаардлагыг хангаагүйгээс тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгосон боловч хуулийн этгээдийн улсын бүртгэлд хадгаламж, зээлийн хоршоо хэлбэрээр бүртгэлтэй байгаа 183 хуулийн этгээдийн мэдээллийг гаргасан. Тус хадгаламж, зээлийн хоршоодыг татан буулгах, эсхүл хуулийн этгээдийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулах асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргахаар ажиллаж байна.

2018 оны 12 дугаар сарын 11-ний өдөр Хорооноос мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулсан “Санхүүгийн салбарын комплаенс 2018” форумын хадгаламж, зээлийн хоршооны салбар хуралдаанаар хадгаламж, зээлийн хоршоодын өнөөгийн байдал, тулгамдсан асуудлын талаар хэлэлцэж, зөвлөмж гарган нэгдсэн хуралдаанд танилцуулсан.

Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй нийт хадгаламж, зээлийн хоршоодоос зээлийн шимтгэлийн талаар судалгаа авч, үр дүнг нэгтгэсэн.

Хадгаламж, зээлийн хоршооны салбарт нэвтрүүлэх боломжтой технологид суурилсан санхүүгийн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний судалгаа хийх хүрээнд Азийн хадгаламж, зээлийн

хоршоодын холбооноос Тайланд, Филиппин улсуудад нэвтрүүлж буй төлбөр тооцооны KAYA системийн талаар судалж танилцуулга бэлтгэсэн.

Хадгаламж, зээлийн хоршооны салбарт эрсдэлд суурилсан хяналт, шалгалтыг нэвтрүүлэх чиглэлээр зайны хяналтын журам, эрсдэлийн үнэлгээ хийх гарын авлагын төслийг боловсруулах ажлын хүрээнд хадгаламж, зээлийн хоршоодод одоо мөрдөж байгаа зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн нийцтэй байдлыг сүүлийн 12 улирлын байдлаарх тоон мэдээлэлд үндэслэн үнэлсэн.

Сургалт, семинар, хамтын ажиллагаа: 2018 оны 5 дугаар сарын 08–ны өдөр Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газартай хамтран “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд хамтран ажилладаг хадгаламж, зээлийн хоршоодын дарга, хяналтын зөвлөлийн дарга нарыг чадавхжуулах сургалт зохион байгуулж, “Хадгаламж, зээлийн хоршооны хууль эрх зүйн орчин”, “Хадгаламж, зээлийн хоршооны удирдлага зохион байгуулалт, дотоод хяналт” зэрэг сэдвийн хүрээнд мэдээлэл өгсөн.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг хадгаламж, зээлийн хоршоодод хууль, холбогдох журам, заавар, олон улсын стандарт, хуулийн хэрэгжилтийн нөхцөл байдал, учирч болох эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх болон таньж мэдэх арга замуудын талаар ойлголт өгөх сургалтыг 2018 оны 6 дугаар сарын 07–ны өдөр Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоотой хамтран зохион байгуулсан.

2018 оны 6 дугаар сарын 12–ны өдөр Монголбанкны Хяналт шалгалтын газрын зээлийн мэдээллийн сан хариуцсан ахлах мэргэжилтэн, мэргэжилтэнтэй уулзалт зохион байгуулж, Монголбанкны зээлийн мэдээллийн санд хадгаламж, зээлийн хоршоодыг

хамруулахад гарч байгаа хүндрэл бэрхшээл, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ, хэрхэн хамтран ажиллах талаар санал солилцсон.

2018 оны 12 дугаар сарын 05–ны өдөр Зээлийн батлан даалтын сангийн удирдлага, Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо, банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны удирдлага Хорооны хадгаламж, зээлийн хоршооны газар болон банк бус санхүүгийн байгууллагын газрын удирдлага болон холбогдох албан хаагчид хамтарсан уулзалтыг зохион байгуулсан. Уулзалтаар Зээлийн батлан даалтын сангийн үйлчилгээнд бичил санхүүгийн байгууллагуудыг хамруулах талаар харилцан санал солилцож улмаар мэргэжлийн холбоодоор дамжуулан банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоодод сургалт зохион байгуулах, холбогдох дүрэм, журамд шаардлагатай өөрчлөлтийг оруулахаар болсон.

“Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд 2018 оны 12 дугаар сарын 16–24–ний өдрүүдэд Дорнод, Сүхбаатар, Увс, Баян–Өлгий аймагт төлөөлөл ажиллав.

ХАВСРАЛТ

Хавсралт 1: Хөрөнгийн зах зээлийн статистик үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Зах зээлийн үнэлгээ	1799.9	1670.5	1442.7	1262.5	1474.2	2440.2	2511.8
ЗЗҮ-г ДНБ-д харьцуулсан хувь	10.8%	8.7%	6.5%	5.5%	6.2%	8.7%	7.8%
Хөрвөх чадвар	8.0%	5.8%	1.7%	2.4%	3.3%	3.2%	8.4%
Топ-20 индекс	17,609.1	16,301.8	14,854.2	12,897.6	12,456.1	20,736.9	21,466.8
Бүртгэлтэй компанийн тоо	328	323	303	299	302	300	305
Брокер, дилерын тоо	95	87	66	61	62	52	54
Хөдөө аж ахуйн биржийн арилжааны дүн /тэрбум төгрөг/	-	403.6	554.1	431.7	463.0	547.2	711.4
Хувьцаа /тэрбум төгрөг/	144.7	97.6	24.2	30.5	49.0	78.1	210.3
ЗГҮЦ /тэрбум төгрөг/	0.001	1.0	36.1	515.5	299.7	772.5	33.5
Компанийн бонд /тэрбум төгрөг/	0.31	-	-	0.5	-	10.2	1.7

Хавсралт 2: Даатгалын зах зээлийн статистик үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Хөрөнгө (тэрбум төгрөг)							
Нийт хөрөнгө	107.4	126.4	152.5	173.2	208.4	244.7	331.9
Ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгө	102.7	120.8	146.0	139.5	165.9	193.6	252.9
Урт хугацааны даатгалын компанийн нийт хөрөнгө	4.7	5.6	6.5	7.6	7.5	7.8	8.9
Давхар даатгалын компанийн нийт хөрөнгө	*	*	*	26.1	35.0	43.4	70.2
Нийт хөрөнгийн өсөлт	0.3	0.2	0.2	0.1	0.2	0.2	0.4
Хураамжийн орлого (тэрбум төгрөг)							
Хураамжийн нийт орлого	78.8	93.9	108.7	114.3	114.5	144.3	178.7
Ердийн даатгалын компаниудын хураамжийн нийт орлого	78.0	92.9	107.3	112.2	111.7	141.2	175.5
Урт хугацааны даатгалын компанийн хураамжийн нийт орлого	0.8	1.0	1.4	1.7	1.3	1.3	1.4
Давхар даатгалын компанийн хураамжийн нийт орлого	*	*	*	0.4	1.6	1.9	1.7
Нөхөн төлбөр (тэрбум төгрөг)							
Нийт нөхөн төлбөр	16.9	26.5	31.5	33.0	34.3	45.2	58.2
Ердийн даатгалын компаниудын нийт нөхөн төлбөр	16.7	26.3	30.9	32.0	33.4	44.3	57.1
Урт хугацааны даатгалын компанийн нийт нөхөн төлбөр	0.2	0.3	0.6	0.9	0.9	0.9	0.6
Давхар даатгалын компанийн нийт нөхөн төлбөр	*	*	*	*	*	*	0.5
Нөөц сан (тэрбум төгрөг)							
Нөөц сан	48.8	60.4	66.1	72.8	93.0	118.1	146.0
Ердийн даатгалын компаниудын нийт нөөц сан	48.2	59.5	64.8	63.8	78.1	96.6	118.1
Урт хугацааны даатгалын компанийн нийт нөөц сан	0.6	0.9	1.3	1.5	1.5	1.6	2.0

Давхар даатгалын компанийн нийт нөөц сан	0.0	0.0	0.0	7.6	13.4	19.9	25.9
Давхар даатгалын хураамж (тэрбум төгрөг)							
Давхар даатгалын хураамж	20.7	26.0	31.6	42.1	37.2	46.6	55.3
Ердийн даатгалын компаниудын давхар даатгалын хураамж	20.6	26.0	31.6	41.9	37.2	45.8	54.5
Урт хугацааны даатгалын компанийн давхар даатгалын хураамж	0.0	0.1	0.0	0.0	0.0	0.0	0.0
Давхар даатгалын компанийн давхар даатгалын хураамж	*	*	*	0.2	*	0.8	0.8
Цэвэр ашиг (тэрбум төгрөг)							
Цэвэр ашиг	5.2	4.7	2.1	6.9	11.4	13.2	18.4
Ердийн даатгалын компаниудын цэвэр ашиг	5.4	4.8	2.0	4.6	8.5	8.7	14.3
Урт хугацааны даатгалын компанийн цэвэр ашиг	(0.1)	(0.1)	0.0	0.2	0.2	0.2	0.1
Давхар даатгалын компанийн цэвэр ашиг	-	-	-	2.1	2.8	4.3	4.1
Цэвэр ашигийн өсөлт	-36.0%	-9.5%	-56.0%	233.8%	64.2%	15.7%	39.7%
Мэргэжлийн оролцогчид (тоо, ширхэг)							
Ердийн даатгал	17	16	16	15	15	15	15
Урт хугацааны даатгал	1	1	1	1	1	1	1
Давхар даатгал	*	*	*	1	1	1	2
Даатгалын төлөөлөгч	2357	3187	3260	3340	3091	2893	2430
Даатгалын зуучлагч	17	20	30	37	40	42	49
Хохирол үнэлэгч	9	14	20	27	31	29	27
Актуарч	18	15	15	15	15	21	28
Аудитор	43	69	84	124	126	130	141
Аудитын компани	16	22	30	40	42	42	43

Хавсралт 3: Банк бус санхүүгийн байгууллагуудын стистик үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Нийт хөрөнгө	252.1	379.7	508.0	623.2	787.2	969.2	1284.9
Эргэлтийн хөрөнгө	242.8	367.2	490.5	600.4	754.3	932.7	1234.7
Мөнгөн хөрөнгө	66.7	113.1	156.0	174.2	243.1	264.1	315.1
Богино хугацаат хөрөнгө оруулалт	2.2	9.9	11.0	11.9	1.3	2.7	1.8
Нийт зээл	157.8	223.7	303.1	391.2	478.2	638.0	869.2
Хэвийн зээл	147.1	205.1	263.1	330.7	392.0	527.0	752.9
Хугацаа хэтэрсэн зээл	4.2	10.1	20.8	22.2	26.7	29.9	33.4
Чанаргүй зээл	6.5	8.5	19.2	38.3	59.5	81.1	75.0
Зээлийн эрсдэлийн сан	4.5	6.4	15.2	26.6	42.1	56.0	64.5
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	0.9	0.8	1.3	2.7	4.5	8.1	10.2
Эргэлтийн бус хөрөнгө	9.3	12.5	17.5	22.8	32.9	36.5	50.2
Нийт өр төлбөр	80.8	146.8	175.9	199.0	208.7	211.0	307.5
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	14.1	19.1	25.7	31.2	30.5	39.2	57.6
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	46.1	90.2	123.6	125.9	121.4	112.8	151.0

Төслийн зээлийн санхүүжилт	8.0	11.9	12.5	15.0	21.4	14.9	17.8
Эзэмшигчдийн өмч	171.3	232.9	332.1	424.2	578.5	758.2	977.4
Хоёрдогч өглөг	1.6	1.6	2.4	1.4	1.0	0.7	1.0
Хувьцаат капитал	139.2	182.3	258.2	308.5	440.5	595.4	740.8
Хуримтлагдсан ашиг	24.2	41.7	64.0	102.0	130.4	155.1	224.6
Банк бус санхүүгийн байгууллагын тоо	212	263	378	450	518	534	539
Үүнээс: УБ хот	188	232	338	400	458	463	466
Хөдөө, орон нутаг	24	31	40	50	60	71	73
Харилцагчдын тоо	594,151	663,098	636,341	449,131	592,461	1,471,099	1,601,749
Нийт орлого	70.5	106.6	132.9	156.1	193.4	195.9	259.5
Хүүгийн орлого	45.7	66.1	89.9	119.8	135.6	161.9	217.4
Хүүгийн бус орлого	23.3	39.3	41.7	33.4	54.4	27.3	33.5
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	1.1	1.1	1.3	3.0	3.5	6.7	8.6
Нийт зардал	51.9	76.8	96.5	109.7	134.4	129.1	158.4
Хүүгийн зардал	6.5	9.6	12.9	14.9	15.4	14.2	20.6
Хүүгийн бус зардал	39.5	58.8	66.7	71.3	88.9	79.3	96.0
Болзошгүй эрсдэлийн зардал	2.3	3.4	11.4	16.4	21.2	24.4	24.0
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	1.0	1.2	1.0	0.9	1.9	2.2	3.9
Цэвэр ашиг	18.6	29.8	36.4	46.4	59.0	66.8	101.1

Хавсралт 4: Хадгаламж, зээлийн хоршоодын статистик үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Нийт хөрөнгө	67.7	73.8	80.5	97.7	113.1	153.1	200.2
Эргэлтийн хөрөнгө	66.1	71.7	78.2	95.2	110.6	149.6	195.9
Мөнгөн хөрөнгө	15.9	20.6	15.0	18.2	24.2	40.0	57.9
Авлага	1.9	1.8	2.0	2.8	3.9	5.4	6.2
Эргэлтийн бус хөрөнгө	1.6	2.1	2.3	2.5	2.5	3.6	4.3
Үндсэн хөрөнгө /цэврээр/	1.6	2.1	2.3	2.5	2.5	3.5	4.2
Биет бус хөрөнгө	0.01	0.01	0.01	0.01	0.01	0.03	0.05
Хөрөнгө оруулалт ба бусад эргэлтийн бус хөрөнгө	0.03	0.03	0.02	0.02	0.02	0.02	0.02
Нийт зээл	48.3	49.4	61.5	75.3	84.4	105.2	133.8
Хэвийн зээл	46.0	46.6	57.8	69.0	73.7	95.7	133.8
Хугацаа хэтэрсэн зээл	1.3	1.2	2.1	2.9	5.2	5.0	4.4
Чанаргүй зээл	1.1	1.5	1.6	3.5	4.6	4.5	6.0
Өр төлбөр	51.3	54.8	60.8	76.1	88.6	123.2	166.7
Хадгаламж	47.1	50.7	55.0	59.3	67.5	99.3	141.5
Богино хугацаат зээл	1.0	0.4	0.7	4.3	3.0	3.9	5.5
Урт хугацаат өр төлбөр	0.5	0.5	3.7	11.2	12.5	12.8	7.6
Бусад богино хугацаат өр төлбөр	2.7	3.2	3.7	4.3	5.0	7.1	12.1
Өөрийн хөрөнгө	16.4	19.0	19.7	21.6	24.5	30.0	33.5
Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	9.4	9.8	10.1	10.6	12.2	14.9	15.3

Хоршоологчдын өмч	6.9	8.7	9.2	10.6	12.1	14.9	18.0
Хуримтлагдсан орлого /алдагдал/	0.0	5.5	5.2	5.5	6.5	7.6	9.9
Нийт орлого	16.6	17.6	18.9	21.8	24.5	31.8	41.2
Хүүгийн орлого	15.4	16.9	18.4	21.0	23.8	30.2	39.6
Үйл ажиллагааны бусад орлого	0.7	0.3	0.3	0.3	0.4	0.7	0.8
Үйл ажиллагааны бус орлого	0.4	0.4	0.3	0.4	0.5	1.0	0.8
Нийт зарлага	12.7	13.5	15.0	18.5	20.6	26.3	35.9
Хүүгийн зардал	8.3	8.9	9.8	11.0	12.5	16.2	23.1
Болзошгүй эрсдэлийн сангийн зардал	0.3	0.6	0.5	1.4	1.4	1.4	2.5
Үйл ажиллагааны зардал	3.0	3.4	4.2	5.6	6.5	8.0	9.5
Үйл ажиллагааны бус зардал	0.6	0.1	0.1	0.1	0.1	0.2	0.3
Нийт ашиг	3.8	4.1	4.0	3.2	3.9	5.5	5.3
ХЗХ-дын тоо	148	141	159	253	280	290	279
ХЗХ-дын тооны өсөлт	-8.6%	-4.7%	12.8%	59.1%	10.7%	3.6%	-3.8%
УБ-ын ХЗХ-дын тоо	64	57	77	166	184	192	176
Орон нутгийн ХЗХ-дын тоо	84	84	82	87	96	98	103
Гишүүдийн тоо /мянга/	26,004	27,245	30,698	39,146	46,183	55,624	62,556
Гишүүдийн тооны өсөлт	-3.3%	4.8%	12.7%	27.5%	18.0%	20.4%	12.5%

